Монгол Улсын Засгийн газар

Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Улаанбаатар хот

2014 он

АГУУЛГА

Зургийн жагсаалт II
Хүснэгтийн жагсаалт III
Хавсралтын жагсаалт V
Товчилсон үгийн жагсаалт VI
1. Монгол Улсын эдийн засгийн 2013 оны төлөв 1
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2
2.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл 2
2.2. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 5
2.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн тухай 6
2.4. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт 7
2.5. Татварын зарлагын гүйцэтгэл 9
2.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэл 16
3. Монгол Улсын төсвийн гүйцэтгэл 18
3.1. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл 18
3.2. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл 22
3.3. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарлагын гүйцэтгэл 23
3.4. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл 36
3.5. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл 37
3.6. Нэмэлт төсвийн гүйцэтгэл 41
4. Хүний хөгжил сангийн төсвийн 2013 оны гүйцэтгэл 42
4.1. Хүний хөгжил сангийн эрсдэлийн удирдлага ба санхүүгийн байдал 42
4.2 Хүний хөгжил сангийн бүрдүүлэлт, зарцуулалт 44
4.3. Хүний хөгжил сангийн удирдлага, зохион байгуулалт 49
5. Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2013 оны гүйцэтгэл 50
5.1. Орлогын гүйцэтгэл 50
5.2. Зарлагын гүйцэтгэл 50
5.3. Төсвийн гүйцэтгэлийн тэнцэл 55
6. Орон нутгийн төсвийн 2013 оны гүйцэтгэл 57
6.1. Орон нутгийн төсвийн орлогын биелэлт 57
6.2. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 58
7. Монгол Улсын Засгийн газрын өр 58
7.1. Засгийн газрын гадаад өрийн тухай 58
7.2. Гадаад өрийн ашиглалт эргэн төлөлтийн талаар 59
7.3. Гадаад зээлийн ашиглалт 61
7.4. УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилт /Чингис бонд/ 77
7.5. УИХ-ын 2011 оны 15 дугаар тогтоолын хэрэгжилт /МУХБ-ны бонд/ 79

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Дотоодын нийт бүтээгдэхүүний динамик 1
Зураг 2. ДНБ-ийн өсөлтийн задаргаа 1
Зураг 5. Төлбөрийн тэнцэл, ГШХО, сая ам.доллар 1
Зураг 7. Нүүрсний экспортийн динамик, сая тонн 4
Зураг 8. Нийт импортын динамик, сая ам.доллар 5
Зураг 10. Нийт худалдан авалтад тендер шалгаруулалтын журмыг хэрэглэсэн байдал 17
Зураг 11. Худалдан авалтын динамик 17
Зураг 12. ТЕЗ нарын худалдан авалт 17
Зураг 13. Улсын хэмжээнд 2013 онд хийгдсэн худалдан авалт, яамдаар 17
Зураг 14. Улсын хэмжээнд 2013 онд хийгдсэн нийт худалдан авалт, аймгуудаар 17
Зураг 15. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл, тэрбум төгрөг 23
Зураг 16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн динамик, тэрбум төгрөг 25
Зураг 17. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын бүтэц 25
Зураг 18. Инженерийн хийцтэй худгийн тоо 26
Зураг 19. Байгаль орчин ногоон хөгжлийн салбарын хөрөнгө оруулалт 31
Зураг 20. Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт 32
Зураг 21. МТШХХГ-ын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг 33
Зураг 22. Батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг 34
Зураг 23. Хууль зүйн салбарын хөрөнгө оруулалт 35
Зураг 24. Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл, тэрбум төгрөг 41
Зураг 25. ХХС-гийн 2013 оны орлогын динамик, сараар, тэрбум төгрөг 43
Зураг 26. ХХС-гийн 2013 оны төсвийн зарлагын динамик, сараар, тэрбум төгрөг 44
Зураг 27. НД-ын байгууллагын урсгал зардлын бүтэц 54

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг 2
Хүснэгт 2. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 4
Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл, тэрбум төгрөг 5
Хүснэгт 4. Төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр, сая төгрөг 7
Хүснэгт 5. Гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний сүүлийн 12 жилийн дундаж үнэ, ам.доллар, тонн 8
Хүснэгт 6. ОУ-ын санхүүгийн байгууллагуудын үнийн төсөөлөл, ам.доллар, тонн 8
Хүснэгт 7. 2013 оны тэнцвэржүүлсэн үнэ 8
Хүснэгт 8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлж буй хуулиуд 9
Хүснэгт 9. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтүүд 10
Хүснэгт 10. Татварын орлого, татварын зарлагын динамик 12
Хүснэгт 11. Татварын зарлагын хэмжээ, сая төгрөг 12
Хүснэгт 12. 2013 оны татварын зарлагын хэмжээ, сая төгрөг 13
Хүснэгт 13. ААНОАТ-ын зарлагын динамик, тэрбум төгрөг 13
Хүснэгт 14. НӨАТ-ын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг 14
Хүснэгт 15. Гаалийн албан татварын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг 14
Хүснэгт 16. ХАОАТ-ын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг 15
Хүснэгт 17. Онцгой албан татварын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг 15
Хүснэгт 18. Татварын зарлага, салбараар, тэрбум төгрөг 16
Хүснэгт 19. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг 18
Хүснэгт 20. Гаалийн байгууллагаас төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг 20
Хүснэгт 21. Зарим барааны импортын хэмжээ 21
Хүснэгт 22. Зарим бараа үйлчилгээний татвараас чөлөөлсөн байдал 22
Хүснэгт 23. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, сая төгрөг 23
Хүснэгт 24. Орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалт, сая төгрөг 29
Хүснэгт 25. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл, хөрөнгийн зориулалтаар, сая төгрөг 37
Хүснэгт 26. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл, тогтоолоор, сая төгрөг 37
Хүснэгт 27. Улсын төсвөөс олгосон зээлийн гүйцэтгэл 39
Хүснэгт 28. Хүний хөгжил сангийн 2013 оны батлагдсан төсөв, сая төгрөг 45
Хүснэгт 29. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн гүйцэтгэл, сая төгрөг 46
Хүснэгт 30. Уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого, тэрбум төгрөг 47
Хүснэгт 31. Уул уурхайн салбарын орлогоос ХХС-д төвлөрсөн орлого, тэрбум төгрөг 47
Хүснэгт 32. Төр хариуцах ЭМД-ын шимтгэл хүртсэн хүний тоо, хөрөнгийн хэмжээ 48
Хүснэгт 33. Бэлэн мөнгөөр хишиг, хувь хүртээсэн байдал, сая төгрөг 49
Хүснэгт 34. НДС-гийн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг 50
Хүснэгт 35. НДС-ын зарлагын гүйцэтгэл, тэрбум төгрөг 50
Хүснэгт 36. Тэтгэвэр авагчийн тоо ба зарцуулсан хөрөнгө, мянган хүн, тэрбум төгрөг 51
Хүснэгт 37. Тэтгэмж авагчийн тоо ба зарцуулсан хөрөнгө, мянган хүн, тэрбум төгрөг 51
Хүснэгт 38. ҮОМШӨ-ний даатгалын зарлага, мянган хүн, тэрбум төгрөг 52
Хүснэгт 39. Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага, мянган хүн, сая төгрөг 52
Хүснэгт 40. ЭМД-ын сангийн зарлага, мянган хүн, тэрбум төгрөг 53
Хүснэгт 41. Цалин хөлс болон НД-ын шимтгэлийн зардал, сая төгрөг 54
Хүснэгт 42. НДС-ын тогтмол зардал, сая төгрөг 54

Хүснэгт 43. Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, сая төгрөг 55
Хүснэгт 44. НДС-ын хөрөнгө оруулалт, сая төгрөг 55
Хүснэгт 45. НДС-ын тэнцэл, тэрбум төгрөг 55
Хүснэгт 46. Орон нутгийн төсвийн гүйцэтгэл, сая төгрөг 57
Хүснэгт 47. Гадаад зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг 58
Хүснэгт 48. Гадаад өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт 59
Хүснэгт 49. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, сая төгрөг 59
Хүснэгт 50. Чингис бондын хүүний төлбөр, сая төгрөг 60
Хүснэгт 51. Гадаад зээлийн ашиглалт, ашиглалт 61
Хүснэгт 52. Ерөнхий сайдын багцын гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 62
Хүснэгт 53. УИХ-ын тамгын газрын гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 62
Хүснэгт 54. Сангийн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 63
Хүснэгт 55. БХБЯ-ны гадаад зээлийн ашиглал, сая төгрөг 66
Хүснэгт 56. БШУЯ-ны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 69
Хүснэгт 57. Зам тээврийн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 70
Хүснэгт 58. ҮХААЯ-ны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 73
Хүснэгт 59. Хуул зүйн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 73
Хүснэгт 60. Эрүүл мэндийн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 74
Хүснэгт 61. Эрчим хүчний яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 75
Хүснэгт 62. Орон нутгийн захиргааны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг 75

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. ОУЗЗ-д арилжаалсан үнэт цаасны хөрөнгө, ЗГ-ын баталгаа гаргасан үнэт цаасны хөрөнгөөр хийгдсэн төслийн гүйцэтгэл 81
Хавсралт 2. Чингис бондын эх үүсвэрээс 2013 онд олгосон санхүүжилтийн мэдээ.....82
Хавсралт 3. Хөгжлийн банкны эх үүсвэрээс олгосон санхүүжилт.....96
Хавсралт 4. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт 100
Хавсралт 5. Монгол Улсын төсвийн үр дүнгийн үзүүлэлт 102
Хавсралт 6. 2013 оны Монгол Улсын төсвийн үр дүнгийн үзүүлэлт 104
Хавсралт 7. 2013 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн үр зарлагын гүйцэтгэл 106
Хавсралт 8. 2013 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл 111
Хавсралт 9. 2013 оны Монгол Улсын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 113
Хавсралт 10. 2013 оны Монгол Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл 114
Хавсралт 11. 2013 оны Монгол Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл 115
Хавсралт 12. 2013 оны Монгол Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл 127
Хавсралт 13. Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 179
Хавсралт 14. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл 204
Хавсралт 15. 2013 оны нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэл 210
Хавсралт 16. 2013 оны орон нутгийн төсвийн орлого, зарлага, татаасын товчоо.....232
Хавсралт 17. Орон нутгийн төсвийн гүйцэтгэл 233
Хавсралт 18. Орон нутгийн төсвийн гүйцэтгэл 239
Хавсралт 19. Хүний хөгжил сангийн төсвийн гүйцэтгэл 292
Хавсралт 20. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл 293
Хавсралт 21. Нийгмийн даатгалын сангийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл 295
Хавсралт 22. ТЕЗ нарын хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнгийн тайлан 298

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБОАТ	Аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АХБ	Азийн хөгжлийн банк
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГАТ	Гаалийн албан татвар
ДБ	Дэлхийн банк
ЗГ	Засгийн газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхим
НББ	Нягтлан бодох бүртгэл
НД	Нийгмийн даатгал
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУ	Олон улс
ОУБ	Олон улсын байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОУЗЗ	Олон улсын зах зээл
ОХУ	Оросын Холбооны Улс
ОН	Орон нутаг
ОССК	Орон сууцны санхүүжилтийн корпораци
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ӨНАМНАТ	Өсөн нэмэгдэх ашигт малтмал ашигласны төлбөр
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЦАУЗБК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс
ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
МУХБ	Монгол Улсын хөгжлийн банк
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хүний хөгжил сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2013 ОНЫ ТӨЛӨВ

Монгол Улсын ДНБ-ий бодит өсөлт 2013 онд 11.7 хувьтай гарч, эдийн засаг чиг хандлагаасаа илүү хурдтай өслөө. Энэхүү өсөлтийн 5.1 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 4.3 нэгж хувийг үйлчилгээний салбар, 2 нэгж хувийг ХАА эзэлсэн ба барилгын салбарт үзүүлж байгаа төрийн дэмжлэг болох орон сууцны 8 хувийн зээл, үнийг тогторжуулах хөтөлбөрийн хүрээнд барилгын салбарт олгож буй дэмжлэг ДНБ өсөлтөд нөлөө үзүүлж байна.

Зураг 1. Дотоодын нийт бүтээгдэхүүний динамик

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, судлаачийн тооцоолол

Зураг 2. ДНБ-ийн өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2013 онд хөрөнгө ба санхүүгийн тэнцэл онд 3.3 тэрбум ам.долларын ашигтай, урсгал тэнцэл 3.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарч нийт тэнцэл 114.6 сая ам доллар ашигтай гарсан байна. Энэ оны төлбөрийн тэнцлийн ашиг нь 2012 онтой харьцуулахад 92.7 хувь буюу 13.7 дахин буурсан байна. 2012 оны төлбөрийн тэнцэл 1.57 тэрбумын ашигтай гарахад Хөгжлийн Банкны болон Засгийн газрын Чингис бонд нөлөөлж байсан юм.

Зураг 3. Төлбөрийн тэнцэл, ГШХО, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

2. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2013 оны гүйцэтгэлээр 5,940.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөний биелэлт 92.8 хувь буюу 459.5 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Харин 2013 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 2012 оны мөн үетэй харьцуулахад 1,076.9 тэрбум төгрөгөөр буюу 22.1 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй гарсан нь олон жилийн дундаж өсөлттэй ойролцоо байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу тогтворжуулалтын санд өнгөрөгч 2013 онд 46.9 тэрбум төгрөгийг төвлөрүүллээ.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг

	ӨӨ-ны мөн үеийн	жилийн Төлөв.	ХУВЬ				ЗӨРҮҮ
			Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	(4 - 3)
	1	2	3	4	5	6	7
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,957.8	6,448.6	6,448.6	5,986.9	92.8	92.8	-461.6
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	94.7	49.0	49.0	46.9	95.7	95.7	-2.1
1. УТ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	23.1	7.6	7.6	7.6	100.0	100.0	0.0
2.УТ - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	18.7	13.3	13.3	10.8	81.7	81.7	-2.4
3. УТ - Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	52.9	28.1	28.1	28.5	101.1	101.1	0.3
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,863.1	6,399.6	6,399.6	5,940.1	92.8	92.8	-459.5
А. УРСГАЛ ОРЛОГО	4,828.0	6,397.5	6,397.5	5,936.7	92.8	92.8	-460.8
I. ТАТВАРЫН ОРЛОГО	4,179.3	5,680.1	5,680.1	5,072.8	89.3	89.3	-607.3
1. Орлогын албан татвар	871.4	1,302.4	1,302.4	1,109.2	85.2	85.2	-193.2
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	524.3	863.8	863.8	660.2	76.4	76.4	-203.6
1.2. Хувь хүний орлогын албан татвар	347.0	438.7	438.7	449.0	102.4	102.4	10.4
1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	650.2	823.6	823.6	874.2	106.1	106.1	50.6
3. Өмчийн татвар	21.9	35.6	35.6	44.0	123.6	123.6	8.4
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1,642.8	2,256.0	2,256.0	1,921.2	85.2	85.2	-334.9
4.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,296.5	1,764.8	1,764.8	1,435.1	81.3	81.3	-329.7
4.2. Онцгой албан татвар	312.4	455.8	455.8	449.4	98.6	98.6	-6.4
4.3. Тусгай зориулалтын орлого	34.0	35.4	35.4	36.7	103.5	103.5	1.3
5. Гадаад худалдааны орлого	327.4	516.6	516.6	381.4	73.8	73.8	-135.2
5.1. Импортын барааны гаалийн албан татвар	327.2	516.4	516.4	381.2	73.8	73.8	-135.2
5.2. Экспортын гаалийн албан татвар	0.2	0.2	0.2	0.2	91.2	91.2	0.0
6. Бусад татвар	665.6	745.8	745.8	742.8	99.6	99.6	-3.0
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	648.7	717.4	717.4	863.9	120.4	120.4	146.5
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	10.4	2.1	2.1	3.4	159.5	159.5	1.3
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	24.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Татварын орлогын гүйцэтгэл 5,072.8 тэрбум төгрөгт хүрч, 89.3 хувийн биелэлттэй байна. Татварын орлого 607.3 тэрбум төгрөгөөр тасарсан нь өнгөрсөн онд нэгдсэн төсвийн орлого тасрахад гол нөлөөг үзүүлсэн байна. Харин татварын бус орлогын гүйцэтгэл 863.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 146.5 тэрбум төгрөгөөр давж, 120.4 хувийн биелэлттэй гарлаа.

Орлогын албан татвар 193.2 тэрбум төгрөг, дотоодын бараа үйлчилгээний татвар 329.7 тэрбум төгрөг, гадаад худалдааны орлого 135.2 тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь нийт татварын орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн байна.

Харин хүү торгуулийн орлого 70.6 тэрбум төгрөг, газрын тосны орлого 25.9 тэрбум төгрөг, төсөвт газрын өөрийн орлого 36.3 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн нь татварын бус орлогын төлөвлөгөө давж биелэхэд гол нөлөөг үзүүлжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 88.0 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 100.6 хувь, хүний хөгжил сангийн орлогын биелэлт 99 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 103.5 хувь байна.

Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 88.0 хувийн биелэлттэй буюу 547.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд дараах гадаад хүчин зүйлээс голчлон хамаарсан байна. Үүнд:

- *Эдийн засгийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй;*
- *Нүүрсний үнийн болон экспортийн тоо хэмжээ бууралт;*
- *Нийт импортын бууралт;*

Эдийн засгийн өсөлт: Манай улсын эдийн засгийн өсөлт уул уурхайн бүтээн байгуулалтын ажил, гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх харьцангуй өндөр үнэ, цаг агаарын таатай нөхцөл байдал зэргээс хамаарч 2011 онд 17.5 хувь, 2012 оны эхний хагас жилийн байдлаар 13.1 хувьд хүрсэн өндөр үзүүлэлттэй байсан тул эдийн засгийн энэхүү өсөлтийг цаашид үргэлжилэхээр тооцон 2013 онд 18.5 хувь байхаар төсөөлж, төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулсан.

Монгол Улсын эдийн засаг 2013 онд төлөвлөсөн хэмжээнээс 6.8 хувиар буурч 11.7 хувьд хүрсэн нь төсөвт төвлөрүүлэх орлогын албан татвар, дотоодын бараа үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлого тасрахад гол нөлөөг үзүүлсэн болно.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын бууралт: Манай улсын нийт экспортын 90 орчим хувь, төсвийн орлогын 20 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт эзэлдэг бөгөөд гадаад зах зээлийн таагүй нөлөөллөөс эдгээр бүтээгдэхүүнээс төсөвт төвлөрөх орлого шууд хамаарч өндөр хэлбэлзэж байна.

Манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолтын хэмжээг 2013 оны төсвийн тодотголд 20.5 сая тонн байхаар төлөвлөсөн боловч 2013 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн мэдээгээр нүүрсний экспорт 18.4 сая тонн болж, төлөвлөсөн хэмжээнээс 2.1 сая тонн дутуу экспортлосон байна.

Америк болон Евро бүсийн эдийн засаг, санхүүгийн тааламжгүй байдал, ялангуяа манай урд хөрш БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурдац саарч гангийн үйлдвэрлэл буурч байгаатай холбогдон дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ, дотоодын компаниудын борлуулалтын үнэ төлөвлөсөн хэмжээнээс нилээд буурсан үзүүлэлттэй байна. Өнгөрсөн оны төсвийн төсөлд нүүрсний үнийг 65.5-131.5 ам.доллар байхаар тооцон тусгасан боловч 2013 оны гүйцэтгэлээр үнэ 50.7-94.3 ам.долларт хэлбэлзэж байсан нь төлөвлөсөн хэмжээнээс даруй 20-30 хувь доогуур байна.

Зураг 4. Нүүрсний экспортийн динамик, сая тонн



Хэдийгээр нүүрс, зэсийн баяжмалаас бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, үнэ төлөвлөсөн хэмжээтэй харьцуулахад багаар буурсан боловч нүүрс, зэсийн баяжмалын экспорт нийт экспортын 50 илүү хувийг бүрдүүлдэг. Харин сүүлийн жилүүдэд нүүрсний экспорт зэсийн экспортоос давсан үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл 2013 онд гол нэр төрлийн эрдэс баялагийн тоо хэмжээ болон үнэ буурсан нь орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.

Өнгөрсөн онд цайрын баяжмалын экспорт 130.8 мянган тонн хүрч, 18.9 мянган тонноор давж биелсэн байна. Харин дэлхийн зах зээл дэх үнэ дээрх ашигт малтмалын бүтээгдэхүүнүүдийн хувьд харьцангуй бага хэлбэлзэлтэй байсан боловч борлуулалтын бодит үнэ буурсан, зардал өссөн зэргээс шалтгаалж ашигт ажиллагаа багассан байна.

Хүснэгт 2. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт

Бүтээгдэхүүн	2012 оны гүйцэтгэл	2013 оны төлөвлөгөө	2013 оны гүйцэтгэл	Зөрүү
Нүүрс /сая тн/	20.9	20.5	18.4	-2.1
Цайрын баяжмал /мян.тн/	140.9	111.7	130.8	18.9
Зэсийн баяжмал /мян.тн/	574.4	694.3	649.8	-44.5
Төмрийн хүдэр /сая тн/	6.4	6.0	6.7	0.7

Нүүрсний экспортын хэмжээ, үнэ буурсан нь нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон тэмдэгтийн хураамжийн орлого буурах нөхцөл болсон байна.

Нийт импортын бууралт: Өнгөрсөн 2013 онд нийт импортын хэмжээ 2012 онтой харьцуулахад 6.2 хувиар буурч, төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын төлөвлөгөө тасрахад шууд нөлөөлсөн байна. Нийт импортын хэмжээг графикаар үзүүлбэл:

Зураг 5. Нийт импортын динамик, сая ам.доллар



Импортын хэмжээ буурснаар импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар 1,117.4 тэрбум төгрөг төвлөрөхөөс 935.9 тэрбум төгрөг төвлөрч 181.5 тэрбум төгрөгөөр, гаалийн албан татвараар 516.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 381.2 тэрбум төгрөг төвлөрч 135.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн хэмжээнээс доогуур гүйцэтгэлтэй гарсан байна. Импортын хэмжээ буурснаас төсвийн орлого 316.5 орчим тэрбум төгрөгөөр тасарсан байна.

2.2. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2013 онд 6,164.7 тэрбум төгрөгт хүрч 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсвийн зарлагад 5,165.6 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 4,683.0 тэрбум төгрөгийн зарлага гарч, 90.7 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл, тэрбум төгрөг

	1. НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	ХУВЬ				ЗӨРҮҮ
			Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	(4 - 3)
	1	2	3	4	5	6	7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**5,993.8**	**6,886.7**	**6,886.7**	**6,164.7**	**89.5**	**89.5**	**-722.0**
УРСГАЛ ЗАРДАЛ	**4,404.1**	**4,841.8**	**4,841.8**	**4,557.0**	**94.1**	**94.1**	**-284.8**
1. Бараа, үйлчилгээний зардал	**2,052.4**	**2,567.2**	**2,567.2**	**2,395.6**	**93.3**	**93.3**	**-171.6**
1.1. Цалин хөлс	1,197.2	1,419.7	1,419.7	1,401.5	98.7	98.7	-18.2
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	112.8	135.8	135.8	132.4	97.5	97.5	-3.3
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	855.3	1,147.5	1,147.5	994.1	86.6	86.6	-153.4
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**125.9**	**313.8**	**313.8**	**270.4**	**86.2**	**86.2**	**-43.4**
3. Татаас ба шилжүүлэг	**2,225.8**	**1,960.8**	**1,960.8**	**1,891.0**	**96.4**	**96.4**	**-69.8**
3.1. Татаас	127.0	192.2	192.2	175.8	91.5	91.5	-16.3
3.2. Орон нутгийн төсөвт өгөх санхүүгийн дэмжлэг					0.0	0.0	0.0
3.3. Төсөв хоорондын урсгал шилжүүлэг	19.5	24.1	24.1	21.3	88.2	88.2	-2.8
3.4. Бусад урсгал шилжүүлгүүд	1,815.7	1,530.4	1,530.4	1,601.2	104.6	104.6	70.8
3.5. бусад шилжүүлэг	260.8	208.4	208.4	88.3	42.4	42.4	-120.1
3.6. Гадаад шилжүүлэг	2.8	5.6	5.6	4.3	76.6	76.6	-1.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**1,525.4**	**1,955.2**	**1,955.2**	**1,486.3**	**76.0**	**76.0**	**-468.9**
1.1. Дотоод эх үүсвэрээр:	1,427.9	1,752.1	1,752.1	1,232.2	70.3	70.3	-519.9
1.2. Гадаад эх үүсвэрээр	97.5	203.1	203.1	254.1	125.1	125.1	51.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	**64.3**	**89.7**	**89.7**	**121.3**	**135.3**	**135.3**	**31.7**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН УРСГАЛ ТЭНЦЭЛ	**423.9**	**1,555.7**	**1,555.7**	**1,364.8**	**87.7**	**87.7**	**-190.8**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	**-1,130.7**	**-487.1**	**-487.1**	**-239.4**	**49.2**	**49.2**	**247.6**

Улсын төсвийн халамжийн сангаас алдар цолтой ахмад дайчдын тэтгэмжид 5.8 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд 30.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон

байна. Хотын нийтийн тээврийн татаас 53.3 тэрбум, эрчим хүч, дулааны алдагдлын татаас 32.7 тэрбум, улаан буудай, махны татаас 24.2 тэрбум, засгийн газрын нөөц хөрөнгийн зардал 19.8 тэрбум, их дээд сургууль коллежийн оюутны тэтгэлэг 105.7 тэрбум, хөрөнгийн зардал 1,069.6 тэрбум төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна. Улсын төсвөөс 155.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 784.0 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 187.5 тэрбум төгрөгийн ОН-ийн хөгжлийн сангийн шилжүүлгийг тус тус орон нутагт олгосон байна.

Орон нутгийн төсвийн зарлага 1,794.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 87.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгаас улсын төсөвт 24.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүний хөгжил сангийн зарлага 278.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 229.0 тэрбум, иргэн бүрт олгох 21000 төгрөгийн санхүүжилтээр 28.6 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 99.1 хувийн буюу 1,058.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 89.7 тэрбум төгрөгийг татаасыг олгосон байна.

2.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн тухай

2013 онд нэгдсэн төсвийн нийт тэнцлийг -487.1 тэрбум төгрөгөөр төлөвлөж байсан ба эцсийн гүйцэтгэлээр -224.6 тэрбум төгрөг болж ДНБ-ний 1.3 хувьтай тэнцэж байна.

Улсын төсвийн нийт тэнцэл -672.6 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 107.5 тэрбум төгрөг, ХХС-ийн төсвийн нийт тэнцэл 115.2 тэрбум төгрөг, НДС-ын төсвийн нийт тэнцэл 225.3 тэрбум төгрөг байна.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2,597.9 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсан[1] ба мөн 321.1 тэрбум төгрөгийн Засгийн газрын зээл авсан байна. Эдгээр эх үүсвэрүүдээс ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 1,558.1 тэрбум төгрөгийг зарцуулсан бол ЗГ-ын гадаад зээлийн эргэн төлөлтөд 98.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Нэгдсэн төсвийн хүрээнд тайлант хугацаанд харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 961.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх хүрээнд 2,542.2 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсан бөгөөд ЗГҮЦ-ны үндсэн төлбөрт 1,450.3 тэрбум төгрөгийг эргүүлэн төлсөн байна. Иймд улсын төсвийн алдагдалд ЗГҮЦ-ны 1,091.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг авч ашигласан байна. Харин улсын төсвийн хүрээнд ЗГ-ын гадаад төсвийн зээлийн 321.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хамруулсан ба улсын төсвөөс ЗГ-ын гадаад зээлийн үндсэн төлбөрт 98.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Иймд улсын төсвийн алдагдалд ЗГ-ын гадаад зээлийн 222.7 тэрбум төгрөгийн зээлийг төслүүдийн

[1] 2013 онд гаргасан нийт ЗГҮЦ-ны 42 хувь буюу 1.1 их наяд төгрөг нь урт хугацаат бонд байсан бол үлдсэн нь богино хугацаат бонд байна.

үйл ажиллагаанд зарцуулсан байна. Тайлант хугацаанд улсын төсвийн харилцах болох хадгаламжийн дансны үлдэгдэл 641.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр, сая төгрөг

	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		Хүний хөгжил сан		Нийгмийн даатгалын сан	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН УРСГАЛ ТЭНЦЭЛ	**1,560,449.6**	**1,384,066.3**	**743,776.5**	**412,559.6**	**-744,862.8**	**-613,984.8**	**114,781.3**	**115,195.4**	**-90,886.4**	**-34,044.1**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	**-487,066.9**	**-224,618.7**	**-608,115.3**	**-672,639.6**	**-166,039.7**	**107,549.2**	**114,781.3**	**115,195.4**	**172,306.8**	**225,276.3**
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	487,066.9	224,618.7	608,115.3	672,639.6	166,039.7	-107,549.2	-114,781.3	-115,195.4	-172,306.8	-225,276.3
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-478,799.9	-960,995.9	-472,532.8	-641,941.7	166,039.7	-107,549.2	0.0	13,771.4	-172,306.8	-225,276.3
3. ЗГ-ын бонд	817,615.7	1,039,436.9	870,000.0	1,091,863.5	0.0	0.0	-52,384.3	-52,426.6	0.0	0.0
3.1. Урт хугацаат	797,244.8	983,486.1	849,629.1	1,035,912.7	0.0	0.0	-52,384.3	-52,426.6	0.0	0.0
3.1.1. Дотоод	797,244.8	983,486.1	849,629.1	1,035,912.7	0.0	0.0	-52,384.3	-52,426.6	0.0	0.0
3.1.1.1. Шинээр гаргах	1,141,415.7	1,091,586.1	1,085,700.0	1,035,912.7	0.0	0.0	55,715.7	55,673.4	0.0	0.0
3.1.1.2. Үндсэн төлбөр	-344,170.9	-108,100.0	-236,070.9	0.0	0.0	0.0	-108,100.0	-108,100.0	0.0	0.0
3.2. Богино хугацаат	20,370.9	55,950.8	20,370.9	55,950.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1. Дотоод	20,370.9	55,950.8	20,370.9	55,950.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.1. Шинээр гаргах	1,471,000.0	1,506,269.4	1,471,000.0	1,506,269.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.2. Үндсэн төлбөр	-1,450,629.1	-1,450,318.6	-1,450,629.1	-1,450,318.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. ЗГ-ын зээл	210,648.0	222,717.8	210,648.0	222,717.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1. Дотоод	-2,684.0	-3,753.0	-2,684.0	-3,753.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1. Монголбанк (ОУВС)	-2,684.0	-3,753.0	-2,684.0	-3,753.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1.1. Шинээр гаргах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1.2. Үндсэн төлбөр	-2,684.0	-3,753.0	-2,684.0	-3,753.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2. Гадаад	213,332.0	226,470.8	213,332.0	226,470.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1. Төслийн зээл	213,332.0	226,470.8	213,332.0	226,470.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.1. Шинээр авах	298,080.8	321,102.0	298,080.8	321,102.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.2. Үндсэн төлбөр	-84,748.8	-94,631.2	-84,748.8	-94,631.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
6. Урьдчилгаа орлогоос орлогод тооцогдсон	-62,397.0	-76,540.2	0.0	0.0	0.0	0.0	-62,397.0	-76,540.2	0.0	0.0

Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл 2013 онд ашигтай гарсан бөгөөд уг төсвийн хүрээнд 55.7 тэрбум төгрөгийн ЗГ-ын бонд арилжаалж, бондын эргэн төлөлтөд 108.1 тэрбум төгрөгийг төлсөн байна. Мөн 76.5 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөрийн орлогод тооцсон байна. Ийнхүү ХХС-ийн төсвийн хувьд харилцах болох хадгаламжийн дансны үлдэгдэл 13.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсөв болон НДС-ийн төсөв нь ашигтай гарсан ба харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл нь төсвийн ашгийн дүнгээр нэмэгдсэн байна (Хүснэгт 4-ийг харах).

2.4. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн тогтортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу 2013 оны нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх зэс, нүүрсийг гол нэр төрлийн эрдэс баялгаар тодорхойлон эдгээр баялгаас төсөвт төвлөрөх орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцож, түүнээс давсан хэсэг буюу нийт 48.9 тэрбум төгрөгийг Тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцсон юм.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялаг зэс, нүүрсний 2013 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон Улсын Валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 12 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараахь 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон.

Хүснэгт 5. Гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний сүүлийн 12 жилийн дундаж үнэ, ам.доллар, тонн

Он	Зэс	Боловсруулсан нүүрс	Коксжих нүүрс (ккал 5500-с дээш)	Чулуун нүүрс (4000-5500)
2000	1,814.5	43.0	38.7	21.5
2001	1,580.2	53.4	41.7	23.2
2002	1,560.3	43.9	46.4	25.8
2003	1,779.4	46.4	49.3	27.4
2004	2,863.5	92.1	57.0	31.7
2005	3,676.5	81.7	55.4	50.0
2006	6,731.4	85.3	58.5	51.2
2007	7,131.6	112.4	66.3	55.0
2008	6,963.5	217.2	103.2	84.0
2009	5,165.3	121.6	86.3	69.8
2010	7,538.4	168.3	109.2	94.4
2011	8,800.6	183.8	105.4	85.5
Дундаж	**4,633.8**	**104.1**	**68.1**	**51.6**

Хүснэгт 6. ОУ-ын санхүүгийн байгууллагуудын үнийн төсөөлөл, ам.доллар, тонн

Он	Зэс	Боловсруулсан нүүрс	Коксжих нүүрс (ккал 5500-с дээш)	Чулуун нүүрс (4000-5500 ккал)
2012	7,970.1	163.6	86.0	74.17
2013	8,152.0	161.2	96.7	83.17
2014	8,180.0	157.0	94.2	81.01
2015	7,795.6	153.8	92.3	79.36
Дундаж	**8,024.0**	**158.9**	**92.3**	**79.4**

Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасны зарчмын дагуу олон улсад нийтлэг хэрэглэгддэг Блүүмбэрг[2] мэдээллийн эх сурвалжуудаас авч ашиглаж 2013 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийн 6,328.9 ам.доллар, боловсруулсан нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 131.5 ам.доллар байхаар тооцсон.

Хүснэгт 7. 2013 оны тэнцвэржүүлсэн үнэ

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс	6,328.9	7,389.0	1,060.1
Боловсруулсан нүүрс	131.5	98.5	(33.0)
Коксжих нүүрс (ккал 5500-с дээш)	80.2	65.9	(14.3)
Чулуун нүүрс (4000-5500ккал)	65.5	53.0	(12.5)

Улмаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу төсвийн тогтвортой байдлыг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон орлогоор хуримтлал үүсгэх зорилгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцож, гол нэрийн эрдэс баялгийн зах зээлийн үнэ болон тэнцвэржүүлсэн үнийн зөрүүгээс нийт 48.9 тэрбум төгрөгийн орлого Төсвийн тогтворжуулалтын санд

[2] bloomberg

хуримтлуулахаар төлөвлөснөөс 46.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 95.7 хувиар биелжээ.

БНХАУ-ын эдийн засгийн хурд саарч, манай улсаас импортлон авах нүүрсний хэрэглээ багассаны улмаас гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн нүүрсний үнэ 2013 онд төлөвлөсөн хэмжээнээс 20 орчим хувиар буурч, тэнцвэржүүлсэн үнээс бага түвшинд хүрсэн нь Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого буурахад нөлөөлжээ.

2.5. Татварын зарлагын гүйцэтгэл

Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зөвхөн хуулиар ногдуулдаг. Батлагдсан 251 төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтуудыг тусгагдсан хуулийн нэр, төрлөөр дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлж буй хуулиуд

№	Хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан хуулиуд	Чөлөөлөлт /заалтын тоо/	Хөнгөлөлт /заалтын тоо/	Нийт хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтын тоо
1	ААНОАТ-ын тухай	13	8	21
2	НӨАТ-ын тухай хууль	36	0	36
3	НӨАТ-аас чөлөөлөх тухай	19	0	19
4	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай (шинэчилсэн найруулга)	11	7	18
5	Бууны албан татварын тухай	4	0	4
6	Гаалийн тариф, гаалийн татварын тухай	13	0	13
7	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	20	0	20
8	Газрын төлбөрийн тухай	11	1	12
9	“Мянганы зам” төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлөх тухай	1	0	1
10	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай	32	2	34
11	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай	4	3	7
12	ХХОАТ-ын тухай хууль	16	8	24
13	Чөлөөт бүсийн тухай	7	0	7
14	“Цагааннуур” худалдааны чөлөөт бусийн эрх зүйн байдлын тухай	2	5	7
15	"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай	2	5	7
16	Онцгой албан татварын тухай	7	0	7
17	Хөрөнгө оруулалтын тухай	4	0	4
18	Агаарын бохирдлын төлбөрийн тухай	4	1	5
19	Ус бохирдуулсны төлбөрийн	3	1	4

	тухай			
20	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай	1	0	1
	Нийт	**210**	**41**	**251**

Дараах хүснэгтээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой 2013 онд гарсан өөрчлөлтүүдийг харууллаа.

Хүснэгт 9. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтүүд

Хууль	Заалт	Статус	Тайлбар
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	"Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбоотой үйл ажиллагаанд зориулан импортолсон техник, тоног төхөөрөмж, материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш"-ийг албан татвараас чөлөөлнө.	Хүчингүй болсон.	2012 оны 10 сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болгож 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна.
Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	"Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл"-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2012 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл чөлөөлнө. 2009.07.16.	Хүчингүй болсон.	2012 оны 10 сарын 25-ны өдрийн хуулиар нэг жилээр сунгаж 2013 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдсөн.
	“Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, бөөрөнхий мод, гуалин, модон зүсмэл материал, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц”-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. 2013.06.07.	Шинээр нэмэгдсэн	2013.06.07-ны өдрөөс 2017.12.31-ний өдрийг хүртэл мөрдөгдөнө.
	“Газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материал”-ыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. 2013.06.07.	Шинээр нэмэгдсэн.	2013.06.07-ны өдрөөс 2018.12.31-ний өдрийг хүртэл мөрдөгдөнө.
	“Үйлдвэрлэснээс хойш нэг хүртэл жилийн насжилттай, шинэ троллейбус,	Шинээр нэмэгдсэн	2014.01.01-ний өдрөөс 2016.12.31-

	нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан, 24 буюу түүнээс дээш суудалтай, 45 буюу түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэснээс хойш нэг хүртэл жилийн насжилттай, шинэ автобусыг импортоор оруулах”-д нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. 2013.06.07.	.	ний өдрийг хүртэл мөрдөгдөнө.
Гаалийн тариф, гаалийн татварын тухай	38.1.8. "газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тос хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаанд зориулан импортлосон техник, тоног төхөөрөмж, материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш"-ийг албан татвараас чөлөөлнө.	Хүчингүй болсон.	2012 оны 10 сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болгож 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна.
Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	"Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл"-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2012 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл чөлөөлнө. 2009.07.16.	Хүчингүй болсон.	2012 оны 10 сарын 25-ны өдрийн хуулиар нэг жилээр сунгаж 2013 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдсөн.
	“Газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материал”-ыг гаалийн албан татвараас чөлөөлнө. 2013.06.07.	Шинээр нэмэгдсэн.	2013.06.07-ны өдрөөс 2018.12.31-ний өдрийг хүртэл мөрдөгдөнө.
	“Импортоор оруулж байгаа /4410.12/ тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц”-ийг гаалийн албан татвараас чөлөөлнө. 2013.06.07	Шинээр нэмэгдсэн.	2013.06.07-ны өдрөөс 2017.12.31-ний өдрийг хүртэл мөрдөгдөнө.
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай	18.1.1. "Засгийн газрын болон Монгол Улсын хөгжлийн банкны өрийн бичгийн /бонд/ хүү"-г албан татвараас чөлөөлнө.	Өөрчлөлт орсон.	“Засгийн газрын” гэдгийг “Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын” гэж өөрчилсөн бөгөөд 2014 оны 1 дүгээр сарын 1-ний

			өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.
	18.1.10. "Хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлого"-ыг албан татвараас чөлөөлнө.	Шинээр нэмэгдсэн.	2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэмж оруулсан.
	18.1.11.хөрөнгө оруулалтын сангийн орлого;	Шинээр нэмэгдсэн.	2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр нэмээд 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.
	18.1.12.хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлсний орлого.	Шинээр нэмэгдсэн.	2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр нэмээд 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.
Хувь хүний орлогын албан татварын тухай	16.1.5. "Засгийн газрын болон Монгол Улсын хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз"-г албан татвараас чөлөөлнө.	Өөрчлөлт орсон.	“Засгийн газрын” гэдгийг “Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын” гэж өөрчилсөн бөгөөд 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2011 онд 336.4 тэрбум төгрөг буюу татварын орлогын 9.2 хувь, 2012 онд 474.8 тэрбум төгрөг буюу татварын орлогын 11.3 хувьтай тэнцэж байсан байна. 2013 онд татварын хөнгөлөлт чөлөөлөлт 505.4 тэрбум төгрөг буюу татварын орлогын 10 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 10. Татварын орлого, татварын зарлагын динамик

Үзүүлэлт	2010	2011	2012	2013
Татварын орлого, тэрбум төг	2,688.2	3,636.9	4,203.3	5,057.3
Татварын зарлагын хэмжээ, тэрбум төг	198.8	336.4	474.8	505.4
Татварын зарлагын татварын орлогод эзлэх хувь	7.4%	9.2%	11.3%	10.0%

Дараах хүснэгтээр татварын зарлагын 2010-2013 оны дүнг хууль тус бүрээр харууллаа.

Хүснэгт 11. Татварын зарлагын хэмжээ, сая төгрөг

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он
НИЙТ	198,772.3	336,359.0	474,776.1	505,390.4
ААНОАТ-ын тухай хууль	10,224.3	16,231.0	23,475.0	21,521.7
Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь	5.1%	4.8%	4.9%	4.3%

НӨАТ-ын тухай хууль	162,801.2	236,413.8	334,739.7	346,293.8
Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь	81.9%	70.3%	70.5%	68.5%
ГАТ-аас чөлөөлөх тухай	13,822.5	23,950.8	39,446.7	33,998.7
Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь	7.0%	7.1%	8.3%	6.7%
ХХОАТ-ын тухай хууль	9,441.1	51,281.8	55,633.7	74,854.9
Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь	4.7%	15.2%	11.7%	14.8%
Онцгой албан татварын тухай	2,483.1	8,481.6	21,481.0	28,721.3
Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь	1.2%	2.5%	4.5%	5.7%

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 2013 оны дүнг татварын хууль тус бүрээр авч үзвэл, хамгийн өндөр буюу 68.5 хувь нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хүрээнд, 6.7 хувь нь гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хүрээнд, 4.3 хувь нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд, 14.8 хувь нь хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд, 5.7 хувь нь онцгой албан татварын тухай хуулийн хүрээнд ногдож байна.

Дараах хүснэгтээр 2013 оны татварын зарлагыг татварын чөлөөлөлт, хөнгөлөлтөөр ангилан харууллаа.

Хүснэгт 12. 2013 оны татварын зарлагын хэмжээ, сая төгрөг

Үзүүлэлт	Чөлөөлөлт	Бүтэц	Хөнгөлөлт	Бүтэц
ААНОАТ-ын тухай хууль	20,194.2	4.4%	1,327.5	3.0%
НӨАТ-ын тухай хууль	346,293.8	75.2%	-	-
ГАТ-аас чөлөөлөх тухай	33,998.7	7.4%	-	-
ХХОАТ-ын тухай хууль	31,273.8	6.8%	43,581.1	97.0%
Онцгой албан татварын тухай	28,721.3	6.2%	-	-
Нийт	**460,481.8**	**100.0**	**44,908.6**	**100.0**

2013 онд үзүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 91 хувь нь татварын чөлөөлөлт, 9 хувь нь татварын хөнгөлөлт байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээнд 2013 онд 21.5 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлсөн байна.

Хүснэгт 13. ААНОАТ-ын зарлагын динамик, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он
Татварын зарлагын хэмжээ	10.2	16.2	23.5	21.5
Үүнээс: Чөлөөлөлт	5.5	8.0	11.4	20.2
Хөнгөлөлт	4.7	8.2	12.0	1.3

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтуудын ихэнх нь жижиг дунд бизнесийг дэмжих, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зориулалттай байна. Зардлаар нь авч үзвэл газрын тосны салбарт

гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих болон тогтвортой байдлын гэрээний дагуу татвараас хөнгөлж, чөлөөлсөн дүн хамгийн өндөр байна.

2013 оны байдлаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд татвараас чөлөөлөх тухай 3 заалтыг шинээр нэмж оруулаад байна. Тухайлбал, хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлогыг тус татвараас чөлөөлөхөөр 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр хуульд нэмж оруулсан бөгөөд жилийн эцсээр 136.6 сая төгрөгийн татварын чөлөөлөлтийг үзүүлээд байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээнд 2013 онд 346.3 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлсөн байна.

Хүснэгт 14. НӨАТ-ын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он
Татварын зарлагын хэмжээ	162.8	236.4	334.7	346.3
Үүнээс: Чөлөөлөлт	162.8	236.4	334.7	346.3
Хөнгөлөлт	-	-	-	-

Газрын тос хайх, олборлох, ашиглах үйл ажиллагааны зориулалтаар импортолсон бараа бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөх заалтыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосон. Тэгвэл 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 3 хууль батлагдсанаас ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг дэмжих, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, барилгын салбарыг дэмжих хуулиуд нь гарсан өдрөөсөө эхлэн хэрэгжиж эхэлсэн.

Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг дэмжиж НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль болон 2013 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 230-р тогтоолоор батлагдсан жагсаалтыг үндэслэн 2013 онд импортоор орж ирэх бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, хориглосноос бусад мод сөөгний үр тарьц, суулгац, тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн угсарахад бэлэн модон барилгын угсармал хийцийн 16.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий барааг импортолж, үүнээс 1.6 тэрбум төгрөгийн татварын чөлөөлөлт үзүүлсэн байна.

Гаалийн албан татвар

Гаалийн албан татварын тухай хуулийн дагуу үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээнд 2013 онд 34.0 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлсөн байна.

Хүснэгт 15. Гаалийн албан татварын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он
Татварын зарлагын хэмжээ	13.8	24.0	39.4	34.0
Үүнээс: Чөлөөлөлт	13.8	24.0	39.4	34.0
Хөнгөлөлт	-	-	-	-

Тэгвэл 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хоёр хууль батлагдан мөрдөгдөж эхэлсэн. Тэдгээр нь газрын тосны нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, барилгын салбарыг дэмжих зориулалттай байна.

Барилгын салбарыг дэмжиж НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль болон 2013 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 230-р тогтоолоор батлагдсан жагсаалтыг үндэслэн 2013 онд импортоор орж ирэх тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн угсарахад бэлэн модон барилгын угсармал хийцийн 16.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий барааг импортолж, үүнээс 0.9 тэрбум төгрөгийн татварын чөлөөлөлт үзүүлсэн байна.

Хувь хүний орлогын албан татвар

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээнд 2013 онд 74.8 тэрбум төгрөгийг татвараас хөнгөлж, чөлөөлсөн байна.

Хүснэгт 16. ХАОАТ-ын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он
Татварын зарлагын хэмжээ	9.4	51.3	55.6	74.9
Үүнээс: Чөлөөлөлт	7.5	15.4	15.6	31.3
Хөнгөлөлт	2.0	35.9	40.0	43.6

Зардлын дийлэнх нь иргэдийн анх удаа хувьдаа орон сууц барих, худалдан авахад зарцуулсан тодорхой хэмжээний хөрөнгийн орлогыг татвараас чөлөөлөх зардал эзэлж байна.

Онцгой албан татвар

Онцгой албан татварын тухай хуулийн дагуу үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээнд 2013 онд 28.7 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлсөн байна.

Хүснэгт 17. Онцгой албан татварын зарлагын хэмжээ, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он
Татварын зарлагын хэмжээ	2.5	8.5	21.5	28.7
Үүнээс: Чөлөөлөлт	2.5	8.5	21.5	28.7
Хөнгөлөлт	-	-	-	-

Онцгой албан татвараас чөлөөлөх заалтууд нь ихэвчлэн хүний эрүүл мэндийг хамгаалах зориулалттай байна.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2011 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 103 дугаар тушаалд заасан салбарын ангиллын дагуу татварын зарлагын хэмжээг ангилан дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 18. Татварын зарлага, салбараар, тэрбум төгрөг

Салбарын ангилал	2013 он	Бүтэц, %
Хөдөө аж ахуй	27.3	5.4
Уул уурхай олборлолт	161.5	32.0
Боловсруулах үйлдвэрлэл	29.9	5.9
Бөөний болон жижиглэн худалдаа	0.4	0.1
Барилга	2.5	0.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	39.0	7.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	54.0	10.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	6.5	1.3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа албан журмын нийгмийн хамгаалал	8.6	1.7
Боловсрол	6.8	1.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	56.5	11.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.0	0.0
ОУБ, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	8.7	1.7
Бусад	103.6	20.5
Нийт	**505.3**	**100.0**

2013 оны гүйцэтгэлээр 505.3 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлсний 32 хувь буюу 161.5 тэрбум төгрөгийг уул уурхайн салбарт олгосон байна.

2.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2013 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 1,663.7 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс 72.9 хувь буюу 1,212.6 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 5.9 хувь буюу 98.1 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, 0.5 хувь буюу 8.1 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын арга, 1.1 хувь буюу 17.9 тэрбум төгрөгийн шууд худалдан авах аргаар, 19.6 хувь буюу 344.8 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлсэн байна. Тайлант хугацаанд нийт 1722 нээлттэй тендер шалгаруулалт, 2978 харьцуулалтын арга, 352 шууд гэрээ байгуулах арга, 2882 шууд худалдан авах арга /төсөвт өртөг 10 сая төгрөгөөс доош/, 110 хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Зураг 6. Нийт худалдан авалтад тендер шалгаруулалтын журмыг хэрэглэсэн байдал



Зураг 7. Худалдан авалтын динамик



Зураг 8. ТЕЗ нарын худалдан авалт



Зураг 9. Улсын хэмжээнд 2013 онд хийгдсэн худалдан авалт, яамдаар



Зураг 10. Улсын хэмжээнд 2013 онд хийгдсэн нийт худалдан авалт, аймгуудаар



3. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2013 онд 4,010.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөний биелэлт 88.0 хувь буюу 547.1 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Харин 2013 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 2012 оны мөн үетэй харьцуулахад 622.7 тэрбум төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй гарсан нь олон жилийн дундаж өсөлттэй ойролцоо байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 82.6 хувийн биелэлттэй буюу 674.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь өнгөрсөн онд нэгдсэн төсвийн орлого тасрахад гол нөлөөг үзүүлсэн бол татварын бус орлого 127.8 тэрбум төгрөгөөр давж, 122.4 хувийн биелэлттэй гарлаа.

Орлогын албан татвар 203.6 тэрбум төгрөг, дотоодын бараа үйлчилгээний татвар 335.8 тэрбум төгрөг, гадаад худалдааны орлого 135.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн хэмжээнээс дутуу төвлөрсөн нь нийт татварын орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн байна.

Хүснэгт 19. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг

	ӨӨ-ны мөн үеийн	жилийн Төлөв.	ХУВЬ				ЗӨРҮҮ
			Төлөв.	Гүйцэт.	(11 : 10)	(11 : 9)	(11 -10)
	8	9	10	11	12	13	14
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,482.4	4,606.4	4,606.4	4,057.3	88.1	88.1	-549.2
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	94.7	49.0	49.0	46.9	95.7	95.7	-2.1
1. УТ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	23.1	7.6	7.6	7.6	100.0	100.0	0.0
2.УТ - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	18.7	13.3	13.3	10.8	81.7	81.7	-2.4
3. УТ - Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	52.9	28.1	28.1	28.5	101.1	101.1	0.3
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,387.7	4,557.5	4,557.5	4,010.4	88.0	88.0	-547.1
А. УРСГАЛ ОРЛОГО	3,036.2	4,443.0	4,443.0	3,896.4	87.7	87.7	-546.6
I. ТАТВАРЫН ОРЛОГО	2,585.6	3,871.3	3,871.3	3,196.9	82.6	82.6	-674.4
1. Орлогын албан татвар	524.4	863.8	863.8	660.2	76.4	76.4	-203.6
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	524.3	863.8	863.8	660.2	76.4	76.4	-203.6
1.2. Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3. Өмчийн татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1,619.6	2,231.2	2,231.2	1,895.4	84.9	84.9	-335.8
4.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,296.5	1,764.8	1,764.8	1,435.1	81.3	81.3	-329.7
4.2. Онцгой албан татвар	312.4	455.8	455.8	449.4	98.6	98.6	-6.4
4.3. Тусгай зориулалтын орлого	10.8	10.6	10.6	10.9	102.7	102.7	0.3
5. Гадаад худалдааны орлого	327.4	516.6	516.6	381.4	73.8	73.8	-135.2
5.1. Импортын барааны гаалийн албан татвар	327.2	516.4	516.4	381.2	73.8	73.8	-135.2
5.2. Экспортын гаалийн албан татвар	0.2	0.2	0.2	0.2	91.2	91.2	0.0
6. Бусад татвар	114.2	259.7	259.7	259.9	100.1	100.1	0.2
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	450.6	571.8	571.8	699.6	122.4	122.4	127.8
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	351.5	114.4	114.4	114.0	99.6	99.6	-0.5

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Улсын төсөвт 863.7 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 660.2 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 203.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 135.8 тэрбум төгрөгөөр буюу 25.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

ААНОАТ-ын бууралт нь экспортод гаргасан эрдэс баялгийн бүтээгдхүүний дэлхийн зах зээлийн үнэ, үйлдвэрлэлийн болон экспортын хэмжээ буурсантай холбоотой байна.

Томоохон аж ахуй нэгжүүдийн ААНОАТ-ын тайлангийн нэгтгэлээс харахад уул уурхайн олборлох үйлдвэрлэл, согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэл, харилцаа холбооны салбарын борлуулалтын орлого буурч, татвар ногдох орлогоос хасагдах зардалын хэмжээ өссөн байна.

Дотоодын бараа, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар

Улсын төсөвт 724.1 тэрбум төгрөгийн татварын орлогын төлөвлөгөөтэй ажилласнаас 574.4 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 149.7 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Монгол Улсын эдийн засаг 2013 он төлөвлөсөн хэмжээнээс 6.8 хувиар буурч 11.7 хувьд хүрсэн нь төсөвт төвлөрүүлэх дотоодын бараа үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлого тасрахад гол нөлөөг үзүүлсэн болно.

Дотоодын барааны онцгой албан татвар

Улсын төсөвт 2013 онд онцгой албан татварын орлогоор 198.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 209.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 105.5 хувиар биелүүлсэн байна. Татварын нэр төрлөөр авч үзвэл дотоодын архи, дарс, спиртийн онцгой албан татварын төлөвлөгөө 18.1 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар давж, тамхины онцгой албан татварын төлөвлөгөө 7.2 тэрбум төгрөг буюу 15.4 хувиар пивоны онцгой албан татварын төлөвлөгөө 0.4 тэрбум төгрөг буюу 0.2 хувиар тус тус тасарсан байна

УИХ-ын 2012 оны 9 сарын 11-д баталсан “Онцгой албан татварын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар 40 хүртэл хатуулагтай архинд ногдох онцгой албан татвар 1 литр тутамд 2 доллар ногдуулж байсныг 4.0 доллар, 40-өөс дээш хатуулагтай архинд ногдох онцгой албан татвар 1 литр тутуамд 4.5 доллар ногдуулж байсныг 9.0 доллар, тамхинд ногдох онцгой албан татвар 1.2 доллар байсныг 2.4 доллар болгон тус тус нэмэгдүүлсэн, 2012 онд төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 1359.2 доллар байсан бол 2013 оны байдлаар 1523.9 доллар болж өссөн нь онцгой албан татварын ногдуулалт өсөхөд нөлөөлсөн байна.

Согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвартай бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад архи, дарс, спирт 1.0 сая литр буюу 2.9 хувиар өссөн, пиво 2.0 сая литр буюу 3.3 хувиар, тамхи 281.9 сая ширхэг буюу 20.3 хувиар тус тус буурсан байна.

Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 152 тоот тогтоолоор 25 аж ахуйн нэгж, 2013 оны 140 тоот тогтоолоор 10 аж ахуйн нэгж, 2013 оны 209 тоот тогтоолоор 4 аж ахуйн нэгж, 2013 оны 395 тоот тогтоолоор 5 аж ахуйн нэгж нийт 44 аж ахуйн нэгжийн 51 согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Одоогийн байдлаар 1 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлээд байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Улсын төсөв, Хүний хөгжлийн санд 511.8 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас 502.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөний гүйцэтгэл 98.2 хувьтай байна.

Манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолтын хэмжээг 2013 оны төсвийн тодотголд 20.5 сая тонн байхаар төлөвлөсөн боловч 2013 оны гүйцэтгэлээр нүүрсний экспорт 18.4 сая тоннд хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 2.1 сая тонн дутуу экспортлосон нь АМНАТ-ын орлого тасрах нөхцөл болжээ.

Агаарын бохирдлын төлбөр

Улсын төсөвт агаарын бохирдлын төлбөрөөр 22.5 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас 25.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөний гүйцэтгэл 112.0 хувьтай байна. Үүнээс нүүрсний агаарын бохирдлын төлбөрөөр 20.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 23.0 тэрбум төгрөгийн төлбөрийн орлогыг төвлөрүүлж төлөвлөгөөг 2.6 тэрбум төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөрөөр 2.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 0.2 тэрбум төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Гаалийн байгууллагаас төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн талаар

Гаалийн байгууллага 2013 оны тодотгосон төлөвлөгөөгөөр Улсын төсөвт 1,960.8 тэрбум төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэйгөөс 2013 оны гүйцэтгэлээр 1,625.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 82.9 хувиар биелүүлжээ. Үүнээс татварын орлогоор 1,901.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,569.1 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөө 82.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 20. Гаалийн байгууллагаас төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг

	Төлөвлөгөө	**Гүйцэтгэл**	**Зөрүү**	**Хувь**
Импортын гаалийн албан татвар	516.4	381.2	-135.2	73.8
Импортын барааны НӨАТ	1,117.4	937.5	-180.0	83.9
Импортын архи, тамхины онцгой албан татвар	91.0	79.9	-11.1	87.8
Импортын пивоны онцгой албан татвар	10.5	10.1	-0.4	96.2
Суудлын автомашины онцгой албан татвар	107.7	104.4	-3.3	96.9
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	47.8	45.4	-2.4	95.0
Автобензин, дизель түлшний албан татвар	10.6	10.9	0.3	102.7
Экспортын гаалийн албан татвар	0.2	0.2	0.0	91.2
Өөрийн орлого	14.6	17.4	2.8	119.4
Бусад татвар	44.5	38.2	-6.3	85.8
Нийт	1,960.8	1,625.2	-335.6	82.9

Өнгөрсөн 2013 онд нийт импортын хэмжээ 2012 онтой харьцуулахад 6.2 хувиар буурч, төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын төлөвлөгөө тасрахад шууд нөлөөлсөн байна.

2013 онд онцгой албан татвартай бараанд 603.9 тэрбум төгрөгийн татвар ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 130,9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ онд янжуур тамхины импорт 9.4 хувиар, дүнсэн тамхиных 12.9 хувиар өнгөрсөн оны мөн үеэс тус тус буурсан боловч онцгой албан татварын хувь хэмжээнд орсон

өөрчлөлт /2012.09.11-ний өдрийн Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар *янжуур тамхины 100ш тутамд 2,4 ам доллар, дүнсэн тамхины 1кг тутамд 1,8 ам долла*р болгон тогтоосон/-тэй холбоотойгоор татвар 30.6 тэрбум төгрөгөөр өссөн. Харин суудлын автомашины импорт буурснаас 14.6 тэрбум төгрөгийн татвар буурсан.

Хүснэгт 21. Зарим барааны импортын хэмжээ

Үзүүлэлт	х/н	2012 он		2013 он		Хувь		Зөрүү -,+	
		Тоо хэмжээ	Татвар /тэрбум ₮/	Тоо хэмжээ	Татвар /тэрбум ₮/	Тоо хэмжээ	Татвар /тэрбум ₮/	Тоо хэмжээ	Татвар /тэрбум ₮/
Согтууруулах ундаа	сая.л	27.3	28.3	36.4	37.9	133.5%	134.1%	9.1	9.6
Янжуур тамхи	сая.ш	1,976.7	53.5	1,791.7	83.0	90.6%	155.1%	(185.0)	29.5
Дүнсэн тамхи	тн	1,145.6	3.1	997.7	4.2	87.1%	133.7%	(147.9)	1.1
Автобензин, дизелийн түлш	мян.тн	1,113.9	193.9	1,186.5	299.2	106.5%	154.3%	72.6	105.3
Автомашин	ш	29,942.0	194.2	25,888.0	179.6	86.5%	92.5%	(4,054.0)	(14.6)
ДҮН			473.0		603.9		127.7%		130.9

Засгийн газрын 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан онцлог салбараас бусад салбарт импортоор оруулсан автобензин, дизелийн түлшний гаалийн болон онцгой албан татварыг “0” хувиар тогтоосонтой холбоотойгоор импортын автобензин, дизелийн түлшний гаалийн, онцгой, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого буурсан. Харин Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 236 дугаар тогтоолоор дизелийн түлшний онцгой албан татварыг тонн тутамд 80000 төгрөг, онцлог салбарт 109000 төгрөгөөр тогтоосноор өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 27.7 тэрбум төгрөгийн онцгой албан татварын орлого орсон. Харин 2013 оны 12 сарын 7-ны өдрийн ЗГ-ын 406 дугаар тогтоолоор орсон дизелийн түлшний 80000 төгрөгийн онцгой албан татварыг “0”-сэн зэрэг өөрчлөлт нь автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлого тасрах шалтгаан болжээ

2013 онд 830.0 тэрбум төгрөгийн бараанд 128.0 тэрбум төгрөгийн татварын чөлөөлөлт үзүүлсэн байна. Үүнийг өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулбал /2012 онд 1063.9 тэрбум төгрөгийн бараг 153.0 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлсөн/ татвараас чөлөөлөгдсөн импорт 233.9 тэрбум төгрөгөөр, чөлөөлөгдсөн татвар 25.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан.

Хүснэгт 22. Зарим бараа үйлчилгээний татвараас чөлөөлсөн байдал

д/д	Үзүүлэлт	2012 он	2013 он	Зөрүү /+,-/
1	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	26.5	17.8	(8.7)
2	Засгийн газрын зээл	1.5	4.0	2.5
3	ГХО	42.0	21.9	(20.1)
4	Оёдлын үйлдвэрийн сэлбэг материал	1.0	3.2	2.2
5	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	16.4	11.5	(4.9)
6	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	23.7	35.8	12.1
7	Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	4.6	5.7	1.1
8	ЖДҮ-ийн зориулалттай тоног төхөөрөмж	31.1	23.8	(7.3)
9	Бусад	6.3	4.4	(1.9)
	ДҮН	**153.0**	**128.0**	**(25.0)**

Газрын тосны орлого

Монгол Улс 2013 онд 3,568.0 мянган баррель газрын тосны олборлож 187.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 16.0 хувиар буюу 25.9 тэрбум төгрөгөөр давж биелүүлсэн.

Экспортын хэмжээг өмнөх онтой харьцуулахад 47.0 хувиар өссөн үзүүлэлтэй байгаа нь “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен” ХХК-ын хайгуулын талбай олборлолтонд шилжиж буйтай холбоотойгоор газрын тосны олборлолт эрчимжиж, экспорт нэмэгдсэн байна.

Навигацийн орлого

Аэронавигацийн орлогоор 2013 онд 56.8 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 2.5 хувь буюу 1.5 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Энэ нь өмнөх оноос 18.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

Тус нөхөн төлбөрийн орлогоор 2.4 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд төлөвлөгөө 41.9 хувиар давсан байна.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоор 35.7 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 7 хувиар буюу тасарсан байна.

Улсын тэмдэгтийн хураамж

Улсын тэмдэгтийн хураамжийн орлогоор 2013 онд 15.9 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөснөөс 73.3 хувиар буюу 6.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

3.2. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл

2013 оны улсын төсвийн зарлага 4,683.0 тэрбум төгрөгт хүрч, 90.7 хувийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 303.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 11. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл, тэрбум төгрөг

	2. УЛСЫН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	ХУВЬ				ЗӨРҮҮ
			Төлөв.	Гүйцэт.	(11 : 10)	(11 : 9)	(11 -10)
	8	9	10	11	12	13	14
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**4,379.5**	**5,165.6**	**5,165.6**	**4,683.0**	**90.7**	**90.7**	**-482.5**
УРСГАЛ ЗАРДАЛ	**3,037.7**	**3,699.2**	**3,699.2**	**3,483.9**	**94.2**	**94.2**	**-215.4**
1. Бараа, үйлчилгээний зардал	**1,895.4**	**1,499.7**	**1,499.7**	**1,398.6**	**93.3**	**93.3**	**-101.1**
1.1. Цалин хөлс	1,084.2	771.6	771.6	755.8	98.0	98.0	-15.8
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	99.9	63.4	63.4	61.1	96.4	96.4	-2.3
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	711.3	664.7	664.7	581.6	87.5	87.5	-83.0
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**107.0**	**304.4**	**304.4**	**261.1**	**85.8**	**85.8**	**-43.3**
3. Татаас ба шилжүүлэг	**1,035.2**	**1,895.2**	**1,895.2**	**1,824.2**	**96.3**	**96.3**	**-71.0**
3.1. Татаас	393.8	444.4	444.4	427.2	96.1	96.1	-17.2
3.2. Орон нутгийн төсөвт өгөх санхүүгийн дэмжлэг	151.8	155.0	155.0	155.0	100.0	100.0	0.0
3.3. Төсөв хоорондын урсгал шилжүүлэг	24.0	999.6	999.6	970.8	97.1	97.1	-28.8
3.4. Бусад урсгал шилжүүлгүүд	274.1	105.6	105.6	201.1	190.5	190.5	95.5
3.5. бусад шилжүүлэг	189.5	185.7	185.7	66.5	35.8	35.8	-119.2
3.6. Гадаад шилжүүлэг	2.1	4.9	4.9	3.6	73.4	73.4	-1.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**1,277.5**	**1,376.7**	**1,376.7**	**1,077.8**	**78.3**	**78.3**	**-298.8**
1.1. Дотоод эх үүсвэрээр:	1,180.0	1,182.6	1,182.6	831.8	70.3	70.3	-350.8
1.2. Гадаад эх үүсвэрээр	97.5	194.1	194.1	246.0	126.8	126.8	52.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	**64.3**	**89.7**	**89.7**	**121.3**	**135.3**	**135.3**	**31.7**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН УРСГАЛ ТЭНЦЭЛ	**-1.4**	**743.8**	**743.8**	**412.6**	**55.5**	**55.5**	**-331.2**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	**-991.7**	**-608.1**	**-608.1**	**-672.6**	**110.6**	**110.6**	**-64.5**

Улсын төсвийн халамжийн сангаас алдар цолтой ахмад дайчдын тэтгэмжид 5.8 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд 30.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Хотын нийтийн тээврийн татаас 53.3 тэрбум, эрчим хүч, дулааны алдагдлын татаас 32.7 тэрбум, улаан буудай, махны татаас 24.2 тэрбум, засгийн газрын нөөц хөрөнгийн зардал 19.8 тэрбум, их дээд сургууль коллежийн оюутны тэтгэлэг 105.7 тэрбум, хөрөнгийн зардал 1,069.6 тэрбум төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна. Улсын төсвөөс 155.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 784.0 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 187.5 тэрбум төгрөгийн ОН-ийн хөгжлийн сангийн шилжүүлгийг тус тус орон нутагт олгоод байна.

3.3. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарлагын гүйцэтгэл

Өнгөрсөн 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,124.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчлагдан батлагдсанаас нийт 787.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж төлөвлөгөөний биелэлт 70.1 хувьтай гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь өнгөрсөн 2012 онтой харьцуулахад 22.5 нэгжээр бага байгаа боловч 2012 оны үлдэгдэл санхүүжилтэд олгосон 182.8 тэрбум төгрөгийг оруулан тооцоход 970.6 тэрбум төгрөг болж байгаа нь өмнөх оны түвшинд байгаа юм.

Монгол Улсын Нэгдсэн төсвийн хэмжээнд авч үзвэл орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 370.5 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтад 5.2 тэрбум төгрөг, нийт 1,346.3 тэрбум төгрөгийг олгосон нь хамгийн их хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн он болсон байна.

Хүснэгт 23. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, сая төгрөг

Үзүүлэлт	2013 оны төлөвлөгөө	2013 оны санхүүжилт	Хувь
Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	362.0	157.7	43.6
Улсын их хурлын дарга	453.2	370.5	81.7

Ерөнхий сайд	91,386.1	57,519.3	62.9
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	11,837.9	8,358.7	70.6
Гадаад харилцааны сайд	11,541.5	10,055.0	87.1
Сангийн сайд	11,648.2	6,571.5	56.4
Батлан хамгаалахын сайд	17,739.1	13,907.2	78.4
Эрүүл мэндийн сайд	40,815.5	22,161.8	54.3
Үндсэн хуулийн цэцийн дарга	170.4	166.8	97.9
Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	792.0	497.2	62.8
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	7,619.3	7,033.9	92.3
Улсын ерєнхий прокурор	10,121.2	8,466.4	83.7
ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга	497.9	491.8	98.8
Үндэсний ерєнхий аудитор	69.5	69.5	100.0
Үндэсний статистикийн хорооны дарга	231.0	183.9	79.6
Төрийн албаны зөвлөлийн дарга	64.8	64.8	100.0
ЦАУЗБК-ын дарга	16.3	16.0	98.2
Монгол улсын шадар сайд	22,899.7	20,217.9	88.3
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	133.8	129.0	96.4
Хүний эрхийн үндэсний комиссын дарга	20.0	19.9	99.4
Авилгатай тэмцэх газрын дарга	3,001.4	2,984.8	99.4
Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	4,469.3	4,063.1	90.9
Хууль зүйн сайд	44,960.3	29,952.3	66.6
Барилга, хот байгуулалтын сайд	99,947.2	69,611.3	69.6
Боловсрол, шинжлэх ухааны сайд	116,520.7	78,910.0	67.7
Зам, тээврийн сайд	332,753.9	260,706.5	78.3
Соёл, спорт, аялал жуулчлалын сайд	42,721.3	28,186.0	66.0
Уул, уурхайн сайд	4,517.7	3,825.8	84.7
Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	54,846.0	35,350.1	64.5
Хөдөлмөрийн сайд	13,446.8	8,349.3	62.1
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	9,504.0	8,722.5	91.8
Эдийн засгийн хөгжлийн сайд	52,070.1	8,692.8	16.7
Эрчим хүчний сайд	117,127.4	92,025.5	78.6
Нийт	**1,124,305.5**	**787,838.8**	**70.1**

Зураг 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн динамик, тэрбум төгрөг



Эрчим хүчний салбар

Эрчим хүчний салбар 2013 онд 117.1 тэрбум төгрөгийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг 78.6 хувиар биелүүлж 92.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан байна.

Зураг 13. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын бүтэц



Улсын төсвөөс 60.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж цахилгаан дамжуулах шугам, дэд станцуудыг барьсан бөгөөд Дундговь аймгийн Мандалговь-Өмнөговь аймгийн Тавантолгой-Оюутолгойн 2 хэлхээтэй 220 кВ-ын 429 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Өмнөговь аймгийн Тавантолгой-Даланзадгадын 110 кВ-ын 98 км, Хөшгийн хөндийд нисэх онгоцны буудал барихтай холбогдуулан 110 кВ-ын 83.4 км, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл-Тариалан сумын 35 кВ-ын 93 км, Увс аймгийн Малчин-Тэс сумын 35 кВ-ын 115 км зэрэг нийт 1214 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж ашиглалтад оруулсан байна.

Улаанбаатар хотын 87 км цахилгааны кабель шугамыг өргөтгөх, шинэчлэхэд 3.4 тэрбум, Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулахад 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс оруулсан нь Нийслэлийн иргэдийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад чухал нөлөө үзүүлсэн.

Улсын төсвөөс 4.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж 20 гаруй сумдын 0.4 кВ-ын ЦДАШ, дэд станцыг иж бүрэн шинэчилсэн нь эрчим хүчний салбарын шугамын алдагдлын багасгахад ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Улсын төсвөөс 25.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж дулааны цахилгаан станц, дулааны шугам шинэчилсэн бөгөөд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын дулааны шугам сүлжээний шинэчлэл, Улаанбаатар хотын НС-3-ын насосуудыг хувьсах хурдны насосуудаар шинэчлэх, Дорнод аймгийн дулааны цахилгаан станцын зуухны шинэчлэл, тэжээлийн усны ерөнхий шугам болон хаалт, арматурыг шинээр солих, Дархан-Уул аймгийн дулааны түгээх сүлжээний шугам хоолойг шинэчлэн сайжруулах, Улаанбаатар хотын дулааны 2 г, д, 3 д, 6 д магистраль шугамуудыг ашиглалтад оруулаа.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд улсын төсвөөс 9.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж, "ДЦС-4"-ийн сүлжээний өргөтгөлийн 1 дүгээр насосуудыг “0” түвшинд шилжүүлэх, "ДЦС-4" ХК-ийн зуухны гаргах утаа, үнсийг үлэмж хэмжээгээр бууруулах технологи нэвтрүүлэх ажлыг ашиглалтад оруулсан.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар

Үйлдвэр хөдөө аж ахуйн салбар 2013 онд 54.8 тэрбум төгрөгийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг 64.4 хувиар биелүүлж 35.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан байна.

Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулахад улсын төсвөөс 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж 18 аймаг, отрын бүс нутагт 57 аж ахуйн нэгжээр 415 инженерийн хийцтэй худгийг барьж ашиглалтад оруулсан. Энэ ажлын үр дүнд 1.2 сая мал сүрэг, 622.5 мянган га бэлчээр, 2.0 мянган малчин өрхийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлэв.

Зураг 14. Инженерийн хийцтэй худгийн тоо



Улсын төсвөөс 485.3 сая төгрөгийн хөрөнгө оруулж Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Хэнтий, Говьсүмбэр аймгуудын 423 бэлчээрт газрын доорхи усны геофизикийн хайгууль хийж дуусган тайланг хамгаалуулан орон нутагт хүргүүлээд байна.

Дорноговь, Говьсүмбэр аймагт салхины эрчим хүчээр ажиллах ус өргүүрийг 15 худагт суурилуулан ашиглалтанд оруулсан бөгөөд улсын төсвөөс 150,0 сая төгрөг санхүүжүүлсэн байна.

Усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн ба орон нутгийн өмчлөлийн 6 аймгийн 10 услалтын системийг шинээр барьж, сэргээн засварласан болно.

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын “Цонжийн хөдөө”-ийн услалтын систем, Толбо сумын Шумекийн услалтын систем, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Эхийн гол”-ын услалтын систем, Галуут сумын Талын толгойн услалтын систем, Баянлиг сумын Баянлигийн услалтын систем, Баянцагаан сумын “Цагдуултайн услалтын систем, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Найрын дэнжийн услалтын систем, Төв аймгийн Борнуур сумын Борнуурын услалтын систем, Дархан Уул аймгийн арван жилийн Бүрэн толгойн услалтын системийг шинээр барих, шинэчлэн засварлах, зураг төсөв боловсруулахад улсын төсвөөс нийт 4.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж 651,3 га талбайг усалгаатай тариалангийн эргэлтэнд нэмж оруулах боломжийг бүрдүүлсэн.

Мөн Ховд аймгийн Буянт сумын Буянтын услалтын системийн 3-р ээлжийн 396,7 га талбайг шинээр барьж ашиглалтанд оруулсан бөгөөд улсын төсвөөс 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан байна.

Төмс, хүнсний ногооны тариалан эрхэлдэг иргэн, ногоочдын бүлгийн га-аас авах ургацыг нэмэгдүүлэх, усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх зорилгоор 1.2 тэрбум төгрөгийн 3 хүртлэх га талбайг услах хүчин чадал бүхий 240 ширхэг зөөврийн усалгааны систем, усан санг нийлүүлж үүний үр дүнд төмс, хүнсний ногооны 800 орчим га талбайн усан хангамжийг сайжруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Эрүүл мэндийн салбар

Эрүүл мэндийн салбарт улсын төсвөөс 2013 онд 22.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, төлөвлөгөөний биелэлт 54.4 хувьтай гарсан байна.

Салбарын хэмжээнд 9.5 тэрбум төгрөгийг барилга байгууламж барихад, 7.4 тэрбум төгрөгийг их засварын ажилд, 5.2 тэрбум төгрөгийг эмнэлгийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авахад тус тус зарцуулсан байна. Хүснэгтээр харуулбал,

Хөдөө орон нутагт нийт 270 ор бүхий 12 эмнэлэг, Эрүүл мэндийг дэмжих 4 төвийг тус тус шинээр ашиглалтад өгсөн байна. Үүнд: Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 30 ортой Халдвартын эмнэлэг; Завхан аймгийн Улиастай, Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 50 ортой Төрөх эмнэлэг; Архангай аймгийн Тариат, Сүхбаатар аймгийн Онгон суманд 20 ортой эмнэлгийн барилга; Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 20 ортой Халдвартын эмнэлэг; Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Төв аймгийн Борнуур суманд 15 ортой; Дундговь аймгийн Дэлгэрцогт, Хэнтий аймгийн Мөрөн суманд 10 ортой Эмнэлгийн барилга; Хэнтий аймгийн Хэрлэн, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Орхон аймгийн Баян-Өндөр, Баян-

Өлгий аймгийн Өлгий суманд тус бүр Эрүүл мэндийг дэмжих төв шинээр ашиглалтад оруулсан.

Соёл, спорт, аялал жуулчлалын салбар

2013 онд Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцад 42.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр шилжих болон шинээр эхэлсэн барилга байгууламж барихад 23.6, их засварт 4.3 тэрбум төгрөгийг зарцуулж, нийт санхүүжилт 66.0 хувийн биелэлттэй гарсан байна.

Соёлын салбарт 2013 онд Баян-Өлгий аймгийн Буянт, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Өвөрхангай аймгийн Есөнзүйл, Увс аймгийн Наранбулаг, Хэнтий аймгийн Дадал болон Баянмөнх сумдад нийт 1250 хүний суудал бүхий Соёлын төвийн 6 барилга, Дорнод аймгийн Баянтүмэн суманд Соёл, урлагийн заал, Дорнод аймгийн Чойбалсан сумын номын сангийн өргөтгөлийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулсан байна.

Биеийн тамир, спортын салбарт 7 барилга байгууламж барихад нийт 8166.7 сая, их засварт 308.0 сая төгрөг зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын хэмжээнд 2013 оны тайлант жилд 5992.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 8 барилга байгууламж шинээр ашиглалтад орсон байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбар

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбарын 2013 оны нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтын 5.4 тэрбум төгрөгийг барилга байгууламж барихад, 1.3 тэрбум төгрөгийг их засварын ажилд, 1.5 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авах ажилд тус тус зарцуулсан байна.

Орхон аймагт Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтсийн барилга, Увс аймгийн Улаангом суманд Иргэдэд үйлчлэх халамжийн төв, Хүүхэд, залуучуудын парк, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт Хүүхдийн хөгжлийн төвийн барилгыг тус тус шинээр, Олон улсын хүүхдийн Найрамдал төвийн дулааны станцын өргөтгөл зэргийг ашиглалтад оруулсан.

Хөдөлмөрийн салбарт улсын төсвөөс 2013 онд 8.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, төлөвлөгөөний биелэлт 62.1 хувьтай гарсан байна.

Салбарын хэмжээнд 4.6 тэрбум төгрөгийг барилга байгууламж барихад, 1.1 тэрбум төгрөгийг их засварын ажилд, 2.6 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Тайлант онд Увс аймгийн Түргэн, Өндөрхангай, Зүүнхангай сумдад тус тус Ахуйн үйлчилгээний төвийн барилга, Булган аймгийн МСҮТ-ийн биеийн тамирын заалны барилга, Хэнтий аймагт МСҮТ, Хөвсгөл аймгийн МСҮТ-ийн авто засварын дадлагын газрын барилгыг тус тус шинээр ашиглалтад оруулсан.

Зам, тээврийн салбар

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралтаар Зам, тээврийн сайдын багцад 777,436.0 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 109 төсөл, арга хэмжээнд 332.7 тэрбум төгрөгийн хөрөнгө батлагдснаас 78.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс Авто зам, гүүрийн салбарт 553.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 81 төсөл арга хэмжээнд 269.9 тэрбум төгрөг, тээврийн салбарт 196.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл арга хэмжээнд 44.5 сая төгрөг тус тус батлагдсан байна. Түүнчлэн салбарын их засварын ажил 83.1 хувь, тоног төхөөрөмж худалдан авалт 57.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ашиглалтад орсон авто зам, замын байгууламжийн төрлөөр гаргавал хатуу хучилттай зам 10 объект 394,551 км, хайрган хучилттай зам 1 объект 7.344 км, төмөрбетон гүүр 4 объект 777.41 у/м, хөвдөг гүүр1 объект 96 у/м тус тус улсын комиссын акт гарч хүлээн авсан байна. “Техникийн үзүүлэлт чанар байдлын дүгнэлт гаргах журам”-ын дагуу хэмжилт судалгаа, үзлэг хийгдсэн авто зам, замын байгууламжийн төрлөөр харвал хатуу хучилттай зам 20 объект 4267.1 км, онгоцны буудлын хөөрч буух зурвас2 объект 3 км тус тус байна.

Барилга, хот байгуулалтын салбар

Монгол Улсын “Төсвийн тухай хууль” болон “2013 оны төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар Барилга хот байгуулалтын сайдын багцад Улсын төсвөөс хөрөнгө оруулалтын зардлаас 61 төсөл арга хэмжээнд 91,133.9 сая, их засварын зардлаас 2 төсөл арга хэмжээнд 151.5 сая, тоног төхөөрөмжийн зардлаас 13 төсөл арга хэмжээнд 5,967.2 сая, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн 12 төсөл арга хэмжээнд 2,694.0 сая төгрөг, нийт 88 төсөл арга хэмжээг 99,947.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан.

Батлагдсан төсөвт багтаан“Төсвийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа ажил үйлчилгээний тухай хууль”, “Барилгын тухай хууль” болон холбогдох дүрэм, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гүйцэтгэл ирүүлэх, хянах, санхүүжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.

Төсвийн тухай хуульд заасан хугацаа буюу 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хөрөнгө оруулалт барилга байгууламжид 66,502.6 сая төгрөг, их засварт 151.4 сая төгрөг, тоног төхөөрөмжид 2,957.2 сая төгрөг, нийт 69,611.2 сая төгрөг байгаа нь батлагдсан төсөвтэй харьцуулахад хөрөнгө оруулалт барилга байгууламж 70.5 хувь, их засвар 99.9 хувь, тоног төхөөрөмж 49.5 хувь буюу нийт дүнгээр **69.6** хувийн гүйцэтгэлтэй байна.

Гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчаас шууд хэрэгжсэн болон орон нутагт эрх шилжин хэрэгжсэн байдлаар үзүүлбэл:

Хүснэгт 24. Орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалт, сая төгрөг

Хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэгч	Гүйцэтгэл
Барилга, хот байгуулалтын яам	39,100.3
Аймаг, нийслэл орон нутаг	30,510.9

Нийт	**69,611.2**

Улсын төсвийн 2013 оны хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт дулааны 12 километр шугамыг бүрэн дуусгаж, Төв аймгийн халааалтын 2 зуухын өргөтгөл, 4 зуухыг шинэчлэх ажлыг бүрэн дуусгасан. Түүнчлэн улсын хэмжээнд бохир усны 31.2 километр шугам, цэвэр усны 151.0 километр шугамыг барьж ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

Аймаг, нийслэл болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудыг түшиглэн хөгжих хот, тосгон, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, шинээр боловсруулах ажлын хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө бүрэн дуусч, Увс аймгийн Боршоо, Өмнөговь аймгийн Шивээхүрэн, Гашуунсухайт хилийн боомтуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө дуусч, экспертизийн хяналтын шатандаа байна. Мөн “21 аймгийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах” ажлын хүрээнд Ховд, Төв, Өмнөговь, Завхан, Хэнтий, Дорнод, Говьсүмбэр аймгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлуудын эхний болон явцын ажлууд хийгдээд байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Сумын төвийн шинэчлэл”, “Шинэ сум” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2013 онд Баянхонгор аймгийн Баянлиг, Бууцагаан сумд, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд энэхүү төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Баянхонгор аймгийн Баянлиг, Бууцагаан суманд хэрэгжиж байгаа ажлын гүйцэтгэл 90.0-92,5 хувьтай, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хэрэгжиж байгаа төслийн цэцэрлэг, эмнэлгийн барилга угсралтын ажил 75.0-85.0 хувьтай, сургуулийн барилга 50.0 хувь, соёл, спортын цогцолборын барилга 30.0 хувийн тус тус гүйцэтгэлтэй хийгдсэн бөгөөд 2014 онд бүрэн хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. /Төсвийн тодотголоор 00 дүнтэй ажлын жагсаалтад оруулсан/

Орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагын чадварыг бэхжүүлэх зорилгоор усны тоолуурын лабораторийн тоног төхөөрөмжийг бүх аймагт, бохир соруулах зориулалтын автомашиныг 10 аймагт тус тус хувиарлан хүргүүлсэн. /Төсвийн тодотголоор 00 дүнтэй ажлын жагсаалтад оруулсан/

Байгаль орчин, ногоон хөгжлийн салбар

Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарт Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар нийт 10,339.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж, хөрөнгийн оруулалтын ангилалд 6,390.0 сая төгрөг, их засварын ангилалд 513.2 сая төгрөг, тоног төхөөрөмжийн ангилалд 3,435.9 сая төгрөг туссан. Салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны хөрөнгийн оруулалтын түвшнээс буурсан гол шалтгаан нь төсвийн орлогын эх үүсвэртэй уялдуулан Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулинд өөрчлөлт оруулах хуулиар 2013 оны 08 дугаар сарын байдлаар тендер зарлаагүй, гэрээ байгуулагдаагүй байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын нийт 19,612.1 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг 2014 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсантай холбоотой юм.

Зураг 15. Байгаль орчин ногоон хөгжлийн салбарын хөрөнгө оруулалт



Түүнчлэн, байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын хэмжээнд 2013 онд ус цаг уур орчны шинжилгээний салбарын барилга, байгууламж байгуулах ажилд 365.8 сая төгрөг, ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул хийх ажилд 757.4 сая төгрөг, газрын генератор суурилуулах ажилд 200.0 сая төгрөг, газар доорх усны хяналт, шинжилгээний болон цэвдгийн хяналтын цооног өрөмдөж тоноглоход 45.0 сая төгрөг, диоксин, фураны дээж авах, шинжилгээ хийх лаборатори байгуулах ажилд 398.6 сая төгрөг, гадаргын усны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх, мэдээллийн сан үүсгэхэд 353.5 сая төгрөг, мод бэлтгэл, тээвэрлэлт, борлуулалтыг хянах, хяналтын видео системд 127.5 сая төгрөг тус тус зарцуулжээ.

2013 оны эцсийн байдлаар Төв, Говь-Алтай, Өвөрхангай, Дундговь, Завхан, Увс, Сүхбаатар зэрэг аймгуудын ус, цаг уурын өртөөний, газрын генераторын байр, цаг уурын радарын станцын автомашины гражын барилга болох 271.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 барилга, байгууламжийг ашиглалтанд оруулан Улсын комисст хүлээлгэн өгсөн.

Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 84.9 хувьтай, их засварын ажлын гүйцэтгэл 97.8 хувьтай, тоног төхөөрөмж худалдан авалтын гүйцэтгэл 95.2 хувьтай байгаа ба үүнээс 121.8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны салбар

Боловсрол, шинжлэх ухааны салбарт хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байгаа хэдий ч 2013 онд хуулиар нийт 116,520.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж 2012 оны төсвөөс 17,3 тэрбум орчим төгрөгөөр буурсан байна.

Үүнээс хөрөнгө оруулалтын ангилалд 80,636.6 сая төгрөг, их засварын ажлын ангилалд 14,680.0 сая төгрөг, тоног төхөөрөмжийн ангилалд 17,637,7 сая төгрөг, техник эдийн засаг үндэслэл, зураг төсөл боловсруулахад 3,567.1 туссан ба боловсролын салбарт 108,610,6 сая төгрөг, шинжлэх ухааны салбарт 7,910.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардалд тус тус төлөвлөсөн.

Зураг 16. Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт



Түүнчлэн "Дэлхийн зөн" олон улсын байгууллага, Япон Улсын "Өвсний-Үндэс" хөтөлбөр, Дэлхийн банкны "Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл" төсөл, Япон Улсын Засгийн газрын тусламжаар хэрэгжиж буй "Сургуулийн барилгын өргөтгөл-4" төсөл, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Дээд боловсролын шинэчлэл" төслийн Монголын талын хөрөнгийн санхүүжилтэд 2,555.4 сая төгрөгийг зарцуулсан.

Шинжлэх ухааны салбарын хэмжээнд нийт 7,910.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсанаас шинжлэх ухааны судалгааны лаборатори, спортын танхим бүхий цогцолборын барилга, биологийн идэвхтэй бэлдмэлийн үйлдвэрлэл, туршилтын цех, Дундговь, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн газар хөдлөлтийг бүртгэх станцын барилга угсралтын ажилд 461.7 сая төгрөг, салбарын их засвар шинэчлэлийн ажилд 492.2 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах ажилд 374.1 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосон бөгөөд хөрөнгө оруулалтын ажил 32.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Салбарын хэмжээнд 2013 оны оны эцсийн байдлаар нийт 9768 хүүхдийн хүчин чадалтай 59 барилгыг шинээр ашиглалтанд оруулснаас 2150 ортой 13.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 24 цэцэрлэгийн барилга, 6248 суудалтай 18.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 сургуулийн хичээлийн байрны барилга, 1430 ортой 9.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 дотуур байрны барилга, 3718 м2 талбай бүхий 5,023.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 спорт заалны барилга, 981.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 музейн барилга, тус бүр нь 300 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 станц, 190.9 сая төгрөгийн 2 сургуулийн гал тогоо тус тус шинээр ашиглалтанд оруулан Улсын комисст хүлээлгэн өгсөн. Салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл нь барилга угсралтын ажил 76.0 хувь, их засвар 94 хувь, тоног төхөөрөмж 46.4 хувь нийт 67.7 хувь байна.

Мэдээлэл, технологи, шуудан, харилцаа холбооны салбар

Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн салбарт нийтдээ 18.4 тэрбум төгрөгөөр 17 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Зураг 17. МТШХХГ-ын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг



Сумдад өндөр хурдны, өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Төслийн хүрээнд 2013 онд 21 аймгийн төв, нийслэлийн Налайх, Багануур, Багахангай, Био-комбинат, Шувуун фабрик гэсэн газруудад утасгүй интернетийн төхөөрөмжийг суурилуулж, МЦХ ХХК интернэтийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд 2013 онд нийт 52 суманд холбогдох төхөөрөмжийн суурилуулалтын ажил хийгдсэн.

Улаанбаатар хотын холбооны сувагчлалын шинэчлэл, худаг сувагчлалын цагирган сүлжээ байгуулах төслийн хүрээнд Олимп хотхон 2 км, СБД 7 хороолол 6.3 км, Нисэх орчмын шинэ хороолол 11.5 км, Гадаад харилцааны яамны уулзвараас Дүнжингарав 1.8 км, Баянзүрх дүүрэг 14 хороолол 5.8 км, Нүхтийн ам орчим 4.5 км сувагчлалын ажлыг хийж эхлүүлсэн бөгөөд 600.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг аналоги системээс тоон системд үе шаттай шилжүүлэх: Өнгөрсөн онд 38 сайтын тоног төхөөрөмж хүлээлгэн өгч ажиллагаанд оруулахад бэлэн болоод байна. 250 сумаас 90 суманд шилэн кабель тавьж 13 аймагт шилэн кабель ороод байна. Энэхүү төсөл, арга хэмжээнд 1.7 тэрбум төгрөг олгоод байна.

Цахим засаглалын мэдээллийн сан, мэдээллийн системийг хөгжүүлэх: Төслийн хүрээнд 2 багц төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн бөгөөд 166.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Багц 1-ийн хувьд Монгол хэлний зөв бичгийн алдаа шалгах програм хангамжийг бий болгох ажлыг хийж үндсэн алдаа шалгах программ хангамжийн 90 хувийг гүйцэтгээд байна. Багц 2-ын хувьд иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах мэдээллийн системийг бий болгох ажлын хүрээнд Улаанбаатар хотод нийт 17 ширхэг ТҮЦ машиныг байршуулан иргэдийн санал хүсэлт хүлээн авах, зарим төрийн байгууллагаас иргэдэд олгодог тодорхойлолтыг олгож эхлээд байна.

Газар хөдлөлийн гамшгийг амжиж анхааруулах систем бий болгох: МТШХХГ нь 2012 онд БНСУ-ын Кореа телеком корпорацитай гэрээ байгуулсан бөгөөд өнгөрсөн онд энэхүү төсөл, арга хэмжээнд 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүдэд нийт 40 ширхэг дуут дохиоллын цамхаг байршуулах

зөвшөөрлийг авч 30 цамхагын угсралт хийгдээд байна. МҮОНРТ-ийн сувагт зарлан мэдээллийн төхөөрөмж суурилуулж тохиргоог хийж гүйцэтгэсэн бөгөөд газар хөдлөлийг мэдрэх сенсоруудыг Дэрэн, Могод, Цагаанннуурын голомтын бүсүүдэд байршуулсан байна.

Аймгийн бүх багийн төвүүдийг үүрэн холбооны сүлжээгээр холбоожуулах, интернетэд холбох: Ховд аймгийн 31 багт үүрэн холбооны үйлчилгээ оруулсан бөгөөд гэрээний дагуу хээрийн сайт болон холбогдох тоног төхөөрөмжүүдийг суурилуулж ашиглалтад оруулахад 533.3 сая төгрөг олгосон байна.

Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /аймаг, нийслэл/ : Өнгөрсөн онд энэхүү төсөл, хэмжээнд нийтдээ 3.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Төслийн хүрээнд 9 багц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 5 багц төслийг бүрэн хэрэгжүүлж дуусаад байна. Үүнд МТҮП-ийн барилгын их засвар, ажлын зураг төсөл боловсруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох ажлууд тусгагдсан байна.

Иргэдийн өргөдөл гомдлын мэдээллийн ухаалаг тайлангийн систем: Энэхүү төслийн хүрээнд 500.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд төслийн гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага системийг суурилуулж, тохиргооны ажлыг хийж дуусгасан байна.

Батлан хамгаалах салбар

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2013 онд нийтдээ 13.9 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын нийт хэмжээ хүлээгдэж буй гүйцэтгэлээр 78.4 орчим хувьд хүрэх тооцоотой байна.

Зураг 18. Батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг



Сүхбаатар, Баянхонгор, Баян-Өлгий аймагт барилга инженерийн холимог бүтэцтэй батальоныг шинээр байгуулж, улс орны бүтээн байгуулалтын ажилд болон олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд барилга инженерийн чиглэлээр оролцуулахаар заасан. Шинээр байгуулагдсан барилга-инженерийн батальоны үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор Сүхбаатар аймагт барилга, инженерийн батальоны барилга байгууламж худалдан авахад үлдэгдэл 350.0 сая төгрөг, Баян-Өлгий аймагт цэргийн

албан хаагчдын албан тушаалын 8 айлын орон сууц худалдан авахад 123.9 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон.

Хэнтий аймагт батлан хамгаалах салбарын сувиллын цогцолборын барилга болон Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн барилгыг барьж ашиглалтанд оруулсан. Мөн Сэлэнгэ аймгийн Мандал суманд "Шонхор хүүхдийн зуслан" төслийн соёлын төв, халуун усны барилгын ажлыг дуусгасан.

Өнгөрсөн онд өмнөх жилүүдэд эхлүүлсэн барилгын ажлуудыг үргэлжлүүлж, нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцох үүрэг зориулалт бүхий 3 дахь батальон байгуулах ажилд 1.3 тэрбум төгрөг, нийслэлийн Баянзүрх дүүрэгт цэргийн эмнэлгийн төв цогцолборын барилгын ажилд 4.2 тэрбум төгрөг, "Тэмүүжин өрлөг" ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн дотуур байрны цогцолборын барилгад 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын өргөтгөлийн барилга, цэргийн албан хаагчдын албан тушаалын 63 айлын орон сууц, Батлан хамгаалах их сургуулийн "Биеийн тамирын цогцолбор"-ын барилга, "Цэрэг спортын төв цогцолбор" төсөл, Хэнтий аймагт цэргийн албан хаагчдын албан тушаалын 16 айлын орон сууц, Өмнөговь аймагт Говийн бүсийн сургалтын төв зэрэг төсөл, арга хэмжээнүүдийг шинээр хэрэгжүүлж эхэлсэн.

Хууль зүйн салбар

Хууль зүйн сайдын багцад 2013 онд 29.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс барилгын ажилд 26.2 тэрбум, их засварын ажилд 0.7 тэрбум, тоног төхөөрөмж худалдан авахад 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг тус тус олгосон байна.

Зураг 19. Хууль зүйн салбарын хөрөнгө оруулалт



Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар 2013 онд 10.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнээс барилга байгууламжийн 4 төсөл, арга хэмжээнд 9.2 тэрбум төгрөг батлагдсанаас 7.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. 2013 онд орон нутгийн сумдын төлөөлөгчийн 25 кобаны барилгыг барьж дуусгахад 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт

Дотоодын цэргийн 805 дугаар ангийн усан хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын албаны контор, цэргийн гал зуухны нэгдсэн байрны санхүүжилтэд 1.7 тэрбум төгрөг, Дотоодын цэргийн бэлтгэл хүчний болон 809 дүгээр тусгай салбарын нэгдсэн барилга барихад 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож тухайн барилгуудыг ашиглалтанд оруулсан байна. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2012 онд Нийслэлийн цагдаагийн хэлтсийн нэгдсэн барилгын ажлыг эхлүүлж 2013 онд үлдэгдэл 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож барилгыг ашиглалтанд оруулсан.

Өнгөрсөн онд цагдаагийн байгууллагад их засварын ажилд 726.0 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хил хамгаалах ерөнхий газрын захиалгаар 2013 оны нийтдээ 1.8 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжээд байна. Үүнээс барилга байгууламжинд 1.4 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 0.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Дорнод аймгийн Халхгол суманд халуун усны угаалгын барилгын ажлыг дуусгасан бөгөөд Дорноговь аймгийн Хатанбулаг суманд хилийн ангийг шилжүүлэн байршуулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар 2013 оны нийтдээ 3.6 тэрбум төгрөгийн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ хэрэгжсэн.

Увс аймагт цагдан хорих байрыг барихад 125.0 сая төгрөг олгож барилгыг ашиглалтанд оруулсан. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт нэгдсэн хорих ангийн барилгын ажлыг шинээр эхлүүлж 3.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын цахилгааны хаалттай дэд станцын барилгын дуусгалд 141.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, барилгыг ашиглалтанд оруулсан.

Өнгөрсөн онд Хууль сахиулахын их сургуулийн 850 сонсогчийн оюутны дотуур байрыг үргэлжлүүлэн барихад 680.0 сая төгрөг олгож, дотуур байрыг ашиглалтанд оруулсан. Хууль сахиулахын их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн байрны барилгыг шинээр эхлүүлж 10.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хуульзүйн яам, Мөрдөн байцаах албаны конторын барилгын дуусгалд нийтдээ 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож Мөрдөн байцаах албаны барилгын ажлыг дуусгасан.

Нийслэлийн Хан-Уул дүүрэгт Дүүргийн прокурор болон шүүхийн нэгдсэн байрны барилгын ажлыг эхлүүлж, 385.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

3.4. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл

Засгийн газрын нөөц сангийн санхүүжилт нь “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн дагуу зохицуулагддаг бөгөөд Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг юм.

2013 оны төсөвт Засгийн газрын нөөц сангаас зарцуулах хөрөнгө 20,000.0 сая төгрөгөөр батлагдсан.

2013 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө зарцуулах тухай Засгийн газрын 46 тогтоолын дүн 20,994.9 сая төгрөг буюу төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 104.9 хувьтай, олгосон санхүүжилт 18,735.1 сая төгрөг буюу төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 93.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

Хүснэгт 25. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл, хөрөнгийн зориулалтаар, сая төгрөг

Засгийн газрын нөөц хөрөнгийн зориулалт	Тогтоолын дүн	Санхүүжүүлсэн дүн
Ойн арга хэмжээ, баяр ёслол, шагнал урамшуулал	2,545.3	2,545.3
Төрийн өмнөөс гүйцэтгэх ажил	4,751.2	4,472.7
Хөрөнгийн чанартай ажил	2,969.6	2,781.7
Хурал, зөвлөлгөөний зардал	409.2	304.5
Цаг үеийн ажил, байгалийн бэрхшээл	10,319.6	8,631.0
Нийт	**20,994.9**	**18,735.1**

Засгийн газрын нөөц сангаас 2010 оны тогтоолоор он дамжиж 339.6 сая төгрөг, 2012 оны тогтоолоор 2,109.2 сая төгрөг, 2013 оны тогтоолоор 16,286.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн болно.

Хүснэгт 26. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл, тогтоолоор, сая төгрөг

Үзүүлэлт	Дүн	Хувь
2013 оны төсөв	20,000.0	
Засгийн газрын тогтоолын дүн	20,994.9	104.9
Үүнээс: 2010 оны тогтоолоор	342.6	1.7
2012 оны тогтоолоор	3,143.2	0.3
2013 оны тогтоолоор	17,509.1	103.0
Нийт санхүүжүүлсэн	18,735.1	93.7
Үүнээс: 2010 оны тогтоолоор	339.6	1.7
2012 оны тогтоолоор	2,109.2	10.5
2013 оны тогтоолоор	16,286.2	81.5

Засгийн газрын тогтоолын хэмнэлт 507.2 сая төгрөгийг “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 91.2.3 дахь “Засгийн газрын нөөц сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэрийг төвлөрүүлнэ” гэсэн заалтын дагуу Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүллээ.

Мөн Үндэсний аудитын газрын актын дагуу 380.2 сая төгрөгийг Тогтворжуулалтын санд бүрэн төвлөрүүллээ.

3.5. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл

Төсвийн зээлийн 2013 оны эхний үлдэгдэл 44.3 тэрбум төгрөг байснаас тайлант онд 15.1 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж, жилийн эцсийн байдлаар 29.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шинээр батлагдсан Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн зээлийг зөвхөн аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт Засгийн газрын тогтоол, шийдвэрийг үндэслэн олгохоор заагдсан тул шинээр төсвөөс зээл асуудал хумигдаж, 2013 онд зөвхөн 1 аймагт төсвийн зээл олгосон байна.

Улсын төсвөөс шинээр олгосон зээл:

- Засгийн газрын 2012 оны 149 дүгээр тогтоолын дагуу Дорноговь аймгийн Сайншанд, Иххэт сумд дахь "Чандмань илч" ХХК-ийн харъяа дулааны станцад шинээр зуух суурилуулах болон зарим тоног төхөөрөмжид засвар хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрт зориулж 740.0 сая төгрөгийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээг байгуулан аймгийн ЗДТГ-т олгосон.

Улсын төсвөөс олгосон зээлийн 2013 онд хийгдсэн эргэн төлөлтүүд:

- "Зээл олгох тухай" Засгийн газрын 2012 оны 66 дугаар тогтоолын дагуу Ховд аймгийн дулаан хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд "Бадамлах дөл" ХХК-ийн зуухны засвар хийх, нүүрс татан авч нөөцлөхөд зориулан 500.0 сая төгрөг олгосноос гэрээнд заасан хуваарийн оны эхнээс өссөн дүнгээр 500.0 сая төгрөг хугацаанд нь эргүүлэн төлж дууссан байна;
- Засгийн газрын 2012 оны 86 дугаар тогтоолыг үндэслэн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудын 2012-2013 оны "Нүүрсний аюулгүйн нөөц" бүрдүүлэхэд зориулан ЭБЭХЯ-нд олгосон зээлийн эргэн төлөлт оны эхнээс өссөн дүнгээр 2,963.8 сая төгрөг төлөгдөж 2013 оны 6 дугаар сард нийт зээлийг бүрэн төлж дууссан байна;
- Засгийн газрын 2011 оны 365 дугаар тогтоолыг үндэслэн Улсын нөөцөд хүнсний улаан буудай худалдан авахад зориулан улсын төсвөөс 35.0 тэрбум төгрөгийн хүүгүй зээлийг Тариалан эрхлэлтийг дэмжих санд олгосноос оны эхнээс өссөн дүнгээр 9,257.8 сая төгрөгийг төвлөрүүлж зээлийг бүрэн төлж дуусгалаа;
- 2002 онд баруун 3 аймгийн эрчим хүчний тасалдалтыг арилгах, төсвийн цаг зуурын хүндрэлийг даваxад дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Ховд аймгийн ЦТС-д 200.0 сая төгрөг олгосноос 2013 онд төлөгдөх хуваарийн дагуу нийт 106.3 сая төгрөг төвлөрүүлж 72.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна;
- 2007 онд батлагдсан "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай" Монгол Улсын хуулийн дагуу нийт 26-н хадгаламж зээлийн хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн хадгаламж эзэмшигчдийн хохирлын тодорхой хэсгийг төрөөс барагдуулахаар 36.1 тэрбум төгрөгийн зээл олгосноос оны эхнээс өссөн дүнгээр 500.0 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдэж 20,600.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна;
- Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолыг үндэслэн Дорнод аймгийн засаг даргын тамгын газрын барилгын хөрөнгө оруулалтын эх үүсвэрт зориулан барилгын ажлын гүйцэтгэлээр эхний шатны санхүүжилт болох 438.38 сая төгрөг олгосныг бүрэн буцаан төлж барагдуулсан байна.
- Засгийн газрын 2012 оны 149 дүгээр тогтоолын дагуу Дорноговь аймгийн Сайншанд, Иххэт сумд дахь "Чандмань илч" ХХК-ийн харъяа дулааны станцад

шинээр зуух суурилуулах болон зарим тоног төхөөрөмжид засвар хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрт зориулж 740.0 сая төгрөгийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгосныг эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн буцаан төлж дууссан байна;

- Баян-Өлгий аймгийн ЗДТГ-т 2002 онд олгосон 180.4 сая төгрөгийн орон сууцны хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс 45.1 сая төгрөгийг, 2002 онд олгосон цахилгаан дулааны хүндрэлийн хугацаа хэтэрсэн зээлээс 66.0 сая төгрөгийг УТ-өөс тухайн аймагт олгох байсан санхүүгийн дэмжлэгээс суутган авч хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажилласан байна.
- Говь-Алтай аймгийн ЗДТГ-т 2002 онд төсвийн дэмжлэг хэлбэрээр олгосон 100.0 сая төгрөг, Хүрхрээгиййн услалтын системийг шинэчлэн сайжруулахад зориулж олгосон 20.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг УТ-өөс тухайн аймагт олгох байсан санхүүгийн дэмжлэгээс суутган авч хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажилласан байна;
- Засгийн газрын 2012 оны 31 дүгээр тогтоолыг үндэслэн цахим мэдээллийн ялтас бүхий дипломат, албан паспорт хэвлүүлэх зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт зориулан Гадаад харилцааны яаманд олгосон зээлийн үлдэгдэл 295.3 сая төгрөгийг бүрэн төлж барагдуулсан байна;

Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээлийн авлага барагдуулах ажлыг гүйцэтгэлүүлэхээр Шинэ Эрин ТББ-тай гэрээ байгуулан ажилласан бөгөөд тус байгууллагад шилжүүлсэн зээлүүдээс 2013 онд эргэн төлөлт хийгдээгүй болно.

Хүснэгт 27. Улсын төсвөөс олгосон зээлийн гүйцэтгэл

№	Байгууллага	Эхний үлдэгдэл	Шинээр олгосон зээл	Хорогдсон	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл
1	Услалтын системийн сэргээн засварлалт	267.9	0.0	0.0	0.0	267.9
2	Бөөний худалдааны сүлжээ	388.8	0.0	2.4	0.0	386.4
3	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	280.4	0.0	111.1	0.0	169.3
	- цахилгаан дулааны хүндрэл	100.0	0.0	66.0	0.0	34.0
	- орон сууцны зээл	180.4	0.0	45.1	0.0	135.3
4	Говь-Алтай аймгийн ЗДТГ	120.0	0.0	120.0	0.0	0.0
	- төсвийн дэмжлэг	100.0	0.0	100.0	0.0	0.0
	- Хүрхрээгийн услалтын систем	20.0	0.0	20.0	0.0	0.0
5	Ховд аймгийн ЗДТГ	678.7	0.0	606.4	0.0	72.3
	- цахилгаан дулааны хүндрэл	178.7	0.0	106.4	0.0	72.3
	- Бадамлах дөл	500.0		500.0	0.0	0.0
6	Цахилгаан дулааны хүндрэл, Увс аймгийн ЗДТГ	150.0	0.0	150.0	0.0	0.0

7	ХЗДХЯам	21,100.7	0.0	500.0	0.0	20,600.7
8	Эрчим хүчний яам	2,963.9	0.0	2,963.9	0.0	0.0
	- 2012-2013 оны нүүрсний нөөц бүрдүүлэхэд	2,963.9	0.0	2,963.9	0.0	0.0
9	Гадаад харилцааны яам	251.2	0.0	295.4	44.2	0.0
10	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	9,257.8	0.0	9,257.8	0.0	0.0
11	Сүхбаатар аймгийн тэжээлийн нөөц	20.0	0.0	0.0	0.0	20.0
12	Дорнод аймгийн ЗДТГ	438.4	0.0	438.4	0.0	0.0
13	Дорноговь аймгийн ЗДТГ		740.0	740.0	0.0	0.0
14	Шуудан цахилгаан холбооны газар, ЭБЭХЯам	106.6	0.0	0.0	0.0	106.6
15	Саалийн фермийн зээл	50.1	0.0	0.0	0.0	50.1
16	Уринш боловсруулах аж ахуйн нэгжүүд	1.7	0.0	0.0	0.0	1.7
17	Мах тос бэлтгэлийн компани	172.8	0.0	0.0	0.0	172.8
18	"Бөхөг" ХХК	70.0	0.0	0.0	0.0	70.0
19	Гурилын үйлдвэрүүдэд олгосон зээл /хүүгүй/	628.5	0.0	0.0	0.0	628.5
20	Налайхын уурхай	20.0	0.0	0.0	0.0	20.0
21	"Төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ	2,722.4	0.0	0.0	0.0	2,722.4
22	Ховдын цементийн үйлдвэр	100.0	0.0	0.0	0.0	100.0
23	Нийтийн тээврийн байгууллага	1,038.2	0.0	0.0	0.0	1,038.2
24	Цаасны Монгол Оюу компани	11.7	0.0	0.0	0.0	11.7
25	Улс төрийн хэлмэгдэл судлалын төв	4.0	0.0	0.0	0.0	4.0
26	Нефть импорт концерн	2,711.0	0.0	0.0	0.0	2,711.0
27	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	253.2	0.0	0.0	0.0	253.2
28	Эрчим хүч уул уурхайн салбар	502.0	0.0	0.0	0.0	502.0
29	Бусад	53.6	0.0	0.0	0.0	53.6
Нийт		**44,363.6**	**740.0**	**15,185.3**	**0.0**	**29,962.5**

3.6. Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь заалтын дагуу нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны тайланг гаргалаа. 2013 онд нэмэлт төсвийн 179.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөнөөс 166.9 тэрбум төгрөгийн зарцуулалт гарсан байна. Нийт зарлагаас 48 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Зураг 20. Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл, тэрбум төгрөг



Эх үүсвэр

Нэмэлт төсвийн хүрээнд 2013 онд 179.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн ба үүний 27 хувь буюу 48 тэрбум төгрөг нь дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарисан хөрөнгө, 26 хувь буюу 46.8 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж, 21 хувь буюу 37 тэрбум төгрөг нь төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 18 хувь буюу 31.7 тэрбум төгрөг нь ЗГНХ, засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 5 хувь буюу 9.5 тэрбум төгрөг нь төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон батлагдсан ЗГ хоорондын гэрээ болон ОУБ-аас авах хөнгөлөлттэй зээл, 4 хувь буюу 6.4 тэрбум төгрөг нь төсвийн урамшууллаас бүрдсэн байна.

Зарцуулалт

Нэмэлт төсвийн нийт зарлагын 97 хувь буюу 162.1 тэрбум төгрөгийг урсгал зардлын дүн эзэлж байгаа бол үлдсэн 3 хувь буюу 4.8 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна. Урсгал зардлын 9 хувь буюу 14.7 тэрбум төгрөгийг татаас, шилжүүлэг хэлбэрээр, 5 хувь буюу 7.5 тэрбум төгрөгийг цалин болон түүнтэй холбогдох зардалд, үлдсэн 86 хувь буюу 140 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

4. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВИЙН 2013 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 20.1, 20.2 дахь зүйлд заасан үндэслэл, шаардлагын дагуу Хүний хөгжил сангийн 2013 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг боловсрууллаа.

Хүний хөгжил сангийн тухай хууль 2009 онд батлагдан гарснаар Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээх үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд энэ арга хэмжээнд бэлэн мөнгө, оюутны сургалтын төлбөр, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэл, орон сууцны үнийн төлбөр хэлбэрээр нийт 1.5 орчим их наяд төгрөгийг зарцуулжээ.

“Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль”, “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2012 оны 51 дүгээр тогтоолын хүрээнд Хүний хөгжил сангаас хишиг, хувь олгох үйл ажиллагааг 2013 онд зохион байгуулсан.

Энэ арга хэмжээний хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 0-18 насны хүүхэд бүрт сар бүр олгох 20.0 мянган төгрөгт зориулж Хүний хөгжил сангийн төсөвт нийт 240 тэрбум төгрөг батлагдсан. Хүний хөгжил сангийн өмнө нь авсан урьдчилгаа төлбөр, Засгийн газрын бондын өглөгийг сангийн үйл ажиллагааны тэнцлээс барагдуулсан.

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 20.2-т зааснаар тус сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд дараах зүйлийг заавал тусгахаар хуульчилсан байдаг. Үүнд:

- Сангийн хөрөнгө оруулалтын жишиг багц, түүний хэрэгжилтийн тухай;
- Сангийн хөрөнгийг менежментийн гэрээний дагуу удирдаж байгаа олон улсын санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга;
- Сангийн хөрөнгийн эрсдлийн удирдлагын тухай;
- Сангийн санхүүгийн байдлын тухай;
- Сангийн хөрөнгийн зарцуулалтын тухай

Хүний хөгжил санд санхүүгийн хөрөнгийн хуримтлал үүсч, санхүүгийн хөрөнгө оруулалт хийх, менежментийн гэрээ байгуулан олон улсын санхүүгийн байгууллагаар энэ үйл ажиллагааг гүйцэтгүүлэх нөхцөл бүрдээгүй учир дээрх жагсаалтын 2 дахь заалт дахь мэдээллээс бусад хуульд заасан хүний хөгжил сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд тусгав.

4.1. Хүний хөгжил сангийн эрсдэлийн удирдлага ба санхүүгийн байдал

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8.1-т “Сангийн хөрөнгийн ерөнхий удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ” гэж, мөн хуулийн 14.1-т “Сангийн хөрөнгийн эрсдлийн удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байдаг.

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөө тасарсанаас санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 38.1.7-т заасныг баримтлан улсын төсөвт өглөг үүсгэх замаар бүрдүүлж санхүүжүүлсэн. Мөн үүссэн өглөгийг тухайн сард нь хаах зарчим баримтлан ажиллаж ирлээ. 2013 онд улсын төсөвт нийт дүнгээр 148.4 тэрбум төгрөгийн өглөг үүсгэж, өглөгийг бүрэн барагдуулсан. Тухайлбал, сар бүр хүүхдийн мөнгө олгоход эх үүсвэр дутагдаж, Улсын төсөвт өглөг үүсгэн зохицуулалтыг хийж, Хүний хөгжил сангийн зарлага, санхүүжилтийг тасалдуулахгүй гүйцэтгэсэн. Хүний хөгжил сангийн төсвийн орлого төлөвлөгөөний дагуу төвлөрөхгүй байх шалтгааныг уул уурхайн салбарын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр Хүний хөгжил санд төвлөрөх орлого тасалдсантай холбон үзэж байна.

Нөгөөтэйгүүр Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх явцад үүсч болзошгүй эрсдэл, орлого, эх үүсвэрийн дутагдлыг урьдчилан тооцож ажилласан. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн орлого эхний 9 сарын байдлаар 86.8 тэрбум төгрөгөөр тасарсан. Мөн Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулсанаар төвлөрөхөөр тооцсон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн 154.9 тэрбум төгрөгийн орлого төсөвт төвлөрөөгүй зэрэг шалтгаанаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2013 оны нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал ДНБ-ний -6.8 хувьд хүрэхээр тооцоо гарсан. Төсвийн тухай хуулийн 34.1.2 зүйлийг үндэслэн төсвийн тодотголын төслийг боловсруулж Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлсэн. Үүний дагуу Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан.

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тус сангийн нийт орлого, эх үүсвэр 397.5 тэрбум төгрөг, нийт зарлага 282.8 тэрбум төгрөг байхаар батлагдсан.

Зураг 21. ХХС-гийн 2013 оны орлогын динамик, сараар, тэрбум төгрөг



Зураг 22. ХХС-гийн 2013 оны төсвийн зарлагын динамик, сараар, тэрбум төгрөг



Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн төлөвлөгөөгөөр урьдчилгаа төлбөрийг хаахад нийт 62.4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 76.5 тэрбум төгрөг буюу "Оюу Толгой" ХХК-ийн урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл төлбөрөөс тус компанийн татварын өрийг суутгах байдлаар нийт 40.6 тэрбум төгрөг, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн татварын нийт 35.9 тэрбум төгрөгийн өр, төлбөрийг урьдчилгаа төлбөрөөс суутган тооцож бууруулсан.

Хүний хөгжил сангийн тухай хуульд Хүний хөгжил сангийн орлого, зарлагын зөрүүг нөхөх зориулалтаар Засгийн газрын үнэт цаас гаргахаар өөрчлөлт 2012 онд оруулсан. Үүний дагуу Хүний хөгжил сангийн төсвийн сар, улирлын чанартай алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Сангийн сайдын 2013 оны 256 дугаар тушаалын дагуу 55.6 тэрбум төгрөгийн богино хугацаат Засгийн газрын үнэт цаасыг 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр арилжааны банкуудад арилжаалж, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн.

Уг Засгийн газрын үнэт цаас арилжсаны эх үүсвэрээр "Засгийн газрын үнэт цаас гаргах тухай" УИХ-ын 2012 оны 64 дүгээр тогтоолын дагуу НДЕГ-т арилжсан Засгийн газрын 1 жилийн хугацаатай 108.1 тэрбум төгрөгийн үнэт цаасны эргэн төлөлтийг санхүүжүүлсэн.

4.2 Хүний хөгжил сангийн бүрдүүлэлт, зарцуулалт

Хүний хөгжил сангийн 2013 оны батлагдсан төсөв

Улсын Их Хурлаас Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн орлого, зарлага, эх үүсвэрийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 28. Хүний хөгжил сангийн 2013 оны батлагдсан төсөв, сая төгрөг

1. Нийт орлого		**397,580.8**
1.1.	Хүний хөгжил сангийн тухай хууль (ХХСТХ)-ийн 3.2.1-д заасан орлого (Ногдол ашиг, хувьцаа борлуулсан орлого)	68,305.6
1.2.	ХХСТХ-ийн 3.2.2-д заасан орлого (Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг)	329,275.2
1.3.	ХХСТХ-ийн 3.2.3-д заасан орлого, (ХО-ын цэвэр ашиг)	0.0
2. Нийт зарлага		**282,799.5**
2.1.	Тэтгэврийн болон ЭМД-ын шимтгэлийн төлбөрт	12,151.5
	2.1.1. ЭМД-ын шимтгэл	12,151.5
2.2.	Бэлэн мөнгө	262,000.0
	2.2.1. Хүүхдэд олгох мөнгө	234,000.0
	2.2.2. Сар бүр олгох 21 мянган төгрөг	28,000.0
2.3.	Зээлийн үйлчилгээний төлбөр	8,648.0
3. Ашиг, алдагдал		**114,781.3**
4. Алдагдалыг санхүүжүүлэх эх үүсвэр		**-114,781.3**
4.1.	Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	0.0
4.2.	ХХСТХ-ийн 3.2.4-д заасан эх үүсвэр, (Урьдчилгаа төлбөр)	-62,397.0
4.3.	Засгийн газрын бонд	-52,384.3
	4.3.1. Шинээр гаргах	55,715.7
	4.3.2. Үндсэн төлбөр	-108,100.0

Улсын Их Хурлаас Хүний хөгжил сангийн төсөвт 2013 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 621,368.7 сая төгрөгөөр, Хүний хөгжил сангийн төсвөөс 2013 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 284,151.5 сая төгрөгөөр баталж, Хүний хөгжил санд 2013 оны төсвийн жилд хуримтлуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг 49,795.0 сая төгрөг байхаар баталсан[3]. Дээр өгүүлсэнчлэн нэгдсэн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, гадаад болон дотоод эдийн засгийн нөхцөл байдал, экспортод гарах эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээ буурсан зэрэг шалтгаанаар төсвийн орлого тасалдахад хүрсэн ба төсвийн тодотгол хийх зайлшгүй нөхцөл үүссэн. Ингэснээр Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн орлогыг оны эхэнд төлөлөсөн хэмжээнээс даруй 223.8 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нийт орлого, эх үүсвэр 397.5 тэрбум төгрөг, нийт зарлага 282.8 тэрбум төгрөг байхаар батлагдсан.

Хүний хөгжил сангийн 2013 оны төсөвт 0-18 насны хүүхэд бүрт сар бүр олгох 20.0 мянган төгрөг, сар бүр олгох 21.0 мянган төгрөгөө өмнө нь аваагүй үлдсэн иргэдэд нөхөж олгоход тус тус хөрөнгө зарцуулахаар төлөвлөгдсөн.

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн гүйцэтгэл

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиар нийт Хүний хөгжил санд 397.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 393.5 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 99.0 хувийн биелэлттэй гарсан байна. Үүнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 325.0 тэрбум төгрөг, ногдол ашгаар 68.3 тэрбум төгрөг төвлөрчээ. Харин Хүний хөгжил

[3] Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль, 2012.11.08-ны өдөр (http://www.legalinfo.mn/law/details/8819?lawid=8819)

сангаас санхүүжүүлсэн нийт зардлын хэмжээ 278.3 тэрбум төгрөг буюу төлөвлөсөн хэмжээнээс 1.6 хувиар бага гарсан байна.

Хүснэгт 29. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн гүйцэтгэл, сая төгрөг

		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Нийт орлого		**397,580.80**	**393,535.00**	**99.0%**
1.1.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	329,275.20	325,038.90	98.7%
1.2.	Хувьцааны ногдол ашиг	68,305.60	68,305.60	100.0%
1.3	Банкны хүүгийн орлого	-	190.4	
2. Нийт зарлага		**282,799.50**	**278,339.60**	**98.4%**
2.1	Төр хариуцах ЭМД-ын шимтгэл	12,151.50	12,151.50	100.0%
2.2	Иргэдэд олгох бэлэн мөнгө	262,000.00	257,607.50	98.3%
	2.2.1. Хүүхдэд олгох мөнгө	234,000.00	228,994.34	97.9%
	2.2.2. Сар бүр олгох 21 мянган төгрөг	28,000.00	28,613.14	102.2%
2.3	Зээлийн үйлчилгээний төлбөр	8,648.00	8,580.40	99.2%
2.4	Банкны үйлчилгээний хураамж	-	0.2	
3. Ашиг, алдагдал		**114,781.30**	**115,195.40**	**100.4%**
4. Алдагдалыг санхүүжүүлэх эх үүсвэр		**-114,781.30**	**-115,195.40**	100.4%
4.1.	Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-	13,771.40	
4.2.	ХХСТХ-ийн 3.2.4-д заасан эх үүсвэр (Урьдчилгаа төлбөр)	-62,397.00	-76,540.20	146.4%
4.3.	ЗГ-ын бонд	-52,384.30	-52,426.60	100.1%
	4.3.1. Шинээр гаргах	55,715.70	55,673.40	99.9%
	4.3.2. Үндсэн төлбөр	-108,100.00	-108,100.00	100.0%

Хүний хөгжил сангаас 2013 онд төр хариуцах иргэний ЭМД-ын шимтгэлд 12.1 тэрбум төгрөг, 21 мянган төгрөгөө өмнө нь аваагүй иргэдэд нөхөн олгоход 28.6 тэрбум төгрөг, Засгийн газрын бондын хүүгийн төлбөрт 8.5 тэрбум төгрөг, 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр олгох 20 мянган төгрөгт 228.9 тэрбум төгрөг тус тус зарцууллаа.

Хүний хөгжил сангийн нийт зарлага, санхүүжилт 2013 онд төлөвлөсөн хэмжээнд буюу 98.4 хувийн биелэлттэй гарсан байна. Мөн нийт орлогын төлөвлөгөөний биелэлт 99.0 хувь гарсан байна. 2012 оны эцэст Нийгмийн даатгалын санд арилжсан Засгийн газрын бондын үндсэн төлбөр 108.1 тэрбум төгрөгийг буцаан төлсөн бөгөөд шинээр 55.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын хямдруулсан үнэт цаасыг арилжааны банкуудад арилжаалсан.

Орлого: Хүний хөгжил санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр төвлөрөх орлого 329.2 тэрбум төгрөг төлөвлөсөнөөс 325.0 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 98.7 хувийн биелэлттэй гарсан байна. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тодотголоор орлогын хэмжээ 282.8 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. Үүнд: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр төвлөрөх орлогыг 67.2 тэрбум төгрөгөөр, оны эхэнд Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулсанаар нэмэгдэж орох 154.9 тэрбум төгрөгөөр бууруулсан.

Ашигт малтмалын нөөц ашигласны болон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн хувьд дэлхийн зах зээл дэх гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүний үнийн бууралт,

тоо хэмжээний бууралтаас хамааран оны эхэнд төлөвлөж байсан хэмжээнээс бууруулж тооцсон.

Уул уурхайн салбараас орох татварын орлогын хэмжээ 2012 онтой харьцуулахад 2013 онд 20.3 хувиар өссөн байна. 2009-2012 оны уул уурхайн татварын орлогын гүйцэтгэл болон 2013 оны гүйцэтгэлийн мэдээг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 30. Уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого, тэрбум төгрөг

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл					Нийт
		2009	2010	2011	2012	2013	
1	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	186.5	423.1	55.8	0.05		**665.5**
2	Агаарын бохирдлын төлбөр*	-	-	19.8	24.1	23.4	**67.3**
3	АМНАТ	107.9	168.9	204.9	310.7	503.6	**1280.5**
4	ӨСНАТ**	-	-	177.7	127.1		**304.8**
5	ААНОАТ	96.1	278.9	318.9	159.2	296.20	**1149.3**
6	Ногдол ашиг	-	-	78.9	141.2	68.3	**288.4**
7	Бусад	15.5	449.4	262.4	81.9	183.69	**992.9**
БҮГД ДҮН		**406**	**1320.3**	**1118.4**	**844.3**	**1,075.19**	**4,748.7**

* Агаарын бохирлын төлбөрийн тухай хууль 2010.06.24-ний өдөр батлагдан 2011 оноос орлого төвлөрсөн. ** Ашигт малтмалын тухай хуульд 2010 онд нэмэлт орсноор ашигт малтмалын үнийн хэлбэлзлээс хамааран ногдуулах нэмэлт төлбөр

Хүснэгт 31. Уул уурхайн салбарын орлогоос ХХС-д төвлөрсөн орлого, тэрбум төгрөг

№	Үзүүлэлт	Үүнээс ХХС-нд хуваарилагдах					Нийт
		2009	2010	2011	2012	2013	
1	АМНАТ	75.53	118.23	143.43	217.49	195.88	750.56
2	ӨСНАТ**			124.39	88.97	129.15	342.51
3	Ногдол ашиг	-	-	78.9	141.2	68.3	288.4
4	Бусад						0.0
БҮГД ДҮН		**75.53**	**118.23**	**346.72**	**447.66**	**393.33**	**1,381.47**

Хүний хөгжил санд 2013 онд “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-иас ногдол ашгийн орлого нийт 68.3 тэрбум төгрөг төвлөрүүлжээ.

Зарлага: Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль, “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2012 оны 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгийг олгох журам”-ыг баримтлан Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө хэлбэрээр хишиг, хувь хүртээх үйл ажиллагааг зохион байгууллаа.

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиар дараах хэлбэрээр хишиг, хувь хүртээхээр баталсан. Үүнд:

- Төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр,

- Бэлэн мөнгө,
- Төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр,

Хүний хөгжил сангаас 2013 онд Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт 12,151.5 сая төгрөг зарцуулсан ба төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх хэсэгт 16 хүртэлх насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, хүүхдээ 2 нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх, хугацаат цэргийн албан хаагч, нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Хүний хөгжил сангийн төсвөөс Эрүүл мэндийн даатгалын санд төлөхөөр хуульчилсан байдаг.

Хүний хөгжил сангаас төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэл хүртсэн иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн талаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 32. Төр хариуцах ЭМД-ын шимтгэл хүртсэн хүний тоо, хөрөнгийн хэмжээ

Үзүүлэлт		**2013 он**		
Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын төрөл		**Даатгуулагч, тоо**	**Шимтгэлийн хувь, хэмжээ**	**Санхүүжилт /сая төг/**
Үүнээс:	16 хүртэлх насны хүүхэд	869,075	Сарын 670, жилийн 8040 төгрөг	8,001.64
	Өндөр насны тэтгэвэр авагч	231,679		2,160.97
	Хүүхдээ асарч буй эх	56,011		436.49
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	57,676		404.63
	Хугацаат цэргийн албан хаагч	5,262		33.29
	Халамжийн тэтгэвэр авагч	29,135		234.34
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч	19,637		24.14
	Их дээд сургуулийн өдрийн ангийн суралцагч	120,439		855.96
Нийт		**1,388,914**		**12,151.5**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2013 оны тайлан

** ЭМД-ын шимтгэлийн 2013 оны хэмжээг тогтоосон (ЗГ-ын 2012 оны 195-р тогтоол)*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2013 оны тайлангийн мэдээгээр 16 хүртэлх насны хүүхэд, өндөр насны тэтгэвэр авагч, хүүхдээ асарч буй эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат цэргийн албан хаагч, халамжийн тэтгэвэр авагч, их, дээд сургуулийн өдрийн ангийн суралцагчид нийт 1.3 сая иргэн Хүний хөгжил сангаас эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр нийт 12.1 тэрбум төгрөгийн хишиг, хувь хүртсэн байна.

Бэлэн мөнгө

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль, УИХ-ын 2012 оны 51 дүгээр тогтоолоор бэлэн мөнгө хэлбэрээр сар бүр өмнө нь олгосон 21 мянган төгрөгийг аваагүй иргэдэд нөхөн олгоход зориулж 28.0 тэрбум төгрөг батлагдсан. Мөн 0-18 насны хүүхэд бүрт сар бүр олгох 20 мянган төгрөгт 234 тэрбум төгрөг Хүний хөгжил сангийн 2013 оны төсөвт тусгагдсан.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын мэдээгээр 2013 онд 960,279 хүүхдэд 20 мянган төгрөгийг олгоход нийт 228.9 тэрбум төгрөг, 21.0 мянган төгрөгийг нөхөж олгоход нийт 263,462 иргэнд 28.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 33. Бэлэн мөнгөөр хишиг, хувь хүртээсэн байдал, сая төгрөг

Үзүүлэлт	Хүний тоо, мян.хүн	Зарцуулсан хөрөнгө
Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан	2797.0	-
2010 онд хуваарилагдсан 70 мянган төгрөг	41.0	2,871.1
2010 онд хуваарилагдсан 50 мянган төгрөг	243.0	12,150.9
2011 онд хуваарилагдсан 21 мянган төгрөг /сар бүр/	2734.6	689,118.4
Үүнээс: ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтын зориулалтаар бөөнөөр авсан	9.7	1,631.4
2012 онд хуваарилагдсан 21 мянган төгрөг /1-5-р сард 21 мянга, 6-р сард 23 мянган төгрөг*/	2823.9	375,479.7
Үүнээс: ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтын зориулалтаар бөөнөөр авсан	808	0.08
2013 онд 21 мянгөн төгрөгөө нөхөж авсан нь	263.5	28,613.13
Монгол Улсын харьяатаас гарч сүүлийн жилийн хишиг, хувийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж авсан**	4	-
Чингэлтэй дүүрэг	3	0.2
Баянзүрх дүүрэг	1	0.7

Эх сурвалж: Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар

4.3. Хүний хөгжил сангийн удирдлага, зохион байгуулалт

Хүний хөгжил сангийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх ажлын хүрээнд Хүний хөгжил сангийн өнөөгийн тогтолцоог өөрчилж боловсронгуй болгох холбогдох хуулийн төслийг боловсруулж ажиллалаа. Хүний хөгжил сан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүүхдийн мөнгө олгох, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хураамжийг төлөх зэрэг санхүүгийн үүргийг хүлээж байна. Олон улсад тогтсон баялгийн сангийн нийтлэг хэм хэмжээ, туршлагад үндэслэн Монгол Улсад баялгийн сангийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд одоогийн байгаа зохицуулалтыг өөрчилж, баялгийн сангийн нийтлэг тогтолцоог бүрдүүлэх, шинэчлэх шаардлага гарч байна.

Хүний хөгжил санд өмнө нь авсан урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл төлбөрийг буцаан төлөх, Хүний хөгжил сангийн өглөгийг эхний ээлжинд барагдуулах, цаашид байгалийн шавхагдах баялгийг ирээдүй хойч үедээ тэгш шударга хуваарилах үндсэн үзэл санааны хүрээнд байнгын өсөн нэмэгдэх санхүүгийн нөөц хэлбэрээр хуримтлал бий болгох, ирээдүйд үүсэх санхүүгийн хэрэгцээг уг эх үүсвэрээс нөхөн санхүүжүүлэх зэрэг ирээдүйд санхүүгийн баталгаа бий болгох урт хугацааны бодлого, төлөвлөлтийн шинж чанартай ажлууд хийгдэж байна.

5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН 2013 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Нийгмийн даатгалын санд төлөвлөснөөс 46,9 тэрбум төгрөг илүү хуримтлуулж, орлогын төлөвлөгөөг 104,8 хувиар давуулан, зарлагыг батлагдсан төсөвт багтаан зарцууллаа.

2012 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Улсын Их Хурлаар батлагдсан "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай" хуулийг 2013 оны 1 дүгээр сарын 1 нээс эхлэн хэрэгжүүлж өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар 1990-1995 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцох, 1995-2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй 498 мянган иргэдийг тухайн онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлүүлснээр нийгмийн даатгалын 29.4 тэрбум төгрөг хуримтлагдсан байна.

5.1. Орлогын гүйцэтгэл

Хүснэгт 34. НДС-гийн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг

Нийгмийн даатгалын сан	2012 он	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Давсан	
		Орлого	Нийтэд эзлэх хувь	Орлого	Нийтэд эзлэх хувь	Дүн	Хувь
Тэтгэврийн	446,7	606,0	62,4	634,8	62,3	29,0	4,8
Тэтгэмжийн	32,5	68,9	7,1	67,3	6,6	-1,6	-2,3
ҮОМШӨ-ний	53,4	73,2	7,5	86,6	8,5	13,5	18,4
Ажилгүйдлийн	35,4	21,1	2,2	25,7	2,5	4,7	22,2
Эрүүл мэндийн	152,2	202,3	20,8	204,0	20,1	1,8	0,9
НИЙТ	720,2	971,5	100,0	1018,4	100	47,3	4,9

5.2. Зарлагын гүйцэтгэл

Нийгмийн даатгалын 5 сангаас даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуулийн дагуу хугацаанд нь олгожээ.

Хүснэгт 35. НДС-ын зарлагын гүйцэтгэл, тэрбум төгрөг

Нийгмийн даатгалын сан	**2012 он**	**Төлөвлөгөө**		**Гүйцэтгэл**		**Давсан**	
		Зарлага	**Нийтэд эзлэх хувь**	**Зарлага**	**Нийтэд эзлэх хувь**	**Дүн**	**Хувь**
Тэтгэврийн	722.5	829.3	77.66	826.4	78.10	2.9	0.35
Тэтгэмжийн	42.6	57.5	5.38	58.7	5.55	-1.2	-2.09
ҮОМШӨ-ний	28.5	34.3	3.21	31.4	2.97	2.9	8.45
Ажилгүйдлийн	7.7	15.3	1.43	16.1	1.52	-0.8	-5.23

Эрүүл мэндийн	117.4	131.4	12.31	125.5	11.86	5.9	4.49
Нийт	918.7	1067.8	100.00	1058.1	100.00	9.7	0.91

Нийгмийн даатгалын 5 сангийн зарлагаас тэтгэмжийн даатгалын сан 2,09 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 5,23 хувиар тус тус төлөвлөгөөг хэтрүүлсэн, бусад 3 сан 0,35-8,45 хувиар хэмнэгдсэн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зарлага

2013 онд тэтгэврийн даатгалын сангаас өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй, тэжээгчээ алдсан 307,1 мянган тэтгэвэр авагчид 3 төрлийн тэтгэвэрт 810,5 тэрбум төгрөг зарцуулав.

Тэтгэвэр авагчийн тоо, зарцуулсан хөрөнгийг өмнөх он, төлөвлөгөөтэй харьцуулбал:

Хүснэгт 36. Тэтгэвэр авагчийн тоо ба зарцуулсан хөрөнгө, мянган хүн, тэрбум төгрөг

Тэтгэврийн төрөл	2012 он	2013 он	Өсөлт+, бууралт-		2013 он		Өсөлт+ , Бууралт-	
	Хүний тоо		Дүн	Хувь	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Дүн	Хувь
Өндөр насны	210,9	217,7	+6,8	3,2	591,2	593,3	-2,1	3,5
Тахир дутуугийн	50,5	51,3	+0,8	1,6	101,9	98,9	3	2,9
Тэжээгчээ алдсаны	23,9	22,5	-1,4	5,8	48,5	45,7	2,8	5,8
Цэргийн	14,9	15,6	-0,7	4,7	71,2	72,6	-1,4	1,9
НИЙТ	300,1	307,1	7,0	2,3	812,8	810,5	2,3	0,3

Нийт тэтгэвэр авагчдын 44,1 хувь буюу 135,6 мянган иргэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага

Тэтгэмжийн даатгалын сангаас 162,5 мянган даатгуулагчдад 58,7 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олголоо.

Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийг харуулбал:

Хүснэгт 37. Тэтгэмж авагчийн тоо ба зарцуулсан хөрөнгө, мянган хүн, тэрбум төгрөг

Тэтгэмжийн төрөл	Хүний тоо				2013 он			
	2012 он	2013 он	Өсөлт, бууралт	%	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Өсөлт, бууралт	%
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	98,9	104,4	+5,5	5,6	10,6	10,2	0,4	3,7
Жирэмсний	38,5	45,7	+7,2	18,	42,3	44,7	-2,4	5,7

болон амаржсаны				7				
Оршуулгын тэтгэмж	12,9	12,4	-0,5	3,9	4,5	3,7	0,8	17,7
НИЙТ	**150,3**	**162,5**	**12,2**	**8,1**	**57,4**	**58,6**	**-1,2**	**2,1**

Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага даатгуулагчийн дундаж цалингийн өсөлт, төрөлт нэмэгдсэнээс шалтгаалан 1,2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага

2013 онд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 6.5 мянган тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 26,9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1,0 мянган хүний тэтгэмжид 0,5 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон рашаан сувиллын зардалд 0,9 тэрбум төгрөгийг 4,6 мянган даатгуулагчдад, тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд 0,8 тэрбум төгрөгийг тус тус уг сангаас санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 38. ҮОМШӨ-ний даатгалын зарлага, мянган хүн, тэрбум төгрөг

Төрөл	**Хүний тоо**				**2013 он**			
	2012 он	**2013 он**	**Өсөлт, бууралт**	**%**	**Төлөвлөгөө**	**Зарцуулсан хөрөнгө**	**Өсөлт, бууралт**	**%**
Тэтгэвэрт зарцуулсан хөрөнгө	6,7	6,5	-0,2	3	28,7	26,9	1,8	6,3
ХЧТА-ны тэтгэмж	0,8	1,0	+0,2	25	0,6	0,5	0,1	16,7
Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбоотой төлбөр, сувиллын зардал	4,5	4,6	-0,1	22,2	1,7	0,9	0,8	47,0
Тэтгэврийн даатгалын санд шилжүүлсэн шимтгэл					0,9	0,8	0,1	11,1
НИЙТ	**12,0**	**12,1**	**0,1**	**0,8**	**31,9**	**29,1**	**2,8**	**8,7**

Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага

Хүснэгт 39. Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага, мянган хүн, сая төгрөг

Зардал	Хүний тоо / Өсөлт+, бууралт-/				2013 он		Өсөлт, бууралт	
	2012 он	2013 он	Дүн	Хувь	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Дүн	%

Ажилгүйдлийн тэтгэмж	10,5	15,9	+5,4	51,4	13383,5	14905,4	1521,9	11,4
Сургалтын төлбөр	0,05	0,01	-0,04	80	43,8	0,05	-43,75	99,8
НИЙТ ДҮН	10,55	15,91	+5,36	50,8	13427,3	14905,45	1478,15	11,0

Тайлант онд ажилгүйдлийн тэтгэмжийг 1521,9 сая төгрөгөөр хэтрүүлсэн, сургалтын төлбөрийг 43,75 сая төгрөгөөр хэмнэсэн. Ажилгүйдлийн тэтгэмжийн өсөлт нь 2013 онд улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 35776 42772 болж өссөнтэй холбоотой.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

Эрүүл мэндийн даатгалын сангаас 3843,2 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардалд нийт 120,7 тэрбум төгрөгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцууллаа.

Хүснэгт 40. ЭМД-ын сангийн зарлага, мянган хүн, тэрбум төгрөг

Тусламж үйлчилгээ	**Хүний тоо**		**Өсөлт, бууралт**		**2013 он**		**Өсөлт, бууралт**	
	2012 он	**2013 он**	**Дүн**	**Хувь**	**Төлөвлөгөө**	**Зарцуулсан хөрөнгө**	**Дүн**	**Хувь**
Эмнэлэг, сувилал	3364,7	2988,7	-376,0	11,2	114,3	111,0	3,3	2,9
Эмийн үнийн хөнгөлөлт	706,9	854,5	+147,6	20,9	12,1	9,7	2,4	19,8
НИЙТ ДҮН	4126,4	3843,2	-283,2	6,9	126,4	120,7	5,7	4,5

Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж төлбөр тусламж авсан хүний тоо урьд оноос 283,2 мянган хүнээр буурч, олгосон хөрөнгө 5,7 тэрбум төгрөгийг хэмнэсэн.

Нийгмийн даатгалын сангаас холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн урамшуулалд 34,6 сая төгрөг, тэтгэвэр олголтын банкны үйлчилгээний хөлсөнд 135,8 сая төгрөг зарцуулав.

Нийгмийн даатгалын байгууллагын урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл

Нийгмийн даатгалын байгууллагын хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 23,8 тэрбум төгрөг зарцуулах төлөвлөгөөтэйгээс 23,3 тэрбум төгрөг зарцуулжээ.

Урсгал зарлага: Нийгмийн даатгалын байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 18376,8 сая төгрөг зарцуулахаас 18042,4 сая төгрөгийг зарцуулсан. Графикаар харуулбал:

Зураг 23. НД-ын байгууллагын урсгал зардлын бүтэц



Цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг төлөвлөгөөтэй харьцуулбал:

Хүснэгт 41. Цалин хөлс болон НД-ын шимтгэлийн зардал, сая төгрөг

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Өсөлт+, бууралт-	
			Тоогоор	Хувиар
Үндсэн цалин	11270,5	11234,7	-35,8	0,32
Гэрээт ажлын цалин	543,8	522,8	-21,0	3,87
Нийгмийн даатгалын шимтгэл	1365,9	1332,3	-33,6	2,5
Унаа, хоолны хөнгөлөлт	602,8	551,5	-51,3	8,52
НИЙТ ДҮН	13783,0	13641,3	141,7	1,02

Нийгмийн даатгалын байгууллагын дүнгээр цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал урсгал зардлын 96%-ийг эзэлж, зардлын гүйцэтгэл нь 13641,3 сая төгрөгт хүрчээ.

Хүснэгт 42. НДС-ын тогтмол зардал, сая төгрөг

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	/+/ өсөлт, /-/ бууралт	
			Тоогоор	Хувиар
Гэрэл цахилгаан	115,9	102,3	-13,6	11,7
Түлш, халаалт	427,4	357,0	-70,4	16,5
Цэвэр, бохир ус	61,1	58,7	-2,4	3,9
Байрны түрээс	186,8	202,8	+16	8,5
НИЙТ ДҮН	791,2	720,8	-70,4	8,9

Баянзүрх, Налайх дүүргийн барилгын ашиглалтын хугацаа дуусч, дахин ашиглах боломжгүй шийдвэр гарсантай холбоотой түрээсийн зардал өссөн.

Ажил олгогчоос олгох бусад тэтгэмжийн зардлыг төлөвлөгөөтэй нь харьцуулбал:

Хүснэгт 43. Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, сая төгрөг

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	/+/ өсөлт, /-/ бууралт	
			Тоогоор	Хувиар
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	390,9	389,8	-1,1	0,3
Орон байраар хангах, орон сууцны дэмжлэг	350,0	350,0	-	-
Нэг удаагийн буцалтгүй тусламж	21,7	40,2	+18,5	85,3
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	16,1	7,9	-8,2	50,9
Эмчилгээний төлбөр	15,9	4,3	-11,6	72,9
Шагнал урамшуулал	580,9	547,9	-33,0	56,8
Хуульд заасан үндэслэлээр олгох тэтгэмж	109,5	128,3	+18,8	17,2
НИЙТ ДҮН	1485,0	1468,4	16,6	1,1

Хөрөнгө оруулалт: Нийгмийн даатгалын байгууллагын батлагдсан бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу сангаас 5255,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэв.Хөрөнгө оруулалтыг төлөвлөгөөтэй нь харьцуулбал:

Хүснэгт 44. НДС-ын хөрөнгө оруулалт, сая төгрөг

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	/+/ өсөлт, /-/ бууралт	
			Тоогоор	Хувиар
Барилга байгууламж, их засвар	4213,9	4101,1	-112,9	2,7
Тоног төхөөрөмж	521,8	515,7	-6,1	1,1
Тээврийн хэрэгсэл	340,0	332,8	-7,2	2,2
Тавилга, эд хогшил	307,2	306,3	-0,9	0,3
НИЙТ ДҮН	5383,0	5255,8	-127,2	2,3

5.3. Төсвийн гүйцэтгэлийн тэнцэл

Нийгмийн даатгалын сангууд тайлант онд орлогоороо зарлагаа нөхөж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

Хүснэгт 45. НДС-ын тэнцэл, тэрбум төгрөг

Нийгмийн даатгалын сан	Орлого	Зарлага	Зөрүү
Тэтгэврийн	899,6	826,4	-73,2
Тэтгэмжийн	67,3	58,7	-8,6
ҮОМШӨ-ний	86,7	31,4	55,3
Ажилгүйдлийн	25,8	16,1	-9,7
Эрүүл мэндийн	204,1	125,6	-78,5
НИЙТ ДҮН	1283,5	1058,2	-225,3

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу эрх үүссэн даатгуулагчдын тэтгэмжийг тухайн сангийн оны эхний хуримтлагдсан үлдэгдлээс олгосон.

Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тэтгэвэр тогтоосон иргэдийн тэтгэврийг Засгийн газар хариуцах үүргийн дагуу тайлант онд 268.6 тэрбум төгрөг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлэхээс 264.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.

Дүгнэлт

- Нийгмийн даатгалын сангууд тайлант онд орлогоороо зарлагаа нөхөж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.
- 2013 онд Монгол улсын тэтгэврийн даатгалын тухай хууль, Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар гарсан иргэдийн тэтгэврийн санхүүжилтийг Сангийн яамнаас олгосон дүнг оролцуулан тооцоолсоны үндсэн дээр тэтгэврийн сангийн тэнцэл эерэг дүнтэй гарсан.
- Цаашид засгийн газраас тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээ авбал орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй эх үүсвэрийн дутагдалд орох хандлагатай.
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчиний даатгалын сан орлогоороо зардлаа нөхөөд хамгийн их хуримтлалтай.

- 2013 онд нийгмийн даатгалын байгууллага 1 төгрөгийн шимтгэлийн орлого олоход 0.02 төгрөгийн зардал гаргаж ажилласан байна. Нийгмийн даатгалын байгууллага шимтгэлийн орлогын 2.3 хувийг урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд зарцуулжээ. Өөрөөр хэлбэл 1 төгрөгийн зардлаар 43,7 төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлж байна. Ажлын ачаалал өндөр байна.нийт бүрдүүлсэн орлогодоо нийт ажиллагчдын тоог харьцуулахад 1 ажилтан албан хаагч 696.8 сая төгрөгийн орлого цуглуулж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгох анхан шатны баримтыг хянаж 723.7 сая төгрөгийн зардлыг тайлант хугацаанд олгосон байна.

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын өсөлт, даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр, тэтгэмж авагчдын хүний тооны өсөлтийн сүүлийн 2 жилийн судалгааг гаргаж НДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, аймаг, дүүрэг суманд шаардлагатай байгаа байцаагчдын орон тоо зардлыг 2015 оны төсөв төлөвлөгөөнд тусгаж ажиллах шаардлагатай байна.

6. Орон нутгийн төсвийн 2013 оны гүйцэтгэл

Орон нутгийн 2013 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 1,901.7 тэрбум төгрөгт хүрч орлогын бүрдүүлэлт 100.6 хувийн биелэлттэй, нийт зарлага 1,794.1 тэрбум төгрөгт хүрч, 87.2 хувийн гүйцэтгэлтэй гарч, урсгал тэнцэл 613.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, нийт тэнцэл 107.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Хүснэгт 46. Орон нутгийн төсвийн гүйцэтгэл, сая төгрөг

	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	ХУВЬ				ЗӨРҮҮ
			Төлөв.	Гүйцэт.	(18 : 17)	(18 : 16)	(18 - 17)
	15	16	17	18	19	20	21
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	862,754.3	1,890,009.0	1,890,009.0	1,901,668.0	100.6	100.6	11,659.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	862,754.3	1,890,009.0	1,890,009.0	1,901,668.0	100.6	100.6	11,659.0
А. УРСГАЛ ОРЛОГО	700,573.3	733,252.7	733,252.7	772,460.5	105.3	105.3	39,207.7
I. ТАТВАРЫН ОРЛОГО	612,781.0	655,956.4	655,956.4	676,656.1	103.2	103.2	20,699.7
1. Орлогын албан татвар	347,019.7	438,689.6	438,689.6	449,045.9	102.4	102.4	10,356.3
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3. Өмчийн татвар	21,929.9	35,581.3	35,581.3	43,975.4	123.6	123.6	8,394.1
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	23,163.0	24,814.2	24,814.2	25,780.2	103.9	103.9	966.0
5. Гадаад худалдааны орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
6. Бусад татвар	220,668.4	156,871.3	156,871.3	157,854.6	100.6	100.6	983.3
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,792.3	77,296.4	77,296.4	95,804.4	123.9	123.9	18,508.0
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	10,426.4	2,127.6	2,127.6	3,393.7	159.5	159.5	1,266.1
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	151,754.7	1,154,628.6	1,154,628.6	1,125,813.8	97.5	97.5	-28,814.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	747,181.2	2,056,048.7	2,056,048.7	1,794,118.8	87.3	87.3	-261,929.9
УРСГАЛ ЗАРДАЛ	501,161.1	1,478,115.6	1,478,115.6	1,386,445.3	93.8	93.8	-91,670.3
1. Бараа, үйлчилгээний зардал	253,650.4	1,180,466.4	1,180,466.4	1,107,551.2	93.8	93.8	-72,915.2
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	773.3	773.3	771.7	99.8	99.8	-1.6
3. Татаас ба шилжүүлэг	247,510.7	296,875.8	296,875.8	278,122.4	93.7	93.7	-18,753.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	246,020.1	577,933.1	577,933.1	407,673.5	70.5	70.5	-170,259.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН УРСГАЛ ТЭНЦЭЛ	199,412.1	-744,862.8	-744,862.8	-613,984.8	82.4	82.4	130,878.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	115,573.1	-166,039.7	-166,039.7	107,549.2	-64.8	-64.8	273,588.9
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-115,573.1	166,039.7	166,039.7	-107,549.2	-64.8	-64.8	-273,588.9
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-115,573.1	166,039.7	166,039.7	-107,549.2	-64.8	-64.8	-273,588.9

6.1. Орон нутгийн төсвийн орлогын биелэлт

Орон нутгийн урсгал орлого 39,207.7 сая төгрөгөөр давж биелэсэний 20,669.7 сая төгрөг нь татварын, 18,508.0 сая төгрөг нь татварын бус орлого байна. Тухайлбал:

- Нийслэл хувь хүний орлогын албан татварын орлого 7.9 тэрбум, бусад татварын орлого 2.4 тэрбум, өмчийн татварын орлого 1.6 тэрбум, татварын бус орлого 10.9 тэрбум төгрөгөөр тус тус давж, нийт дүнгээр 7.9 тэрбум төгрөгөр
- Өмнөговь аймгийн хувь хүний орлогын албан татварын орлого 0.3 тэрбум, бусад татварын орлого 2.2 тэрбум, өмчийн татварын орлого 5.5 тэрбум, татварын бус орлого 0.1 тэрбум төгрөгөөр тус тус давж, аймгийн дүнгээр 6.3 тэрбум

Тусламжийн орлого 28,814.9 сая төгрөгөөр тасарсаны 22,148.4 сая төгрөгө нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэгийн орлогын эх үүсвэрийг улсын төсвөөс орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан дутуу олгосонтой холбоотой байна. Үүний улмаас урсгал орлого 39,207.7 сая төгрөгөөр давж биелэсэн боловч нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн орлогын биелэлт 11,659.0 сая төгрөг болон буурсан байна.

6.2. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Нийт зарлага 1,794.1 тэрбум төгрөгт хүрч, 87.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 261.9 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй тайлагнадсан ба өмнөх онтой харьцуулбал нийт зарлага 1,047.0 сая төгрөгөөс нэмэгдсэн байна. Энэ нь төсвийн тухай хууль 2013 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулсан тус хуулийн 61-д заасан тусгай зориулалтын шилжүүлэг болон 60-д заасан орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн зарцуулалттай холбоотой.

Тухайлбал нийслэл 169.8 тэрбум төгрөгийн, Орхон аймаг 23.7 тэрбум, Өмнөговь аймаг 16.4 тэрбум төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.

7. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

7.1. Засгийн газрын гадаад өрийн тухай

Гадаад зээлийн үлдэгдэл

Монгол Улсын Засгийн газар Хандивлагч орон, Олон улсын санхүүгийн байгууллагаас 2013 онд 321.1 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашигласан ба гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 130.3 тэрбум төгрөг /үүнээс 98.4 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт, 31.9 тэрбум төгрөгийг хүүний төлбөрт/, харин Чингис бондын хүүгийн төлбөрт 98.9 тэрбум төгрөгийг төлж Засгийн газын гадаад зээлийн үлдэгдэл 2013 оны жилийн эцсийн байдлаар 3,613.2 тэрбум төгрөг, гадаад бондын үлдэгдэл 2,481.1 тэрбум төгрөг, нийт гадаад өрийн үлдэгдэл 6,092.0 тэрбум төгрөг болж нэрлэсэн дүнгээрээ ДНБ-ний 34.7 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 47. Гадаад зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг

Гадаад зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь
Хөтөлбөрийн зээл	42.27	0.00	0.00	8.08	50.35	1.4
Төслийн зээл	2,114.72	295.04	65.40	292.59	2,636.95	73.0
Автозамын зээл	438.29	19.07	16.07	90.19	531.47	14.7
Санхүүгийн зээл	336.75	4.14	11.76	63.52	392.66	10.9
ОУВС зээл	3.49	0.00	3.75	0.26	0.00	0.0
Хугацаа хэтэрсэн өрийн шийдвэрлэлт	0.00	2.85	1.40	0.28	1.73	0.0
Нийт гадаад зээл	2,935.53	321.10	98.38	454.92	3,613.16	59.3
Чингис бонд	2,088.15	-	-	393.00	2,481.15	40.7
Нийт гадаад өр	**5,023.68**	**321.10**	**98.38**	**847.63**	**6,094.31**	**100.0**

Нийт гадаад зээлийн үлдэгдлийн 1.4 хувийг хөтөлбөрийн зээл, 73.0 хувийг төслийн зээл, 14.7 хувийг автозамын зээл, 10.9 хувийг санхүүгийн зээл эзэлж байна.

2013 онд хуучин системийн үед үүссэн Бүгд Найрамдах Болгар Улсад төлөх 2.0 сая ам.долларын өрийг шийдвэрлэж 1.0 сая ам.доллар буюу 1.4 тэрбум төгрөгийн

төлбөрийг төлсөн бөгөөд үлдсэн төлбөрийг 2014 оны 3 дугаар сард төлөх хуваарьтай байна.

Гадаад зээлийн үлдэгдэлд үйл ажиллагаа, бүртгэлээс хамааран тооцооллын зөрүү үүсэх эрсдэлээс сэргийлэх зорилгоор 2013 оны жилийн эцсийн байдлаар Хандивлагч орон, Олон улсын санхүүгийн байгууллагын манай улсад олгосон зээлийн үлдэгдлийн үндсэн валютаар илэрхийлэгдэх дүнтэй тулган, тайлант онд зээлийн үлдэгдлийг тооцоолоход бүртгэлийн үйл ажиллагаанаас шалтгаалсан ямар нэг зөрүү үүсээгүй болохыг баталгаажуулж, баримтжуулсан болно.

Гадаад өрийн тогтвортой байдлын талаар

Засгийн газрын гадаад өрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх дарамтын шинжилгээг ОУВС/Дэлхийн банкны аргачлалын дагуу хийдэг бөгөөд манай улсын хувьд энэхүү үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 48. Гадаад өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт

Үзүүлэлт	2013	Сэрэмжлэх түвшин	Тайлбар
Гадаад Өр/ДНБ	34.7	40.0	Тогтвортой
Гадаад Өр/Экспорт	77.0	150.0	Тогтвортой
Гадаад Өр/ЗГ-ын орлого	103.6	250.0	Тогтвортой
Өрийн үйлчилгээ/Экспорт	2.9	20.0	Тогтвортой
Өрийн үйлчилгээ/ЗГ-ын орлого	3.9	30.0	Тогтвортой

ДНБ-д эзлэх Засгийн газрын гадаад өрийн хэмжээ 2013 онд 34.7 хувь байгаа нь ОУВС, Дэлхийн банкнаас тогтоосон гадаад өрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх дарамтыг шинжлэх шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд “гадаад өрийн эрсдэл дунджаас дээгүүр” гэсэн ангилалд багтаж байна.

7.2. Гадаад өрийн ашиглалт эргэн төлөлтийн талаар

Гадаад зээлийн эргэн төлөлт

2013 оны санхүүгийн жилд Монгол Улсын Засгийн газар гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт нийт 131.4 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 130.3 тэрбум төгрөгийг төлж, гүйцэтгэл 99.2 хувьтай гарч байна. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг бүтцийн хувьд авч үзвэл үндсэн төлбөрт 98.4 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөснөөс 98.4 тэрбум төгрөгийн төлж, гүйцэтгэл 100 хувь, хүүгийн төлбөрт 33.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 31.9 тэрбум төгрөгийг төлж, гүйцэтгэл 96.7 хувьтай тус тус гарсан байна.

Хүснэгт 49. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, сая төгрөг

Байгууллагаар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Үндсэн төлбөр	98,401.95	98,384.19
АХБ	30,415.34	30,544.92
Дэлхийн банк	11,396.97	11,426.06
Финлянд	891.36	891.36
Хятад	4,359.10	4,445.50

Испани	1,281.81	1,984.48
Болгар	1,400.46	1,400.46
АБУ-ДАБИ сан	1,100.29	1,136.30
Япон	25,562.32	25,883.15
Кувейт	6,822.23	5,662.99
Польш	297.38	297.38
Солонгос Улс	3,999.01	4,098.71
ХААХОУС	1,466.08	1,024.49
ОУ-ын валютын сан	3,718.68	3,752.97
Нордикийн хөгжлийн сан	1,100.39	1,150.27
Герман Улс	4,590.54	4,685.17
Хүүгийн төлбөр	33,008.86	31,930.11
АХБ	10,101.79	9,393.97
Франц	180.98	189.45
Дэлхийн банк	5,306.61	5,275.26
Финлянд	34.65	34.65
Хятад	4,669.58	4,669.58
Испани	148.98	221.69
АБУ-ДАБИ сан	370.81	382.70
Япон	7,314.41	7,322.99
Кувейт	1,895.54	1,490.18
Солонгос Улс	910.78	960.41
ХААХОУС	357.49	238.63
ОУ-ын валютын сан	10.10	
Швед	36.10	36.10
Нордикийн хөгжлийн сан	380.97	392.82
Герман Улс	1,290.07	1,321.69
Нийт дүн	**131,410.81**	**130,314.31**

Гадаад бондын эргэн төлөлт

Монгол Улсын Засгийн газраас Олон Улсын санхүүгийн зах зээлд гаргасан “Чингис бондын” хүүгийн төлбөрт 2013 оны санхүүгийн жилд 100.0 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөснөөс 98.9 тэрбум төгрөгийг төлж 99.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 50. Чингис бондын хүүний төлбөр, сая төгрөг

Дугаар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Чингис бонд /1.0 тэрбум/	82,500.00	81,525.68
Чингис бонд /500.0 сая/	17,500.00	17,458.76
Нийт дүн	**100,000.00**	**98,984.44**

Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний төлбөр нь тухайн зээл олгогдсон үндсэн валютаар эргэн төлөгддөг тул эргэн төлөлтийн гүйцэтгэлд гадаад валютын ханшийн хэлбэлзэл хамгийн их нөлөөллийг үзүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдэх төлбөрийн дүнг 2013 оны Улсын тодотгосон төсөвт тусгахад ам.долларыг ханшийн Эдийн засгийн хөгжлийн яамны төсөөлсөн ханш болох 1465.0 төгрөгөөр тооцоолон тусгасан болно. Харин бусад валютын ханшийн

таамаглалыг албан байдлаар тооцоолсон тооцоолол ирээгүй тул тухай үеийн Монгол банкнаас зарласан ханш болох зээлжих тусгай эрхийг 2454.98 төгрөг, еврог 2140.96 төгрөг, Японы иенийг 16.45 төгрөг, Солонгос воныг 1.45 төгрөг, Кувейт динарыг 5660.27 төгрөг, АНЭУлсын дирхамыг 439.55 төгрөгийн ханшийг ашиглан тооцсон болно.

Өнгөрөгч 2013 онд гадаад зээлийн ашиглалтын гадаад зээлийн ашиглалтын хэмжээ зарим нэг төслийг эс тооцвол төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй зэрэг нь төлөвлөсөн ашиглалтаас шууд хамааруулан тооцсон зээлийн хүүгийн төлбөрийн гүйцэтгэлийг 96.7 хувийн биелэлттэй гарахад нөлөөлсөн байна. **Тухайлбал:** Эрүүл мэндийн сайдын багцад тусгагдсан 21.5 тэрбум төгрөг гадаад зэлийн ашиглалт огт гараагүй, боловсролын салбарт зарцуулахаар төлөвлөсөн 38.5 тэрбум төгрөгийн ашиглалт 2.3 хувийн биелэлттэй гарсан гэх мэт гадаад зээлийн ашиглалтын дүн зарим нэг төслүүдийг эс тооцвол маш муу гарсан юм.

7.3. Гадаад зээлийн ашиглалт

Монгол Улсын Засгийн газар Хандивлагч орон, Олон улсын санхүүгийн байгууллагаас 2013 онд 317.9 тэрбум төгрөгийн гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөснөөс 101.0 хувийн гүйцэтгэлтэй 321.1 тэрбум төгрөгийн гадаад зээлийн ашиглалт гарсан. Тайланд онд “Улаанбаатар хотын олон улсын нисэх улсын шинэ онгоцны буудал барих төсөл”-ийн хүрээнд ашиглалтын гүйцэтгэл 242.1 хувьтай гарсан нь зээлийн ашиглалтын гүйцэтгэлийн хувийн жинд мэдэгдэхүйц нөлөөллийг үзүүлж байна юм. Үүнийг эс тооцвол бусад сайдын багцад тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл тайлан онд хангалттай хэмжээнд гарсангүй. Ялангуяа эрүүл мэндийн сайд, Боловсролын сайд, Барилга хот байгуулалтын сайдын багцад тусгагдсан зээлийн ашиглалт маш муу байна.

Хүснэгт 51. Гадаад зээлийн ашиглалт, ашиглалт

ТЕЗ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Хувийн жин
Монгол Улсын Ерөнхий сайд	5,184.36	1,978.47	38.2%	1.6%
Улсын Их Хурал	378.67	623.27	164.6%	0.1%
Сангийн сайд	46,614.19	29,420.73	63.1%	14.7%
Барилга хот байгуулалтын сайд	60,565.18	8,463.19	14.0%	19.1%
Боловсрол шинжлэх ухааны сайд	38,488.90	869.27	2.3%	12.1%
Зам тээврийн сайд	108,633.09	263,007.71	242.1%	34.2%
Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд	3,291.83	1,988.07	60.4%	1.0%
Хууль зүйн сайд	1,239.83	403.39	32.5%	0.4%
Эрүүл мэндийн сайд	21,453.48		0.0%	6.7%
Эрчим хүчний сайд	12,333.27	10,732.42	87.0%	3.9%
Орон нутгийн засаг захиргаа	19,728.79	3,622.44	18.4%	6.2%
Нийт дүн	**317,911.58**	**321,108.97**	**101.0%**	**100.0%**

Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын Ерөнхий сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 38.2 хувьтай гарсан байна.

Хүснэгт 52. Ерөнхий сайдын багцын гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Монгол Улсын Ерөнхий сайд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний шинэчлэл төсөл	5,184.36	1,978.47	38.2%
Дүн	**5,184.36**	**1,978.47**	**38.2%**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

20093597 - Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний шинэчлэл төсөл - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу тус төсөл нь тодорхой хугацаагаар зогссон тул үүнтэй холбогдуулан зарим ажлын гүйцэтгэл хойшлогдсон

Улсын Их Хурал

Улсын Их Хурлын тамгын газрын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 164.6 хувьтай гарсан байна.

Хүснэгт 53. УИХ-ын тамгын газрын гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Улсын Их Хурал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
4607MOG - Үндэсний статистикийн системийг сайжруулах төсөл	378.67	623.27	164.6%
Нийт дүн	**378.67**	**623.27**	**164.6%**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

4607MOG - Үндэсний статистикийн системийг сайжруулах төсөл – Дэлхийн банкнаас санхүүжүүлж буй МОНСТАТ төсөл нь 2013 оны 12-р сарын 31-ний байдлаар Олон улсын хөгжлийн ассоциацын зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс 623,273.60 мянган төгрөгийн санхүүжилт авч бусад орлогоор 1477,48 мянган төгрөгийн орлого олсон. Дээрх санхүүжилтээс 45,4 сая төгрөгийг 2012 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн гэрээт ажлуудын он дамжсан төлбөрийн үлдэгдэлд, 78,3 сая төгрөгийг ХБНГУ-ын Статистикийн газар Дестатис, БНСУ-ын Статистикийн газар Костатын хамтарсан Консорциум хосолмол түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлж буй зөвлөх үйлчилгээний 2012 оны төлбөрт, үлдсэн санхүүжилтийг Дэлхийн банкнаас баталсан 2013 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажлуудын төлбөрт зарцуулсан болно. ҮСХ-ны хэрэгжүүлж буй МОНСТАТ төсөл нь томоохон хэмжээний тооллого, судалгааны ажил, олон улсын болон дотоодын зөвлөх үйлчилгээнүүдийг санхүүжүүлдэг тул Сангийн яаманд өгч буй мэдээний Эрдэм, шинжилгээ, судалгааны ажлын хөлс мөрөнд эдгээр зардлыг тавьсан.

Төслийн ашиглалтын мэдээний төсвийг урд оны 7-8 сард хүлээж авдаг, Дэлхийн банк он, оны төсвийг тухайн оны эхний 2-3 саруудад батлан хэрэгжүүлдэг, мөн тухайн онд хэрэгжүүлж амжаагүй эсвэл урд оны батлагдсан төсвийн дагуу хийгдэж буй ажлуудын төлбөр он дамжин хийгддэг, валютын ханш нэмэгдсэн зэрэг шалтгаанаас төрийн санд сар болгон өгдөг төслийн ашиглалтын гүйцэтгэлийн дүн нь өмнөх оны 7-8 сард Сангийн яаманд өгсөн төсвийн төслөөс хэтрэх магадлал өндөр байдаг.

Сангийн сайд

Сангийн сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 63.1 хувьтай гарсан байна.

Хүснэгт 54. Сангийн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Сангийн сайд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
3803MOG - Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл	502.97	-5.54	-1.1%
4330MOG - Тогтвортой амьжиргаа төсөл - 2	1,086.36	-61.92	-5.7%
4489MOG - Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл	2,582.26	789.34	30.6%
4069MOG - Малын индексжүүлсэн даатгалын төсөл		29.07	
4687MOG - Малын индекжүүлсэн даатгал төслийн нэмэлт	5,229.40	2,106.18	40.3%
4777MOG - Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл	4,676.80	3,349.35	71.6%
4888MOG - Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	3,904.75	1,298.50	33.3%
4953MOG - Тогтвортой амьжиргаа төсөл - 2 нэмэлт		1,043.41	
H222 - Засаглалыг дэмжих төсөл	2,515.38		0.0%
india01 - Эдийн засгийг тогтворжуулах зээл		346.98	
MON-P9 - Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн нэгж	26,116.26	17,675.34	67.7%
Хугацаа хэтэрсэн өрийн шийдвэрлэлт		2,850.01	
Дүн	**46,614.19**	**29,420.73**	**63.1%**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

3803MOG - Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл – Уг төсөл нь тайланд онд үйл ажиллагаа нь дууссан бөгөөд зээлийн ашиглагдаагүй дүнг буцааснаас ашиглалтын гүйцэтгэл хасахтай гарсан байна.

4330MOG - Тогтвортой амьжиргаа төсөл – 2 – Уг төсөл нь тайланд онд үйл ажиллагаа нь дууссан бөгөөд зээлийн ашиглагдаагүй дүнг буцааснаас ашиглалтын гүйцэтгэл хасахтай гарсан байна.

4489MOG - Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл – 2013 онд хөрөнгийн зарцуулалт төлөвлсөнөөс бага байсан нь нэг талаар төслийн хэрэгжилтийн хугацааг сунгах эсэх нь тодорхой бус байснаас үүдэн төслийн үлдэгдэл бүхий л хөрөнгийг 2013 онд зарцуулахаар төлөвлөгөөнд тусган оруулсантай холбоотой. Нөгөө талаар 2009-2013 оны төслийн хөрөнгийн зарцуулалт төлөвлөж байснаас бага байсан УУЯ дээр зохион байгуулагдах хэд хэдэн ажлын тендерт маргаан үүсэж, ажил удааширсантай холбоотой.

4069MOG - Малын индексжүүлсэн даатгалын төсөл болон 4687MOG - Малын индекёжүүлсэн даатгал төслийн нэмэлт – Төсөл нь 2013 онд 5,229,400.00 мян төгрөгийг үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж төсвийн хуваарьт орон баталгаажиж төсвийн дагуу үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэлээр 2,281,252.62 мянган төгрөгийн зарцуулалттай тайлант жилийн үйл ажиллагааг зохион байгуулан тайлагналаа. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлээс харахад 2,948,147.38 мян төгрөгийн төсвийн хэмнэлттэй байдлаар гүйцэтгэл хийгдсэн байна.

Төслийн төлөвлөлтийн явц нь жил бүр Байгалийн давагдашгүй зуд болох магадлалтай гэсэн байдлаар нөхцөлт зээлийн санхүүжилтийг төлөвлөхдөө тухайн жилд 2,500,000.00 мянган төгрөгийг төлөвлөсөн бөгөөд 2013 онд нөхөн төлбөрт зээлийн санхүүжилтээс Дорнод аймгийн Халх гол суманд малын хорогдлын нөхөн төлбөрийн хэмжээ 30%-иас хэтэрч зээлийн санхүүжилтээс нөхөн төлбөр олгохоор болсон бөгөөд 25,771.20 мянган төгрөгийг төлбөр гарч төлөвлсөнөөс даруй 2,474,228.70 мянган төгрөгийн хэмнэлттэй гарсан. Төслийн үйл ажиллагааны хүрээнд сургалтын зардал, хэвлэлийн зардлууд хэмнэлттэй гарсан. Хэвлэлийн зардлын хувьд төслийн зүйгээс цөөхөн тоогоор хэвлүүлэхэд үнэ өндөр гарч байгаатай холбогдуулан хэвлэлийн зардлын хэмнэх зорилгоор нийт хэвлэлийн ажлуудыг нийтэд нь хэвлүүлэх болсноор зардал хэмнэгдсэн.

4777MOG - Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл – 2012 онд Сангийн яаманд 2013 оны төсвийг хүргүүлж 4676,8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч 2013 оны 3 сарын 1 нд төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орж С3-Санхүүгийн зохицуулах хорооны чадавхийг сайжруулах, Е-Худалдан авах ажиллагааны газрын чадавхийг бэхжүүлэх, ил тод байдлыг сайжруулах, F-Тэтгэврийн шинэчлэлийн бодлогын хувилбаруудыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь (ХАХНХЯам) бүрэлдэхүүн хэсгүүдийн төсөв нэмэгдсэн. Энэ нь төлөвлөгөөт ажил зарим үзүүлэлтээр давж биелсэн мөн төгрөгийн ханш унасантай холбоотой байна. Сангийн яамны хүсэлтээр Төслийн санхүүжилтийн гэрээнд өөрчлөлт орсон болно.

4888MOG - Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл – 2013 онд хөрөнгийн зарцуулалт төлөвлсөнөөс бага байсан нь нэг талаар төслийн хэрэгжилтийн хугацааг сунгах эсэх нь тодорхой бус байснаас үүдэн төслийн үлдэгдэл бүхий л хөрөнгийг 2013 онд зарцуулахаар төлөвлөгөөнд тусган оруулсантай холбоотой. Нөгөө талаар 2009-2013 оны төслийн хөрөнгийн зарцуулалт төлөвлөж байснаас бага байсан УУЯ дээр зохион байгуулагдах хэд хэдэн ажлын тендерт маргаан үүсч, ажил удааширсантай холбоотой.

4953MOG - Тогтвортой амьжиргаа төсөл - 2 нэмэлт – Энэ төсөл нь 4330MOG дугаартай төслийн нэмэлт төсөл бөгөөд мөн тайлант онд төслийн үйл ажиллагаа эцэслэсэн байна.

india01 - Эдийн засгийг тогтворжуулах зээл – 2009 онд Энэтхэг улсаас авсан тус зээлийн гэрээний нөхцөлийн дагуу 2013 онд ногдох хүүгийн төлбөрийг ашиглалт хэлбэрээр зээлийн үндсэн дүн дээр нэмж бүртгэлээ. Зээлийн гэрээнд 2019 он хүртэлх хугацаанд жил бүрийн хүүгийн төлбөр болох 250.0 мянган ам.доллартай тэнцэх хэмжээний төлбөрийн зээлийн үндсэн дүн дээр ашиглалт хэлбэрээр нэмж бүртгэх нөхцөлтэй болно.

MON-P9 - Жижиг, дунд үйлдвэрийг хөгжїїлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн нэгж – Төслийн 2-р шат 2011 оны 6-р сараас эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд дараах арилжааны банкуудаар буюу Капитал банк, Голомт банк, Хаан банк, Хас банк, Худалдаа, хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкаар дамжуулан зээл олгогдож байна. 2013 оны хэмжээнд иений эх үүсвэрээс нийт 47 төслийн зээлийг санхүүжүүлсэн бөгөөд үүнээс ЖДҮ-ийг хөгжүүлэх зээлд 33 төслийн 10.3 орчим тэрбум төгрөг, Байгаль орчныг хамгаалах зээлд 14 төслийн 3.5 орчим тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Төслийн өдөр тутмын үйл ажиллагаагаар төсөлд оролцогч арилжааны банкуудын харилцагчид болон бусад бизнес эрхлэгчдэд төслийн зээлийн талаарх нээлттэй мэдээлэл өгөх уулзалт, сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд тайлант хугацаанд нийт 16 удаагийн төслийн танилцуулах өдөрлөгөөр 570 гаруй хүн хамрагдсан байна. Банк санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах сургалтын хүрээнд тайлант онд Төрийн банкинд сургалт зохион байгуулсан байна.

Үүний дээр улирал бүр санхүүжигдсэн төслүүдийн хэрэгжилтэд эргэн хяналт хийж, холбогдох хүмүүстэй холбогдон явцын тайланг тогтмол авдаг бөгөөд 2013 оны хугацаанд Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт, Төв аймгуудад хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааг хэрэгжиж буй газарт очиж хяналт хийсэн байна.

Түүнчлэн 2013 оны 11-р сарын 20-нд Японы элчин сайдын Яамтай хамтран уг төслийн хэрэгжилт, үр дүнг таниулах зорилгоор төсөлд хамрагдсан нийт аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний дээжис бүхий үзэсгэлэнг амжилттай зохион байгуулсан.

Үүнээс үзэхэд төслийн үр дүн, хэрэгжилт амжилттай байгаа тул японы талаас энэхүү загвар төслийг үргэлжлүүлэх сонирхолтой байгаа бөгөөд төслийн 3-р шатыг эхлүүлэх боломжийг судлах зорилгоор судалгааны баг Монголд ирээд ажиллаж байна.

Хугацаа хэтэрсэн өрийн шийдвэрэлт – Тайлант онд хуучин системийн үед үүссэн Бүгд Найрамдах Болгар Улсын өрийн асуудлыг 2 талын хамтын хэлэлцээрийн үр дүнд шийдвэрлэн, тус онд төлбөрийн эхний хагас болох 1.0 сая ам.доллартай тэнцэх төлбөрийг шилжүүлсэн. Өрийн үлдсэн төлбөрийг хуваарийн дагуу 2014 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн дотор төлөхөөр хүлээгдэж байна.

Барилга хот байгуулалтын сайд

Барилга хот байгуулалтын сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 14.0 хувьтай гарсан байна.

Хүснэгт 55. БХБЯ-ны гадаад зээлийн ашиглал, сая төгрөг

Барилга хот байгуулалтын сайд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
201015122-Төмөр Замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх	13,376.87	141.55	1.1
201123174-Орон сууцны хороолол барих төсөл	37,772.95		0.0
2301-MON(SF)-Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	9,415.36	8,321.64	88.4
Дүн	**60,565.18**	**8,463.19**	**14.0**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

- 201015122 - Төмөр Замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл – Гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмжүүд 2013 оны жилийн эцсийн байдлаар бүгд нийлүүлэгдсэн. Одоо зөвхөн 5% гүйцэтгэлийн баталгааны төлбөр үлдсэн болно.
- 201123174 - Орон сууцны хороолол барих төсөл – Тус төслийн хувьд газар чөлөөлөлтийн ажил удаашралтай байгаа болон гүйцэтгэлийн аудитын ажлууд хийгдсэн зэрэг шалтгаанаар төслийн ажил төлөвлөгөөнөөс хоцролттой явагдаж байгаагаас шалтгаалан тайлант онд төлөвлөсөн ашиглалт гарах боломжгүй болсон байна.
- 2301-MON(SF) - Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл – Төслийн хүрээнд 2013 онд нийт 9,415,359,500.0 төгрөгийн гадаад зээлийг ашиглахаар төлөвлөснөөс 8,321,639,552.35 төгрөгийг ашиглаж дараах ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:
  - Эрдэнэт хотын гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургыг сайжруулах барилгын ажил /Санхүүжилт 729,916.02 сая төгрөг/: ЗТБХБЯ гүйцэтгэгч “Одкон холдинг” компанитай 2010 онд байгуулсан гэрээний дагуу дараах ажлыг хийсэн. Үүнд: ундны усны эх үүсвэрийн гүний худаг 4 ш шинээр гаргах, худгийн барилга, хамгаалалтын хашаа барих, насос, дагалдах тоног төхөөрөмж, удирдлага, хяналтын самбар суурилуулах, хлоржуулах тоног төхөөрөмж суурилуулах; цэвэр ус дамжуулах 35 км шугам угсрах; 2-р өргөлтийн насос станц шинээр барих; 2х1000 м3 багтаамжтай усан сан болон 1х100 м3 багтаамжтай усан сан шинээр барих, шинээр ус түгээх байр 26-г барих, одоо ашиглаж байгаа 24-н ус түгээх байрыг засварлаж, цэвэр усны шугаманд холбох/ цэцэрлэг, сургууль, эмнэлэг холбох/; 4.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам татах, дэд өртөө угсрах/-д техникийн болон чанарын үзлэг шалгалт хийж дотоодын хяналтын дүгнэлт гаргах ажлын хэсэг 2013 оны 12 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд ажилласан. Гэрээний хугацаа 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр дуусна, нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 95 хувь.
  - Алтай хотын ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг сайжруулах ажил /Санхүүжилт 85,423.01 сая төгрөг/: ЗТБХБЯ барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Хүрд” ХК-тай 2011 онд байгуулсан гэрээний хүрээнд Алтай хотод ундны усны эх үүсвэрийн гүний худгийн 3 барилгыг засварлаж, насос, тоног төхөөрөмжийг шинэчлэх, 3.3 км-т эх үүсвэрийн гүний

худаг шинээр гаргах, цэвэр ус дамжуулах 3.3км шугам /Олон нуурын бүс/ угсрах, насос тоног төхөөрөмж суурилуулах, 1.56км-т шинээр гаргасан эх үүсвэрийн гүний худгийг холбох, цэвэр ус дамжуулах 1.56км шугам /Харзат/ угсрах, гүний худгуудын цахилгаан дамжуулах агаарын 4.8км шугам шинээр татах, дэд өртөө угсрах, ус зөөлрүүлэх тоног төхөөрөмжийг шинэчлэх, хлоржуулах тоног төхөөрөмж шинээр суурилуулах, ус түгээх байр 7ш шинээр барьж цэвэр усны төвлөрсөн шугамд холбох, хотын дотор цэвэр ус дамжуулах 2.2км цагираг шугам шинээр угсрах, гэр хороололд цэвэр ус дамжуулах 2.8км шугам шинээр угсрах, орон сууцнуудын гадна бохир усны 0.57км, цэцэрлэгүүдийн 0.44км, МСҮТ 0.74км бохир ус дамжуулах шугамын угсралт, цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажил, сараалжийн барилга барих, цэвэрлэх байгууламжийн 6ква-ын ЦДАШ, 25кВа чадалтай иж бүрэн агаарын дэд өртөө, өргөлтийн насос станцын насос тоног төхөөрөмжийг шинэчилж, халаалтын зуухыг засварлах, харуулын байр шинээр барих, ирээдүйн барилгажуулалтад зориулан гэр хорооллын цэвэр ус дамжуулах 816м шугамын угсралт, 75 хүүхдийн 4-р цэцэрлэгийн 84м цэвэр усны шугамын угсралтын ажлууд хийгдсэн. Гэрээний хугацаа 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр дуусна. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувь.

- Баянхонгор хотын ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг сайжруулах ажил. /Санхүүжилт 670,123.18 сая төгрөг/: ЗТБХБЯ гүйцэтгэгч “ЧММ” ХХК-тай 2012 онд байгуулсан гэрээний хүрээнд ундны усны эх үүсвэрийн гүний 2ш барилга засварлах, 1ш барилга шинээр барих, эх үүсвэрийн цэвэр усны 440м шугам угсрах, 1000м3 багтаамжтай 2ш усан сан шинээр барих, гэр хорооллын цэвэр усны 10км шугам угсрах, ариутгах татуургын 2.3км шугам шинэчлэх, ус түгээх 5ш байр шинээр барих, 9ш байр засварлах, хлораторын барилга, цахилгаан дамжуулах агаарын шугам 1.6км татах, дэд өртөө угсрах, цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлууд хийгдсэн. 2013 оны 7 дугаар сарын 30-нд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. Гэрээний дуусах хугацаа 2013 оны 7 дугаар сарын 30-ны өдөр. Ажлын гүйцэтгэл 100 хувь.
- Арвайхээр хотын ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг сайжруулах ажил. /Санхүүжилт 3,670,738.47 сая төгрөг/. БХБЯ барилгын угсралтын ажлын гүйцэтгэгч “Одконхолдинг” ХХК-тай 2012 онд байгуулсан гэрээний хүрээнд:
  - Ундны усны эх үүсвэрийн ажил: Гүний худгийн 1-р цооног 53м, 2-р цооног 56м, 3-р цооног 55м гүнтэй өрөмдлөгийн ажил болон цооногийн шүүрийн яндан, хайрган шүүр хийх ажил дууссан. Шавхалт, ундарга тогтоох ажил хийгдсэн. 3-р худагт ундрага хангалттай гараагүй. Гүний 3-н худгийн барилгын ажил хийгдэж, худгуудын монтаж, дотоод гэрэлтүүлэг, цахилгаан, хамгаалалтын хашааны ажлууд хийгдсэн. 1, 2-р цооногт насос суурилуулах ажил хийгдсэн. Цооног шавхалтын ажил 2013 оны 9 дүгээр сарын 18-наас эхлэн ЭЦВ-6 маркийн насосаар шавхалт хийсэн /суурилах насос Grundfos SR 60-16/ 69m3/ц бүтээлтэй, Н-100м/ нь суурилах насоснаас 1.5 дахин их хүчин чадалтай насосаар шавхалт хийх нормыг зөрчсөн тул насосаар

тогтоосон ундрага, статик, динамик түвшинг зөвшөөрөх боломжгүй гэж ТХН мэдэгдсэн. Шороон овоолго далан хийгдсэн.

- Цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил: Цэвэр ус дамжуулах 19.8км /№1/ гол шугамын угсралт болон 10.2км цэвэр ус дамжуулах гол шугам /№2/-ын угсралт дууссан. Хот доторхи цагираг шугам 11.5км хийхээс 8.5км шугам хийгдсэн. 3км хадан хөрс илэрч нэмэлт зардлаар ажил хийгдэж дууссан.
- Хот доторхи цагираг шугам: Баруун талын цагираг шугам 283м газарт 2013 оны 10 дугаар сарын 22-нд тэсэлгээ хийсэн. Тэсэлгээ хийсэн газарт үр дүн багатай 10 дугаар сарын 22-30-ыг хүртэл ухалт хийсэн 15м газар дутуу, өдөрт 3м газар ухалт хийсэн. Зүүн хэсгийн цагираг шугамын ажил 169м газарт тэсэлгээ хийсэн. Тэсэлгээ хийсэн газрын шугамын ухалт угсралтын ажил дууссан. 3.2-р өргөлтийн насосны станцын барилгын ажил: 2-р өргөлтийн насос станцын барилгын угсралтын ажил дууссан. Хаалга, цонх суурилуулсан, цахилгаан угсралтын ажил хийгдсэн, дотор халаалт, бохир ус зайлуулах шугам угсралтын ажил хийгдэж, насос, дагалдах тоног төхөөрөмж, хлоржуулах тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдсэн. Гадна хашааны ажил дууссан.
- Цахилгаан дамжуулах агаарын шугам татах, дэд өртөө угсрах ажил: Цахилгаан дамжуулах агаарын 1.7км шугам татах, дэд өртөө угсрах ажил хийгдэж дууссан.
- Усан сангийн ажил: 1000м3 усан сангийн цутгалтийн ажил бүрэн дууссан. Дүүргэлтээ хийж 3 газраар шүүрэлт өгсөнг дахин түрхэлт хийж тогтоож, шороогоор хучилт хийсэн. Одоо ашиглагдаж байгаа 1000м3-ын усан санг шинээр баригдсан 1000м3-ын усан сантай холбосон. Цэвэр усны насос станцтай холбогдох болон бусад холболтууд хийгдсэн. 100м 2ш усан сангийн барилгын ажил дууссан.
- Ус түгээх байрны ажил: Гэр хорооллолд баригдах 16ш ус түгээх байр болон эргэлтийн насостай 2ш ус түгээх байрны барилгын ажил дууссан. Дотор механик холболт, цахилгааны ажил хийгдэж шугаманд холбогдсон.
    - Булган хотын гэр хорооллын 1.3км цэвэр усны шугамын угсралтын ажил /Санхүүжилт 300,813.40 сая төгрөг/. БХБЯ гүйцэтгэгч “Селена” ХХК хооронд 2013 онд байгуулсан гэрээний хүрээнд 1.3км цэвэр усны шугамын барилга угсралтын ажил, ус түгээх байр хоёр ширхэгийг холбох ажлуудыг 2013 оны 7 дугаар сарын 30-нд хийж дууссан. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2013 оны 9 дүгээр 4-нд ажилласан. Ажлын гүйцэтгэл 100 хувь.
    - Баруун салааны 4,1км авто замын барилгын ажил /Санхүүжилт 7,620.33 сая төгрөг/. ЗТБХБЯ гүйцэтгэгч “Хотын зам” ХХК-тай 2010 онд байгуулсан гэрээний дагуу 2км авто замын асфальтобетон хучилт, тэмдэглэгээний хамт, 2.7км явган хүний замын асфальтбетон хучилт, 13ш автобусны зогсоол дээрхи сүүдрэвч суурилуулах, 16ш гэрэлтүүлгийн шонг тэжээлийн хамт суурилуулах, эцсийн зогсоолын ухмалын 251,5м2 талбайг эко хавтангаар бэхлэх болон замын далангийн 1800м2 налууг засаж тэгшлэх, Зорчих хэсгийн асфальт бетон хучилт, автобусны эцсийн

буудлын бетон ажлууд хийгдсэн. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2013 оны 12 дугаар сарын 5-нд ажилласан. Комиссын гишүүдээс өгсөн гэрэлтүүлгийг гүйцээж тавих, замын тэмдэгийг бүрэн байрлуулах, 1.4км явган хүний замын үлдэгдэл хучилтыг 2014 оны 5 сард дуусгана. Ажил гүйцэтгэх хугацаа 2014 оны 5 дугаар сарын 30. Нийт ажлын гүйцэтгэл 96.5 хувь.

- Орбит-Тахилтын 7,1км авто замын барилгын ажил /Санхүүжилт 1,888,179.55 сая төгрөг/. ЗТБХБЯ гүйцэтгэгч "Хурдны зам" ХХК-тай 2010 онд байгуулсан гэрээний дагуу 4км замын асфальтбетон хучилт,16ш автобусны буудлын сүүдрэвч суурилуулах, 7км замын тэмдэг, тэмдэглэгээ хийх, эцсийн буудлын налуугийн эко хавтан бэхэлгээ, өөрийн шуудуу хийх, замын гэрэлтүүлэг, зүлэгжүүлэлтийн ажлыг бүрэн хийж дууссан.Барилга байгууламжийг ашиглалтад өгөх комисс 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр ажилласан. Замыг НЗДТГ-т хүлээлгэн өгсөн. Ажил гүйцэтгэх хугацаа 2013 оны 7 дугаар сарын 30. Нийт ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн.

Боловсрол шинжлэх ухааны сайд

Барилга хот байгуулалтын сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 2.3 хувьтай гарсан байна.

Хүснэгт 56. БШУЯ-ны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Боловсрол шинжлэх ухааны сайд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
2766-MON(SF) - Дээд боловсролын шинэчлэлийн төсөл	7,783.73	521.50	6.7%
China - Шинэ зууны боловсрол төсөл	13,518.35		0.0%
india2 - Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв төсөл	17,186.82		0.0%
Poland - Оюутан солилцох хөтөлбөр		347.77	
Дүн	**38,488.90**	**869.27**	**2.3%**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

- 2766-MON(SF) - Дээд боловсролын шинэчлэлийн төсөл – Тайлант хугацаанд төслийн хүрээнд 7,783,734,800.0 төгрөгийн гадаад зээлийг ашиглахаар төлөвлөснөөс 521,504,980.69 төгрөгийг ашиглаад байна. Төслийн үйл ажиллагаа эрчимжиж 2013 онд дараах ажлуудыг хийгээд байна. Үүнд:
  - Худалдан авах ажиллагаа: Төслийн хүрээнд орон нутгийн 7 сургууль /Ховд Их сургууль, Дорнод Дээд сургууль, МУИС-ын Завхан сургууль, Эрдэнэт үйлдвэр ХХК-ний дэргэдэх ШУТИС-ын харъяа технологийн сургууль, ШУТИС-ын Дархан-Уул аймаг технологийн сургууль, МУИС-ын Орхон сургууль, ХААИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь ХАА-н сургуулиуд/-д 148,454,400 төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж, угсарч хүлээлгэн өгсөн.

- Зөвлөх үйлчилгээ: Төслийн хүрээнд ажиллах олон улсын зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлж зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулан зарлаад байна. Мөн дээд боловсролын хүний нөөцийн олон улсын зөвлөх Хийдер Де Бердт Ромиллитэй 41,825 ам.долларын, дээд боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн олон улсын зөвлөх Сузанна Караханянтай 90,125 ам.долларын, дээд боловсролын засаглалын дотоодын зөвлөхөөр Л.Мөнх-Эрдэнэтэй 33,000 ам долларын гэрээг тус тус байгуулсан бөгөөд санхүүгийн, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн, хууль, эрхзүйн дотоодын зөвлөхүүдтэй тус тус гэрээ байгуулаад байна.
- Дээд боловсролыг дэмжих сан: Төслийн хүрээнд дээд боловсролын санхүүжилтийн арга механизмыг өрсөлдөөнт тэтгэлэг, үр дүнд суурилсан үйл ажиллагаанд шилжүүлэхтэй холбогдуулан Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн, Дээд боловсролыг дэмжих сан болгож зохион байгуулах хуулийн санал боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч байна.
- Чадавх бэхжүүлэх: Төслийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд нийт 13 сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох яам, агентлаг, их, дээд сургуулийн нийт 600 орчим хүн оролцож мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. Сургалт семинарт нийт 162,5 сая төгрөгийг зарцуулаад байна.

- China - Шинэ зууны боловсрол төсөл – Төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулагдаагүйгээс төсөл хэрэгжиж эхлээгүй болно.
- india2 - Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв төсөл – Төслийн гэрээ байгуулагдаагүйгээс холбогдох санхүүжилт гарах боломжгүй болсон.
- Poland - Оюутан солилцох хөтөлбөр – Дутуу бүртгэгдсэн мэдээллийг нөхөн бүртгэсэн.

Зам тээврийн сайд

Зам тээврийн сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 242.1 хувьтай гарсан байна.

Хүснэгт 57. Зам тээврийн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Зам тээврийн сайд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
200465112 - Бүс нутгийн салбарын дэд бүтцийг сайжруулах төсөл		117.03	
200865162 - Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл	9,084.17	2,246.98	24.7%
201017124 - Замын Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл	15,841.29	29,370.82	185.4%
201026133 - Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл	19,843.58	20,856.44	105.1%
201124175 - Хөдөлгөх бүрэлдэхүүн хэсгийн сайжруулах төсөл		16,702.95	

2087-MON(SF) - Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх төсөл	9,143.47	8,776.65	96.0%
2621-MON(SF) - Бүс нутгийн авто замыг хєгжүүлэх төсөл-нэмэлт	201.29	1,774.70	881.7%
2847-MON(SF) - Баруун босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл	13,833.82	13,660.43	98.7%
797 - Уньт-Мөрөнгийн чиглэлд Уньт-Тариалангийн хооронд авто зам барих төсөл	9,482.71	867.80	9.2%
MON-P8 - Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл	31,202.75	168,633.91	540.4%
Дүн	**108,633.09**	**263,007.71**	**242.1%**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

- 200465112 - Бүс нутгийн салбарын дэд бүтцийг сайжруулах төсөл – Уг төсөл нь 2012 онд үйл ажиллагаа нь эцэслэгдсэн бөгөөд сүүлийн санхүүжилтийг 2013 онд авсан байна.
- 200865162 - Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл – Төслийн хүрээнд хүрээнд тайлант онд дараах 3 багц ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:
  - Багц-1: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгон (Партизаны САА) чиглэлийн 17км авто замын барилгын ажлын гүйцэтгэл 96.3%, замын барилгын ажлыг ашиглалтад хүлээн авч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн.
  - Багц-2: Төв аймгийн Партизан-Батсүмбэр чиглэлийн 29,36км авто замын барилгын ажлын Гүйцэтгэгчтэй 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр гэрээ байгуулсан.
  - Багц-3: Төв аймгийн Жаргалант сум чиглэлийн 24,75 км, Борнуур сум чиглэлийн 7,45 км авто замын шинэчлэлийн ажлын гүйцэтгэл 98%, замын барилгын ажил үндсэндээ дуусч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн.
- 201017124 - Замын Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл – Дулааны станц, ус цэвэршүүлэх үйлдвэр, бохир цэвэршүүлэх байгуулжийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын графикаас урьдчилан гүйцэтгэгдсэн.
- 201026133 - Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл – Ханшийн зөрүүгээс үүдэн зөрүү гарсан.
- 201124175 - Хөдөлгөх бүрэлдэхүүн хэсгийн сайжруулах төсөл – Энэ төсөл нь 201017124 дугаартай төслөөс тусдаа эх үүсвэрээс гарч байгаа ч төслийн хувь нэг үйл ажиллагаа явагддаг төсөл тул төсөвт нэгтгэсэн байдлаар төлөвлөгөөг тусгасан байна.
- 2087-MON(SF), 2621-MON(SF) - Бүс нутгийн авто замыг хєгжүүлэх төсөл – Төслийн хүрээнд 2013 онд дараах ажлыг хийсэн. Үүнд:
  - Төслийн гол зам: Чойр-Сайншанд чиглэлд 257.5 км хатуу хучилттай зам барих ажлын хүрээнд
    - Багц NP1: 18-ын худгаас 62.2 км хүрэх замын ажлыг хийх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ цуцлагдсан тул шинээр тендер зарлаж China Machienery Industry Construction Group-тэй гэрээ 2012 онд байгуулж, барилгын ажлыг

2013 оны 4 дүгээр сард барилгын ажлыг эхэлж 2013 оны 10 дугаар сард дуусган хөдөлгөөн нээгээд байна.

- Багц NP2: 61.79 км замын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалж, шинээр тендер зарлаж China Railway First Group-тэй гэрээг 2012 оны 11 дүгээр сард гэрээ байгуулж, 2013 онд барилгын ажлыг эхлүүлэн 2013 оны 11 дүгээр сард дуусгаж, хөдөлгөөнийг нээсэн.

- Туслах зам: Дорноговь аймгийн Өргөн, Эрдэнэ сумыг гол замтай холбох туслах зам /Багц AR1, AR2/ -ын хүрээнд
  - Багц AR2 буюу Өргөн сум хүртэлх 18.25 км авто замын гүйцэтгэгчтэй гэрээг цуцлагдаж шинээр сонгон шалгаруулахаар ажиллаж байна.
- Тоног төхөөрөмж: Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий тоног төхөөрөмж, машиныг 109,175.04 ам.долларын хөрөнгөөр худалдан авсан.

- 2847-MON(SF) - Баруун босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл – Уг хүрээнд “Шинэчилсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, олон улсын байгууллага Төв Азийн Бүсийн Эдийн Засгийн Хамтын ажиллагааны хөтөлбөр /CAREC/, Ази, Номхон Далайн Эдийн Засгийн комисс /ESCAP/-ийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, улмаар Монгол Улсын нутаг дэвсгэрээр олон улсын транзит тээврийг нэвтрүүлж, Ази, Дундад Азийн орнуудтай авто тээврийн сүлжээг өргөжүүлж улсын болон бүсийн нийгэм, эдийн засаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын баруун босоо тэнхлэгийн дагууд Ярант/БНХАУ-тай хил залгаа улсын хил/- Ховд-Өлгий-Улаанбайшинт /ОХУ-тай хил залгаа улсын хил/ чиглэлийн 743.1 км олон улсын чанартай авто замыг барьж дуусгана.

Төслийн хүрээнд Багц 2-Бага Улаан даваа-Манхан сум чиглэлийн 103,3км авто замыг барьж дуусгах бөгөөд 2013 онд замын барилгын ажлыг үргэлжлүүлж барилгын ажлын гүйцэтгэл 28,3%-тай байна.

- 797 - Уньт-Мөрөнгийн чиглэлд Уньт-Тариалангийн хооронд авто зам барих төсөл – Гүйцэтгэгчийн ажлын явц хоцрогдсоны улмаас 2013 оны 8 сарын 15 өдөр ЗТЯ-аас Захиалагч, Зөвлөх, Гүйцэтгэгч нар гурван талт уулзалт хийн, 2013 оны 8 сарын 16 өдөр Монгол Улсын Засгийн газрын хурлын шийдвэр дээр үндэслэн Уньт-Тариалан чиглэлийн 88км замыг 40км, 48км гэж хоёр багц болгон хувааж зам барилгын ажлыг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн.
- MON-P8 - Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл – Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын хөнгөлөлттэй зээл /MON-P8/-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл"-ийн Бүтээн байгуулаптын ажлын гэрээг 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Иргэний нисэхийн ерөнхий газар болон Мицүбиши/Чиёода хамтарсан түншлэлийн хооронд байгуулсан. Бүтээн байгуулалтын ажил 2013 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн амжилттай явагдаж байна.

Төслийн бүтээн байгуулалтын ажлын 2013 оны Гадаадын зээл, тусламжаар санхүүжигдэх хөрөнгө оруулалт болон урсгал зардлын төлөвлөгөөнд 34.2 тэрбум

төгрөг тусгагдсан. Үүнд: Хөрөнгө оруулалтад 27.7 тэрбум төгрөг, Урсгал зардалд 4.7 тэрбум төгрөг.

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн хүрээнд 2013 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар Гадаадын зээл, тусламжаар санхүүжигдэх хөрөнгө оруулалт болон урсгал зардалд нийт 37.6 тэр бум төгрөгийг зарцуулаад байна. Үүнд: Хөрөнгө оруулалтад 34.8 тэрбум төгрөг, урсгал зардалд 2.8 тэрбум төгрөг тус тус зарцуулсан болно.

Жич: Бүтээн байгуулалтын ажлын гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөх урьдчилгаа төлбөр болох нийт гэрээний үнийн дүнгийн 20 хувь буюу 160.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Зээлийн хөрөнгөөс олгосон.

Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд

Зам тээврийн сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 60.4 хувьтай гарсан байна.

Хүснэгт 58. ҮХААЯ-ны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Үйлдвэр хөдөө аж ахуйн яам	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
836 - Зах зээл ба бэлчээрийн менежментийн удирдлага	3,291.83	1,987.61	60.4
MON-P7 - Хувийн хэвшлийг хөгжүүлэх		0.47	
Дүн	**3,291.83**	**1,988.07**	**60.4**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

836 - Зах зээл ба бэлчээрийн менежментийн удирдлага – MON-P7 - Хувийн хэвшлийг хөгжүүлэх – Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл нь дууссан төсөл бөгөөд 2013 оны 1 дүгээр сард гарсан 30 мянган иентэй тэнцэх хэмжээний шимтгэлийг бүртгэсэн болно.

Хууль зүйн сайд

Зам тээврийн сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 14.0 хувьтай гарсан байна.

Хүснэгт 59. Хуул зүйн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Хууль зүйн сайд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
4493MOG - Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл	1,239.83	403.39	32.5
Дүн	**1,239.83**	**403.39**	**32.5**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь 4493MOG - Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл – Төлийн үйл ажиллагаа тайлант онд дууссантай холбоотой байна.

Эрүүл мэндийн сайд

Эрүүл мэндийн сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 0.0 хувьтай байна.

Хүснэгт 60. Эрүүл мэндийн яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Эрүүл мэндийн яам	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2932-MON(SF) - Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл	2,672.20		0.0%
China - Цахим эрүүл мэнд төсөл	11,033.20		0.0%
ITA-001 - Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах	6,433.33		0.0%
MON-8 - Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл	1,314.75		0.0%
Дүн	**21,453.48**	**0.00**	**0.0%**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

- 2932-MON(SF) - Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл – Тайлант хугацаанд төслийн олон улсын зөвлөхийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлсэн хэдий ч төслийн хөрөнгийг зарцуулах эрх бүхий этгээдүүдийн баталгаат гарын үсгийг албажуулан санхүүжүүлэгч талд хүргүүлээгүй тул төслийн хүрээнд санхүүжилт гараагүй болно. Зээлийн хэлэлцээрийг 2012 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдөр АХБ-тай зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурж, хэлэлцээр 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болж, ЭЗХЯ-аас төслийн тус төслийн баримт бичгийг Сангийн яаманд 2013 оны 8 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгч, төслийн гарын үсгийн баталгааг 2014 оны эхний улиралд хүргүүлсэн.
- China - Цахим эрүүл мэнд төсөл – Төслийг хэрэгжүүлэх тусгайлсан гэрээ хийгдээгүйн улмаас тайлант онд төсөл хэрэгжиж эхлээгүй байна.
- ITA-001 - Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах – Зээлийн гэрээ байгуулагдаагүйн улмаас тайлант онд төсөл хэрэгжиж эхлэх боломжгүй болсон.
- MON-8 - Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл – Төслийн зээлийн гэрээ 2012 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болж төслийн хүрээнд 2013 онд 1,3 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалт гарахаар төлөвлөгдсөн боловч уг ашиглалт дараах шалтгааны улмаас гараагүй болно. Үүнд:
  - Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбогдон Төсөл хэрэгжүүлэх нэгжийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.
  - Төслийн хүрээнд ажиллуулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 сарын 22-нд эхлүүлсэн ч БНСУ-ын Эксим банкны процедурын дагуу холбогдох зөвшөөрлүүдийг банкнаас авахад ихээхэн хугацаа орж, үүнтэй холбогдуулан зөвлөх компанитай 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гэрээ байгуулсан.

Эрчим хүчний сайд

Эрүүл мэндийн сайдын багцад 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 87.0 хувьтай байна.

Хүснэгт 61. Эрчим хүчний яамны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Эрчим хүчний яам	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
200066183 - Эрчим хүчний салбарын хөтөлбөр I		55.06	
200665828 - Дарханы дулааны цахилгаан станцын турбин шинэчлэх төсөл	9,195.46	3,657.77	39.8%
201065424 - Эрчим хүчний үр ашиг төсөл		2,637.85	
4673-MON(SF) - Эрчим хүчний төсөл нэмэлт санхүүжилт	3,137.81	3,795.61	121.0%
579 - Тайширын УЦС		586.14	
Дүн	**12,333.27**	**10,146.29**	**87.0%**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

- 200066183 - Эрчим хүчний салбарын хөтөлбөр I
- 200665828 - Дарханы дулааны цахилгаан станцын турбин шинэчлэх төсөл – Уг төслийн хүрээнд 2013 онд төлөвлөсөн ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд тайлант оны сүүлээр гарсан ашиглалтын баримт донор байгууллагаас ирээгүйгээс гүйцэтгэлийг бүртгэлд тусгаагүй болно.
- 201065424 - Эрчим хүчний үр ашиг төсөл – Уг төсөл нь 2013 оны 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд төслийн хүрээнд тайланд онд гүйцэтгэх төлөвлөгөөт ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.
- 4673-MON(SF) - Эрчим хүчний төсөл нэмэлт санхүүжилт – Уг төсөл нь тайлант онд дууссан бөгөөд үлдэгдэл санхүүжилтийг бүрэн гаргасан байна.
- 579 - Тайширын УЦС – Төслийн хүрээнд хийгдэх ажлууд бүрэн хийгдэж дууссан бөгөөд үлдэгдэл санхүүжилтийг тайланд онд авсан байна.

Орон нутгийн засаг захиргаа

Орон нутгийн захиргаанд 2013 онд тусгагдсан гадаад зээлийн ашиглалтын гүйцэтгэл 18.4 хувьтай байна.

Хүснэгт 62. Орон нутгийн захиргааны гадаад зээлийн ашиглалт, сая төгрөг

Төсөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
5039MOG -Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл	4,461.70	3,590.40	80.5
China - Замын цагдаагийн газрын ойролцоох уулзвар ба төмөр зам дээрх гүүрэн гарц төсөл	14,988.06		0.0
FR-002 - Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл	279.04	32.04	11.5
Дүн	**19,728.79**	**3,622.44**	**18.4**

Тус багцад хэрэгжсэн төслүүдийн гадаад зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү нь дараах шалтгаантай холбоотой байна.

- 5039MOG -Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл – Уг төслийн хүрээнд 2013 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Зуух туршилт, хөгжлийн төвийг сайжруулах, хөгжүүлэх техникийн туслалцаа, хөгжлийн төсвийн тоног төхөөрөмж суурьлуулах, тохиргоо хийх
- Дүүргийн ногоон байгууламжийг сайжруулах,
- Сурталчилгааны үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх зөвлөх ажил,
- Дулааны шугам сүлжээг сайжруулах зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөний биелэлт 80.5 хувьтай гүйцэтгэсэн нь шаардлагатай тоног төхөөрөмж ирэх хугацаа хоцорсноос 1 удаагийн төлбөр он дамжсан сантай холбоотой байна.

- China - Замын цагдаагийн газрын ойролцоох уулзвар ба төмөр зам дээрх гүүрэн гарц төсөл – Төслийн тусгайлан байгуулах гэрээ байгуулагдаагүй тул тайланд онд төсөл хэрэгжиж эхлэх боломжгүй болсон.
- FR-002 - Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл – Зээлийн хөрөнгийг Орхон аймгийн Засаг даргын тамгын газарт дамжуулан зээлдүүлэх зорилгоор Монгол Улсын Сангийн яам, Орхон аймгийн Засаг даргын тамгын газар хооронд Дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Засгийн газар хоорондын Санхүүгийн протоколд зээлийг БНФУ-ын компаниудаар гүйцэтгүүлэхээр заасанчлан Орхон аймгийн Засаг даргын тамгын газар нь БНФУ-ын Дегремон С.А компанитай 8.7 сая еврогийн үнийн дүн бүхий төслийн гүйцэтгэлийн гэрээг 2009 оны 6 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан. Зээлийн хөрөнгөөс 6.9 сая еврог тус байгууламжийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулах бөгөөд үлдсэн хөрөнгөөр гүйцэтгэгч компани байгууламжийн засвар арчилгааг байгууламжийг хүлээлгэж өгсөнөөс хойш 2 жилийн хугацаанд хариуцах, тоног төхөөрөмжийг ашиглах сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд зарцуулах юм. Дегремон компаний үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор БНФУ-ын Засгийн газраас BCEOM International компанийг төслийн техник туслалцааны багаар сонгон шалгаруулсан. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газраас BCEOM International компанитай 601.7 мянган еврогийн үнийн дүн бүхий Техник туслалцааны гэрээг 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр байгуулан төслийн үйл ажиллагаа эхэлж, тоног төхөөрөмжөө нийлүүлээд байна.

Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер 2013 оны 3-р сард зарлагдаж тендерт “Ар дааган “ХХК, Байгууламж ХХК, Хангилцаг ХХК-ийн түншлэл шалгарч 2013 оны 8-р сарын 6-ны өдрөөс барилга угсралтын ажил эхэлсэн. 2013 онд дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд :

- Барилга байгууламжийн 0,00 түвшин хүртэлх газар шорооны ажил;
- Талбайд байгаа инженерийн шугам сүлжээг зөөх / цэвэр бохир усны шугам/;
- Гадна дулааны шугамын ажил, дулааны төвийн барилга;
- Цахилгааны дэд өртөөний барилга;
- Агаар үлээгчийн барилга;
- Лаг усгүйжүүлэх байгууламжийн барилга зэрэг байгууламжуудын ажил хийгдэж байна.

7.4. УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилт /Чингис бонд/

Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5 тэрбум хүртэлх ам.долларын Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрсөн билээ.

Энэхүү тогтоолын дагуу Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан 1.5 тэрбум ам.долларын Чингис бондын эх үүсвэрээс Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн хөтөлбөр болон салбарын бодлогын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкнаас Засгийн газрын холбогдох тогтоолуудаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэргжилтэнд 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 735.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Чингис бондын эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг танилцуулга:

Авто зам:

Орон нутгийн авто замын төслийн хувьд 2013 онд шинээр хэрэгжих зам барилгын 10 ажил, он дамжин хэрэгжиж буй зам барилгын 14 ажил ба тэдгээрийн хяналтын зөвлөх үйлчилгээнд зориулан 570.0 хүртэл тэрбум төгрөгийг Чингис бондын хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр Засгийн газрын 2012оны 96, 124 дүгээр тогтоолоор баталсан болно. Дээрх Засгийн газрын тогтоолын дагуу Хөгжлийн банкнаас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МУХБ 350.1 тэрбум төгрөгийг авто замын салбарт зориулан санхүүжүүлсэн байна.

Эдгээр авто замын төслүүд хэрэгжсэнээр Дундговь, Өмнөговь, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод, Баянхонгор аймгууд нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбогдоно. Чингис бондын санхүүжилтээр нийт 1,800 км зам баригдахаас 930 км-ийг бүрэн хучиж дуусган (үүнээс 2013 онд 620 гаруй км зам шинээр), ойролцоогоор 150 км-ийн суурийн ажил хийгдэж, хучилт хийхэд бэлэн болоод байна. Нийт зам барилгын ажлын гүйцэтгэлийн дундаж нь 68 хувь байна.

Гудамж төсөл:

Улаанбаатар хотын авто замын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, хот төлөвлөлтийг сайжруулах зорилгоор “Гудамж” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 81 дүгээр тогтоол баталагдсан. Дээрх тогтоолын дагуу МУХБ-аас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 47.9 тэрбум төгрөгийг олгосон байгаа бөгөөд цаашид 279.1 тэрбум төгрөгийн санхүүжилт дутуу байна. Уг төслийн хүрээнд Туул, Сэлбэ голын дагуу хурдны замыг барьж, 33 уулзварыг шинэчлэх, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах ажлууд хийгдэх төлөвлөгөөтэй. Гудамж төслөөс хийгдэх ажлын дундаж гүйцэтгэл 92.6 хувьтай байна.

Дэд бүтэц:

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт баригдах орон сууцны хотхон, хороолол, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээ сайжруулах зорилгоор Засгийн газрын 2013 оны 118, 285, 386 болон 2014 оны 114 дүгээр тогтоол (*2014.04.04-нд батлагдсан*) оор нийт 466.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 95 төслийг 2013, 2014 онд хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс МУХБ эхний ээлжинд эх үүсвэр нь тодорхой 200 тэрбум хүртэлх төгрөгийн санхүүжилтийг төслүүдэд олгохоос 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 93.0 тэрбум төгрөгийг олгоод байна. Гэрээ байгуулсан 33 ажлын гүйцэтгэлийн дундаж хувь: 72.2 хувьтай байна.

Шинэ төмөр зам:

Уг төслийн хүрээнд Тавантолгой - Сайншанд - Чойбалсан, Тавантолгой - Гашуун Сухайт чиглэлийн нийт 1800 км төмөр зам баригдана. Төслийг “Монголын Төмөр Зам” ТӨХК удирдан зохион байгуулж, "Шинэ төмөр зам" ХХК төслийн компани хэрэгжүүлж байна. Уг төслийн санхүүжилтэд Чингис бондын хөрөнгөөс 156.1 сая ам.доллар буюу 241.0 тэрбум төгрөгийг Ухаа Худаг-Гашуун Сухайт чиглэлийн төмөр замын дээд, доод бүтцийн барилгын ажил, төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд зориулан олгоод байна.

Чингис бондын санхүүжүүжилтээр нийт 267 км шинэ төмөр замын барилгын ажлыг санхүүжүүлж буй бөгөөд уг төмөр замыг 2015 оны 10 сард ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Барилгын гол ажил нь 2 өртөө, 5 зөрлөг, 16 гүүр, 132 малын гарц, хоолой барих ажлаас бүрдэнэ. Урьдчилсан ТЭЗҮ-н дагуу төсөлд 700,0 сая ам.долларын санхүүжилт шаардлагатай байгаагаас Чингис бондын хөрөнгөөс 200,0 сая ам.долларын санхүүжилт олгохоор шийдвэр гарсан.

Нийт 267 км төмөр замын барилгын ажлын гүйцэтгэл 25 хувь, газар шорооны ажил 70 хувь, ухмал 77 хувь, далан 62 хувьтай байна, Трассыг нийт 13 хэсэгт хуваасан бөгөөд барилгын ажлыг дотоодын 14 авто замын компани гүйцэтгэж байна.

Таван толгойн цахилгаан станц:

Засгийн газрын 2013 оны 80, 261 дүгээр тогтоолуудад Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц барих төслийн эхний ээлжийн санхүүжилтэнд зориулан Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн эх үүсвэрээс 16 сая ам.долларын санхүүжилтийг давуу эрхийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй мезанин зээл хэлбэрээр олгохоор заасны дагуу төслийн бэлтгэл ажилд нийт 15.98 сая ам.долларын санхүүжилтийг олгохоор баталсан билээ.

Чингис бондын эх үүсвэрээс МУХБ-аас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төслийн нэгжийн 2013-2014 оны үйл ажиллагааны зардал болон төслийн бэлтгэл ажилд зориулж 1.9 сая ам.долларын санхүүжилтийг олгоод байна.

Эгийн голын усан цахилгаан станц:

Засгийн газрын 2013 оны 375 дугаар тогтоолоор Эгийн голын усан цахилгаан станцын төсөлд 34 сая ам.долларыг Засгийн газрын үнэт цаасны эх үүсвэрээс МУХБ-аар дамжуулан санхүүжүүлт олгохоор шийдвэрлэсэн.

Төслийн удирдах хорооноос баталсан төлөвлөгөө болон Эдийн засгийн хөгжлийн яамнаас баталсан төсвийн дагуу 7.38 сая ам.долларын санхүүжилтийг олгохоор баталснаас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаах Чингис бондын эх үүсвэрээс 0.5 сая ам.долларын санхүүжилтийг олгосон байна.

7.5. УИХ-ын 2011 оны 15 дугаар тогтоолын хэрэгжилт /МУХБ-ны бонд/

Улсын Их Хурлын "Зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох тухай" 2011 оны 14 дүгээр тогтоол, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2011 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн "Үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргах тухай" Засгийн газрын 2011 оны 85 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 322 дугаар тогтоолоор МУХБ-ны санхүүгийн эх үүсвэрийг нь бүрдүүлэхэд зориулан МУХБ-ны 600.0 сая ам.долларын үнэт цаас гаргахыг тус банкинд зөвшөөрч, уг үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт Засгийн газрын баталгаа гаргахыг Сангийн сайдад зөвшөөрсөн.

Энэхүү Монгол Улсын Засгийн газрын баталгаа бүхий МУХБ-ны 20.0 сая ам.долларын, жилийн 6 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай үнэт цаасыг хаалттай хэлбэрээр 2011 оны 12 дугаар сарын 9-ний өдөр, 580.0 сая ам.долларын, жилийн 5.75 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдөр тус тус олон улсын зах зээлд арилжаалсан.

Дээр дурдсан МУХБ-ны эх үүсвэрээс 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 8 салбарын 80 дэд төсөл хөтөлбөрүүдэд 548.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсөл хөтөлбөрүүдийг салбараар ангилж үзвэл:

Авто зам болон дэд бүтэц:

Хөдөө орон нутгийн 32 зам, хот доторх 38 замыг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр МУХБ-аас санхүүжүүлсэн бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 82.2 тэрбум төгрөгийг авто замын төслүүдэд олгосон байна.

Баянголын амны дулааны хангамжийн IV ээлжийн барилга угсралтын ажил болон 4200 м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн ажилд зориулан МУХБ-аас 2.0 тэрбум төгрөгийг олгосон байна.

Монголын Төмөр зам:

Шинэ төмөр зам төслийн санхүүжилтийн тухай Засгийн газрын 2011 оны 266 дугаар тогтоолын хүрээнд "Шинэ төмөр зам төсөл"-ийг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд шаардагдах 55.0 (тавин таван) сая ам.долларын санхүүжилтийг шийдвэрлэхийг даалгасны дагуу МУХБ-аас 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 22.5 сая ам.долларын санхүүжилт буюу 31.4 тэрбум төгрөгийн өөрийн эх үүсвэрээс олгосон байна.

Сайншанд АҮЦ ХХК:

Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалтыг эхлүүлэх тухай Засгийн газрын 2013 оны 76 дугаар тогтоолын хүрээнд 14.2 тэрбум төгрөгийг МУХБ-аас санхүүжүүлэхийг даалгасны дагуу Хөгжлийн банкнаас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3.3 тэрбум төгрөгийг олгосон байна.

Төрийн банкны 6%-ийн моргэйжийн зээл:

"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол, "Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2011оны 138 дугаар тогтоолын дагуу Засгийн газраас хэрэгжүүлж буй жилийн 6 хувийн хүүтэй орон сууцны зээлэнд МУХБ-ны эх үүсвэрээс 80.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Дулааны цахилгаан станц:

Засгийн газрын 2012 оны 99 болон 119 дүгээр тогтоолоор батлагдсан Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг санхүүжүүлэх МУХБ-аас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 62.6 тэрбум төгрөгийг олгосон байна.

Жижиг дунд үйлдвэр:

Улсын Их Хурлын 2011 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 15 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны "Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 138, 208 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн арга хэмжээний санхүүжилтэд МУХБ-аас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 34.4 тэрбум төгрөгийг олгосон байна.

Дулааны III цахилгаан станц:

Засгийн газрын 2013 оны 142 дугаар тогтоолын дагуу "Дулааны III цахилгаан станц" ТӨХК-д 50 МВт-ын турбин суурилуулах ажлын гэрээг түлхүүр гардуулах нөхцлөөр байгуулж, тайлант хугацаанд барилгын ажилд зориулж 44.4 тэрбум төгрөгийг МУХБ-аас олгоод байна.

Хавсралт 1.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГАА ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨӨР ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГЭЭР ХИЙГДСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ /НЭГТГЭЛ ХҮСНЭГТ/

ЧИНГИС БОНДЫН ЭХ ҮҮСВЭРЭЭС 2013 ОНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭ

/сая ам.доллар, тэрбум төгрөг/

д/д	Төсөл хөтөлбөрийн нэр	Тогтоолоорх нийт төсөвт өртөг			2012 оны олголт			2013 оны олголт			2013.12.31-ний өдрийн байдлаар цаашид олгох санхүүжилтийн дүн		
		Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)
1	Авто зам	570.0	-	570.0	-	-	-	350.1	-	350.1	219.9	-	219.9
2	Гудамж	314.0	7.9	327.0	-	-	-	44.8	1.9	47.9	269.2	6.0	279.1
3	Дэд бүтэц	416.8	-	416.8	-	-	-	93.0	-	93.0	323.7	-	323.7
4	Таван толгойн цахилгаан станц	-	16.0	25.7	-	-	-	-	1.9	2.7	-	14.1	23.0
5	Эгийн голын усан цахилгаан станц	-	34.0	55.7	-	-	-	-	0.5	0.8	-	33.5	54.8
6	Шинэ төмөр зам	-	200.0	312.7	-	-	-	-	156.1	241.0	-	43.9	71.7
	НИЙТ	**1,300.8**	**257.9**	**1,707.9**	**-**	**-**	**-**	**488.0**	**160.4**	**735.6**	**812.8**	**97.5**	**972.3**

ТАЙЛБАР:

1. Олгосон зээлийн нийт дүнг төгрөгөөр илэрхийлэхдээ олголт хийсэн тухайн өдрийн ам.долларын албан ханшийг ашигласан болно.
2. "Гудамж" төслийн санхүүжилт ам.доллараар батлагдсан боловч гүйцэтгэлээр төсөвт өртөг нь төгрөгөөр гарч байгаа тул тогтоолоор батлагдсан төсөвт өртгийг төгрөгөөр оруулав.
3. Дэд бүтцийн төслүүдийн нийт өртөг 416.776 тэрбум төгрөгөөр батлагдсан боловч санхүүжилт нь 200.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төсөвт өртөгт нийт өртгөөр оруулсан болно.
4. 1,300.8 тэрбум төгрөгийн тогтоолоор баталсан өртгөөс 216.776 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байгаа болно.
5. 973.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийн 216.776 тэрбум төгрөгийн эх үүсвэр тодорхогүй байгаа болно.
6. "Гүйцэтгэгч" баганын өнгөөр тэмдэглэсэн төслүүдийн гүйцэтгэгчийг захиалагч сонгон шалгаруулаагүй байгаа эсхүл захиалагч хэрэгжүүлээгүй байгаа болно.

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭС 2012 БОЛОН 2013 ОНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭ

д/д	Төсөл хөтөлбөрийн нэр	Тогтоолоорх нийт төсөвт өртөг			2012 оны олголт			2013 оны олголт			2013.12.31-ний өдрийн байдлаар цаашид олгох санхүүжилтийн дүн		
		Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)
1	Авто зам	400.7	-	400.7	8.9	139.5	202.5	-	53.6	82.2	-	87.3	116.0
2	Дэд бүтэц	3.4	-	3.4	-	0.3	0.4	-	1.3	2.0	-	0.7	0.9
3	Төрийн банкны 6%-ийн моргэйж	80.0	-	80.0	-	36.9	50.0	-	21.5	30.0	-	-	-
4	ТЭЦ-4 хүчин чадал нэмэгдүүлэх	-	70.0	111.6	-	2.0	2.8	-	42.1	62.6	-	27.9	46.2
5	ТЭЦ-3 хүчин чадал нэмэгдүүлэх	-	35.0	56.0	-	-	-	-	28.0	44.4	-	7.0	11.6
6	МТЗ 55 сая санхүүжилт	-	55.0	85.1	-	-	-	-	22.5	31.4	-	32.5	53.7
7	Сайншанд АҮЦ ХХК	14.2	-	14.2	-	-	-	3.3	-	3.3	10.8	-	10.8
8	Жижиг дунд үйлдвэр	50.0	-	50.0	2.1	-	2.1	34.4	-	34.4	13.5	-	13.5
	НИЙТ	**548.3**	**160.0**	**801.0**	**10.9**	**178.7**	**257.8**	**37.8**	**169.0**	**290.4**	**24.4**	**155.4**	**252.8**

ТАЙЛБАР:

1. Авто зам, дэд бүтэц, Төрийн банкны 6%-ийн зээлийн хувьд зээлийн үлдэгдэл санхүүжилтийг төгрөгөөр илэрхийлэхдээ холбогдох гэрээний дагуу төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг 1329.68 төгрөгөөр тооцов.
2. Бусад зээлийг төгрөгөөр илэрхийлэхдээ төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг 2013.12.31-ний өдрийн албан ханш болох 1654.1 төгрөгөөр тооцов.
3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төслийн зээлийн хүүгийн төлбөр болон ханшийн алдагдлын төлбөр нь улсын төсвөөс эргэн төлөгддөг.

Хавсралт 2. Чингис бондын эх үүсвэрээс 2013 онд олгосон санхүүжилтийн мэдээ

/сая ам.доллар, тэрбум төгрөг/

д/д	Төсөл хөтөлбөрийн нэр	Төрөл ангилал	Гүйцэтгэсэн аж ахуй нэгж	Гэрээний захиалагчтал	Хөрөнгө өмчлөгч	Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийн хувь	Тогтоолоорх нийт төсөвт өртөг			2013 оны олголт			2013.12.31-ний өдрийн байдлаар санхүүжилтийн үлдэгдэл		
							Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)
1	Мандалговь - Даланзадгад 83 км ЧБ	Авто зам	Ялгуусан ХХК	ЗТЯ	ЗТЯ	56.7%	41.5	-	41.5	15.8	-	15.8	25.7	-	25.7
2	Мөрөн-Тариалан чиглэлийн авто зам 32 км	Авто зам	Хотгор Зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	40.0%	17.1	-	17.1	10.6	-	10.6	6.6	-	6.6
3	Мөрөн-Тариалан чиглэлийн авто зам 25 км	Авто зам	Их Монгол Барилга ХХК, Хурдны зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	38.0%	13.1	-	13.1	6.2	-	6.2	6.9	-	6.9
4	Мөрөн-Тариалан чиглэлийн авто зам 29.3 км	Авто зам	Пик Девелопмент ХХК	ЗТЯ	ЗТЯ	86.0%	15.4	-	15.4	12.5	-	12.5	2.9	-	2.9
5	Өндөрхаан Чойбалсан чиглэлийн авто зам 30 км	Авто зам	Насны зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	51.8%	15.8	-	15.8	10.4	-	10.4	5.3	-	5.3
6	Өндөрхаан Чойбалсан чиглэлийн авто зам 27 км	Авто зам	Хансуун зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	49.1%	14.3	-	14.3	8.8	-	8.8	5.5	-	5.5
7	Өндөрхаан Чойбалсан чиглэлийн авто зам 27.75 км	Авто зам	Гашууны гол ХХК	ЗТЯ	ЗТЯ	49.4%	14.7	-	14.7	7.4	-	7.4	7.4	-	7.4
8	Өндөрхаан Чойбалсан чиглэлийн авто зам 10.65 км	Авто зам	ЗЗБ ХХК, Нейшнл девелопер ХХК Эвт уул ХХК,БСМ ХХК	ЗТЯ	ЗТЯ	51.2%	5.8	-	5.8	3.5	-	3.5	2.3	-	2.3
9	Өндөрхаан Чойбалсан 94 КМ АВТО ЗАМ	Авто зам	Насны зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	0.0%	1.4	-	1.4	1.4	-	1.4	-	-	-
10	Мандалговь Даланзадгад чиглэлийн авто зам 25 км	Авто зам	Мадимос ХХК, Наранбулаг хан ХХК	ЗТЯ	ЗТЯ	60.4%	13.3	-	13.3	6.9	-	6.9	6.3	-	6.3
11	Мандалговь Даланзадгад чиглэлийн авто зам 25 км	Авто зам	Эсто ХХК	ЗТЯ	ЗТЯ	60.4%	13.3	-	13.3	7.9	-	7.9	5.3	-	5.3
12	Халзанбургэдэй - Солонготын даваа чиглэлийн 100 км ЧБ	Авто зам	Монроуд ХХК	ЗТЯ	ЗТЯ	0.0%	23.2	-	23.2	13.9	-	13.9	9.3	-	9.3
13	Улаангом - Хяргас нуур чиглэлийн 15 км ЧБ	Авто зам	Шинжиан Шинфа ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	7.0	-	7.0	6.3	-	6.3	0.7	-	0.7
14	Өндөрхаан - Чойбалсан чиглэлийн 143 км ЧБ	Авто зам	Насны зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	73.0%	38.6	-	38.6	11.2	-	11.2	27.4	-	27.4
15	Манхан - Дарви чиглэлийн 100 км ЧБ	Авто зам	Алтайн зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	98.0%	21.5	-	21.5	17.1	-	17.1	4.4	-	4.4
16	Арвайхээр - Баянхонгор чиглэлийн 57 км ЧБ	Авто зам	Шинжан Бэйшин ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	12.0	-	12.0	11.1	-	11.1	0.9	-	0.9
17	Арвайхээр - Баянхонгор чиглэлийн 50 км ЧБ	Авто зам	Нэйшнл Девелопер ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	10.7	-	10.7	10.5	-	10.5	0.2	-	0.2
18	Улаангом - Хяргас нуур чиглэлийн 85 км ЧБ	Авто зам	Шинжан Шинфа ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	30.4	-	30.4	26.6	-	26.6	3.8	-	3.8
19	Тариалан - Мөрөн 79 км ЧБ	Авто зам	Эйч Кэй Би ХХК, Тум арвжих ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	29.3	-	29.3	22.4	-	22.4	6.9	-	6.9
20	Тосонцэнгэл - Улиастай 67 км ЧБ	Авто зам	Тэнгэр Уул ХХК	ЗТЯ	ЗТЯ	50.0%	27.1	-	27.1	6.1	-	6.1	21.0	-	21.0
21	Өндөрхаан-Мөнххаан-Баруун Урт 132.6 км ЧБ	Авто зам	Арж Капитал ХХК	ЗТЯ	ЗТЯ	34.4%	31.4	-	31.4	17.9	-	17.9	13.5	-	13.5

д/д	Төсөл хөтөлбөрийн нэр	Төрөл ангилал	Гүйцэтгэсэн аж ахуй нэгж	Гэрээний захиалагч тал	Хөрөнгө өмчлөгч	Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийн хувь	Тогтоолоорх нийт төсөвт өртөг			2013 оны олголт			2013.12.31-ний өдрийн байдлаар санхүүжилтийн үлдэгдэл		
							Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)	Төгрөг	ам.доллар	нийт (төгрөг)
22	УЛААНГОМ-НАРАНБУЛАГ 90 КМ АВТО ЗАМЫН БАРИЛГА	Авто зам	Шинжан Шинфа ХХК	ЗТЯ	ЗТЯ	71.2%	29.3	-	29.3	13.4	-	13.4	15.9	-	15.9
23	Цахир-Тосонцэнгэл 127.1 км ЧБ	Авто зам	Хурдны зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	16.0%	13.2	-	13.2	3.1	-	3.1	10.1	-	10.1
24	Өндөрхаан-Мөнххаан-Баруун Урт 45.3 км ЧБ	Авто зам	Түм Арвжих ХХК	ЗТЯ	ЗТЯ	49.7%	10.8	-	10.8	10.6	-	10.6	0.1	-	0.1
25	Улаанбаатар-Мандалговь 104 км ЧБ	Авто зам	Монголын хурдны зам ХХК, Жэй Кей Си ХХК, Шинжан Жэнгун Житуа ХХК, Мотор Сервис ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	36.3	-	36.3	24.7	-	24.7	11.6	-	11.6
26	Баянхонгор - Алтай чиглэлийн 128 км ЧБ	Авто зам	Шинжан Шинфа ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	27.2	-	27.2	21.7	-	21.7	5.5	-	5.5
27	Мандалговь - Даланзадгад чиглэлийн 163 км ЧБ	Авто зам	Шинжиан констракшн инженеринг групп ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	34.6	-	34.6	31.4	-	31.4	3.3	-	3.3
28	Мандалговь - Даланзадгад 83 км хяналт	Авто зам	Эс Ар Пи ХХК	ЗТЯ	ЗТЯ	0.0%	2.0	-	2.0	1.1	-	1.1	0.9	-	0.9
29	Тосонцэнгэл - Улиастай 67 км хяналт	Авто зам	Гендай инженеринг ХХК	ЗТЯ	ЗТЯ	50.0%	2.1	-	2.1	1.2	-	1.2	0.8	-	0.8
30	Улаанбаатар-Мандалговь 104км хяналт	Авто зам	Эс Ар Пи ХХК	ЗТЯ	ЗТЯ	100.0%	2.5	-	2.5	1.8	-	1.8	0.7	-	0.7
31	Мөрөн-Тариалан чиглэлийн авто зам хяналт 32 км	Авто зам	Ростов ХХК	ЗТЯ	ЗТЯ	40.0%	0.5	-	0.5	0.3	-	0.3	0.2	-	0.2
32	Мөрөн-Тариалан чиглэлийн авто зам хяналт 25 км	Авто зам	Эм Ай Эл ХХК	ЗТЯ	ЗТЯ	38.0%	0.4	-	0.4	0.2	-	0.2	0.2	-	0.2
33	Мөрөн-Тариалан чиглэлийн авто зам хяналт 29.3 км	Авто зам	Мөнхөд Ашдын Зам ХХК	ЗТЯ	ЗТЯ	86.0%	0.5	-	0.5	0.3	-	0.3	0.1	-	0.1
